



5

ТОГТВОРЖИЛТЫН САН БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Гүйцэтгэсэн: Б.Тэмүүжин⁹

Түлхүүр үгс, JEL ангилал: *Stabilization E63, Insurance G22*

⁹ СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт email: temuujin@frc.mn

| | | |
|-----|---|-----|
| I. | ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН | 151 |
| | 1.1. Удиртгал | 151 |
| | 1.2. Зээлийн хоршоодын бүтэлгүйтлийн шалтгаан, тогтворжуулалтын ач холбогдол | 152 |
| | 1.3. Тогтворжуулалтын үндсэн зарчим | 158 |
| | 1.4. Тогтворжуулах олон улсын хандлага | 165 |
| | 1.4.1. Канадын Зээлийн хоршоодын хадгаламжийн баталгааны корпорац | 166 |
| | 1.4.2. АНУ–ын Үндэсний Зээлийн Хоршооны Даатгалын Сан | 172 |
| | 1.5. Тогтворжуулах үйл ажиллагааны төсөв, санхүүжилт | 182 |
| | 1.6. Дүгнэлт | 186 |
| | 1.7. Санал, зөвлөмж | 187 |
| II. | ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА | 193 |
| | 2.1. Удиртгал | 193 |
| | 2.2. Дэлхийн улс орнуудын хадгаламжийн даатгалын нөхцөл байдал | 196 |
| | 2.3. Хадгаламжийн даатгалын загварчлал | 199 |
| | 2.4. Хадгаламжийн даатгалын онолын бөгөөд эмпирик баримт | 202 |
| | 2.5. Дүгнэлт болон бодлогын санал | 210 |
| | ЭХ СУРВАЛЖ | 213 |
| | ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | |
| | Хүснэгт 1: WOCSCU–гаас санал болгосон зохистой харьцааны PEARLS үзүүлэлт | 190 |
| | Хүснэгт 2: Дотоодын ХЗХ–дын сангуудын үзүүлэлт | 192 |
| | Хүснэгт 3: Хадгаламжийн даатгалын загварыг улс орнуудаар харьцуулалт | 196 |
| | Зураг 1. 1934–1999 он хүртэл хугацаанд депозитын даатгалыг нэвтрүүлсэн улс орнууд | 199 |

I. ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

1.1. УДИРТГАЛ

Дэлхийн олон оронд дан зээлийн хоршоодын санал хүсэлтийн дагуу эсвэл Засгийн газрын зохицуулагчийн ивээл дор зээлийн хоршоодын аюулгүй байдал, найдвартай байдлыг хангах замаар гишүүдийн хадгаламжийг хамгаалах зорилготой тогтворжуулалтын сан, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Эдгээр тогтворжуулалтын хөтөлбөрүүд нь хадгаламжийг хамгаалах тогтолцоо схемтэй холбоотой боловч Их Британийн FSCS-ээс ялгаатай нь үндсэндээ татан буугдсан зээлийн хоршоодын хадгаламж эзэмшигчдэд нөхөн олговор олгох зорилгоор байгуулагдаагүй байдаг. Зээлийн хоршоо бүтэлгүйтэж, санхүүгийн хүндрэлд автсаны дараа түүнийг аврахын тулд л эдгээр хөндлөнгийн оролцоо байгаа биш юм. Тогтворжуулалт нь тодорхойлолтоор стратегийн, цогц нэгдмэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм. Тогтворжуулалтын хөтөлбөрүүд нь зээлийн хоршоодын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тэдэнд хүндрэлтэй үед нь туслах зорилготой бөгөөд, харин эхлээд тэднийг хөтөлбөрийн хүрээнд бизнесийн болон санхүүгийн тогтвортой стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хянан баталгаажуулж, албадан хөөн гаргах

хүртэлх шийтгэл ногдуулах хүртэлх арга замаар хэрэгжүүлдэг.

Олон улсын хэмжээнд үндэсний зээлийн хоршоодын тогтворжуулах хөтөлбөрүүдийн үр нөлөө хангалттай сайн байжээ. Тогтворжуулах хөтөлбөр хаана ч хэрэгжиж болох ба зээлийн хоршооны бүтэлгүйтэл нь гишүүдийн хуримтлалыг нөхөн олговрын сангаас төлөх шаардлагатай болгодог ч энэ нь маш ховор тохиолддог. Залруулах арга хэмжээ нь зээлийн хоршоог төлбөрийн чадваргүй гэж /дефолт зарлахаас/ зарлахаас өмнө бүтэлгүйтлийг таслан зогсоодог. Мэдээжээр ийм арга хэмжээ нь төлбөрийн чадвартай бусад зээлийн хоршоодыг нэгтгэх эсвэл бүр хаагдахад хүргэж болзошгүй юм. Хүрсэн ахиц дэвшлийг үл харгалзан олонх нь сайн дурынхан удирддаг жижиг хоршоодтой зах зээлд тогтвортой тогтворжуулах хөтөлбөрийг олон улсын зарчмын дагуу хэрэгжүүлбэл олон зээлийн хоршоодын үйл ажиллагааг шууд зогсоох магадлалтай. Олон улсын хэмжээнд зээлийн хоршоодын амжилт нь тогтворжуулах хөтөлбөрөөс ихээхэн хамааралтай байдаг. Энэ нь, дэлхий даяар шинээр гарч ирж буй олон зээлийн хоршоодын тогтвортой байдлын гол хүчин зүйл юм.



1.2. ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН БҮТЭЛГҮЙТЛИЙН ШАЛТГААН, ТОГТВОРЖУУЛАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ

Хямралтай зээлийн хоршоодыг тогтворжуулах хөтөлбөр, санаачилга нь зээлийн хоршоо хэрхэн, яагаад санхүүгийн хүндрэлд орж, эцэст нь бүтэлгүйтдэг тухай тодорхой ойлголтоос шалтгаална. FSA, FSCS, DWP-тэй хийсэн зөвлөгөөн нь бүтэлгүйтлийн динамикийг тодруулах, тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд анхаарах гол чиглэлүүдийг тодорхойлох зорилготой байв. Эдгээр зөвлөгөөний үр дүнд бүтэлгүйтлийн дараах хэлбэрүүд үүсдэгийг тодорхойлсон.

Мэдээжийн хэрэг, гэрээ, хэлэлцээрийг шилжүүлдэг эсвэл бүрмөсөн хаадаг зээлийн хоршоод бүтэлгүйтсэн байх албагүй. Шилжүүлэх эсвэл хаах нь янз бүрийн шалтгааны улмаас тохиолдож болдог. Зээлийн хоршоод эдийн засгийн хэмнэлт гаргах, илүү өргөн, олон талт зах зээлд хүрэх эсвэл бусад стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд гэрээ, хэлэлцээрийг шилжүүлж болно.

Төлбөрийн чадвартай ч гэсэн зээлийн хоршоо нь тухайн байгууллагыг удирдах захирал, ажилтан байхгүй болсон, эсвэл хэрэгжих боломжтой нийтлэг хүлээсэн үүрэг байхгүй болсон эсвэл зээлийн хоршооны анхны зорилго арилсан эсвэл үгүй болсон бол сайн дураараа хаагдаж болно.

Үүнтэй холбогдуулан зээлийн хоршооны дампуурал гэдэг нь тухайн байгууллага санхүүгийн алдагдал хүлээсний үр дүнд хадгаламж эзэмшигчид болон зээлдүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадваргүй болохыг хэлж байдаг. Амжилтгүй болсон зээлийн хоршоо гэдэг нь

тодорхойлолтоор нийт хөрөнгөөсөө илүү өр төлбөртэй бөгөөд төлбөрийн чадваргүй болсон байгууллагууд юм. Хөрөнгө нь идэвхгүй байх ч өр төлбөрөө төлөхөд хүрэлцэхгүй байх тул тэд төлбөрийн чадваргүй болно. Их Британид FSCS нь зээлийн хоршооны нэг гишүүнд ногдох 50,000 фунт стерлинг хүртэл хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох зохицуулалттай байдаг.

Ихэнх судалгаануудад зээлийн хоршооны дампуурлын шууд шалтгааныг санхүүгийн алдагдал гэж тодорхойлсон. Гэсэн хэдий ч энэ нь хэд хэдэн шалтгааны улмаас тохиолдож болох боловч санхүүгийн алдагдал нь ихэвчлэн хоёр үндсэн эх үүсвэрээс үүсдэг: зээлийн хугацаа хэтэрсэн, найдваргүй өр, мөн зарлагаа нөхөхөд хангалтгүй орлого бий болгосон шалтгаанууд юм.

* Зээлийн хугацаа хэтэрсэн, найдваргүй өр.

Зээлийн хугацаа хэтрэлт болон найдваргүй өр нь зээлийн хоршооны дампуурлын үндсэн шалтгаан гэж үздэг. Их Британид зээлийн хоршооны дампуурлын цаана нэг талаараа муу өрийн тохиолдол үргэлж холбоотой байдаг.

* Зардлаа нөхөх орлого хангалтгүй.

Хэрэв орлого хэт бага ба/эсвэл зарлага хэт өндөр байвал эргээд санхүүгийн алдагдал орно. Хангалттай ашиг авчирдаггүй зээлийн багц өсөхөд хяналтгүй зардал нь бүтэлгүйтэлд хүргэж болзошгүй юм.

Хэд хэдэн бүтэлгүйтлийн тохиолдлоос авч үзэхэд, гаднын татаас, буцалтгүй тусламж дуусаж байсан тул орлого нь багассан байсан. Санхүүжилтийн байгууллагуудын дэмжлэг

зогссон тохиолдолд буцалтгүй тусламжаас хамааралтай зээлийн холбоод бүтэлгүйтэх эрсдэл өндөр байдаг.

Зээлийн хоршоодын санхүүгийн алдагдал нь мөнгө завших, залилан мэхлэх зэргээс үүдэлтэй байж болно. Мэдээжийн хэрэг, Британийн зээлийн хоршоод хөрөнгө шамшигдуулах, залилан мэхлэх явдал зарим үед гарч байсан. Гэсэн хэдий ч FSA болон FSCS-ийн мэдээлснээр

эдгээр нь Британийн зээлийн хоршоодын санхүүгийн алдагдлын голлох чухал шалтгаан биш бөгөөд учрах аливаа хохирлыг ихэвчлэн даатгалд даатгадаг. Мэдээжээр, хөрөнгө шамшигдуулах, залилан мэхлэх нь зээлийн хоршооны найдвартай байдал, найдвартай санхүүгийн байгууллага болох олны итгэлийг алдагдуулж болзошгүй юм. Энэ нь олсон орлогоо алдахад хүргэж болзошгүй.

ЗЭЭЛИЙН ХОРШООД ЯАГААД БҮТЭЛГҮЙТДЭГ ВЭ?

Зээлийн хугацаа хэтрэлт, найдваргүй өр, орлого зардлаа нөхөхөд хүрэлцэхгүй байх нь санхүүгийн алдагдлын шууд эх үүсвэр болж төлбөрийн чадваргүй байдал болон дампууралд хүргэдэг. Гэсэн хэдий ч эдгээр нь өөрсдөө үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг олон тооны хүчин зүйлийн үр дагавар юм. Эдгээр нөлөөлөгч хүчин зүйлс, шалтгаануудын зарим нь зээлийн хоршоодын дотоод хүчин зүйлс байдаг бол зарим нь гадаад зах зээл, эдийн засгийн орчноос үүдэлтэй ч байж болно.

Хэлэлцүүлгийн үеэр санхүүгийн болон зохион байгуулалтын хүнд хэцүү байдалд орсон зээлийн хоршоодтой хэрхэн харьцах талаар FSA, FSCS болон DWP-ийн шууд туршлагад үндэслэн дараах шалтгаануудыг тодорхойлсон.

1/ Дотоод шалтгаанууд

Ерөнхийдөө Их Британийн зээлийн хоршоодын санхүүгийн алдагдлын хамгийн түгээмэл шалтгаан нь зээлийн хоршооны дотоод зохион байгуулалттай холбоотой гэж үзсэн.

■ Санхүүгийн сахилга бат, хяналт

Санхүүгийн сахилга бат дутмаг байдал. Төлбөрийн чадваргүй болох нь зээлийн хоршоодын санхүүгийн сахилга батыг сахиж, санхүүгийн үйл ажиллагааны өндөр стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, санхүүгийн зорилтоо биелүүлж чадаагүйгээс болж ихэвчлэн тулгардаг.

■ Санхүүгийн хяналт дутмаг байдал. Дампуурсан зээлийн хоршоод орлого зарлагаа хянаж чадахгүй байна. Энэ нь ихэвчлэн санхүүгийн систем муу, дотоод хяналтгүй, санхүүгийн нягтлан бодох бүртгэл муу, ялангуяа хуримтлагдалт дээр суурилсан нягтлан бодох бүртгэлийг эзэмшиж чадахгүй байгаатай холбоотой байдаг. Зээлийн хоршоод зардлаа хуримтлуулахгүйгээр ихэвчлэн өөрт байхгүй мөнгөөрөө зарцуулалт хийдэг. Буцалтгүй тусламжийг удирдахад



санхүүгийн хяналт дутмаг байгаа нь буцалтгүй тусламж дуусаж, шаардлагатай зардлыг нөхөхөд хүргэдэг. Зарим дампуурсан зээлийн хоршоодод гишүүдийн дансны бүртгэл хуучирсан, буруу бүртгэлтэй зэрэг маш тааруу бүртгэлтэй байсныг онцолсон.

- Санхүүгийн мэдлэг, мэдээлэл дутмаг байдал. Бүтэлгүйтсэн зарим томоохон зээлийн хоршоодын удирдах зөвлөл болон ажилтнууд зээлийн хоршоонд нь юу болж байгааг таниж мэдэх, ойлгох хангалттай санхүүгийн мэдлэг, мэдээлэлгүй байсан гэж тэмдэглэгдсэн. Удирдах зөвлөлийн хуралд оруулсан болон менежерт бэлэн байгаа санхүүгийн тайлан байхгүй байсан.
- Санхүүгийн шинжилгээ дутмаг байдал. Санхүүгийн мэдээллийн хомсдолоос илүүтэйгээр зээлийн хоршоодын санхүүгийн мэдээллийн утга, агуулгын талаар удирдах зөвлөл болон ажилтнуудын ойлголт, дүн шинжилгээ дутмаг байгаагаас болж бүтэлгүйтдэг. Санхүүгийн харьцаанд дүн шинжилгээ хийдэггүй, ихэвчлэн удирдах зөвлөл, ажилтнууд нь зохион байгуулалтын дутагдлыг цаг тухайд нь олж илрүүлж чаддаггүй.
- Санхүүгийн төлөвлөлт дутмаг байдал. Бүтэлгүйтэл нь ихэвчлэн алсын хараагүй, санхүүгийн талаар урьдчилан бодох чадваргүйгээс болдог. Бүтэлгүйтэл гэдэг нь зээлийн хоршооны санхүүгийн байдлыг ойлгох чадваргүй эсвэл нөхцөл байдал улам дордож байгааг харах чадваргүйн үр дүн юм.
- Байгууллагын хөрөнгө, нөөц бага буурай байдал. Санхүүгийн буруу төлөвлөлтийн гол элемент бол хөрөнгө болон бусад нөөцийг хангалттай бүрдүүлэхийн тулд урьдчилан бодохгүй байх явдал юм. Өөрийн хөрөнгийн харьцаа бага, бусад нөөц багатай зээлийн хоршоод бүтэлгүйтэлд өртөмхий, маш эмзэг байдаг.

■ **Зээлийн удирдлага, өр барагдуулах.**

- Зээлийн удирдлага муу байдал. Тооцоололгүй санамсаргүй зээл олгох, зээлийн багцын буруу менежмент нь хяналтаас хурдан гарах нөхцөл байдалд хүргэдэг. Loan book /зээлийн захиалгад/ хэт их өртөх нь зарим зээл муудаж эхэлбэл (ажилгүйдэл, өвчин эмгэг гэх мэтээс шалтгаалан) зээлийн хоршоодод ихээхэн хохирол учруулдаг. Зарим зээлийн хоршоодын тогтвортой үйл ажиллагааг алдагдуулахын тулд хоёрхон том муу зээл авсан байхад хангалттай.
- Үр ашиггүй өр төлбөрийг барагдуулах журам: Санхүүгийн алдагдалд орж, бүтэлгүйтсэн зээлийн хоршоод өр барагдуулах журам муу эсвэл огт байхгүй байсан.

■ **Тохиромжтой, үр дүнтэй бизнесийн загвар**

- Ажиллах боломжтой бизнесийн загвар дутмаг. Зээлийн хоршоод sub–prime зах зээлд /Зээлийн түүх муутай, ихэвчлэн өндөр хүү гэх мэт таагүй нөхцөлтэй зээлдэгчдэд зориулсан зээл эсвэл зээлийн зохицуулалтыг илэрхийлнэ/ үйл ажиллагаа явуулахад, бизнес эрхлэхэд хангалттай орлого олох нь хэцүү байдаг. Өндөр эрсдэлтэй, бага орлоготой гишүүд ихэвчлэн бага хэмжээний санхүүгийн өгөөж авахын тулд санхүүгийн нөөц хэрэгцээтэй байдаг. Эдийн засгийн хувьд олон янзын гишүүнчлэлд үйлчилдэггүй зээлийн хоршоод жижиг, эмзэг хэвээр үлдэж, жижиг, бүхэлдээ сайн дурынхан ажиллахгүй бол төсвөө тэнцвэржүүлэхэд бэрхшээлтэй байж болно.

■ **Бизнес төлөвлөлт**

- Бодит үйл ажиллагаа эсвэл бизнес төлөвлөгөө байхгүй. Амжилтгүй болсон зээлийн хоршоодын ихэнх нь ахиц дэвшлийг хянахад идэвхтэй ашигладаг бодит бизнес загвар эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөгүй байсан. Тэд зах зээлд дүн шинжилгээ хийж, ирээдүйн учирч болзошгүй тохиолдлуудын эсрэг хариу арга хэмжээг төлөвлөх чадваргүй байсан. Жишээлбэл, employer credit union–ны дэмжлэгийг алдах нь бизнесийн ашигт байдалд ихээхэн нөлөөлнө гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь employee зээлийн хоршооны бүтэлгүйтэлд хүргэж болзошгүй юм.

■ **Зохион байгуулалтын үр ашигтай байдал**

- Зохион байгуулалтын алдаа дутагдалд хариу үйлдэл үзүүлэх хурд бага. Хүнд хэцүү байдалд орсон зээлийн хоршоод зохион байгуулалтын дутагдалд хариу өгөхдөө удаан бөгөөд ур чадваргүй байдаг. Эхний ээлжид эдгээр дутагдлыг олж илрүүлэх систем бүрдээгүй байж болох ч зээлийн хоршоод үүнийгээ мэдсэн ч хариу арга хэмжээ авахдаа удаашралтай байдаг.



2/ Гаднын нөлөөллийн шалтгаанууд

Зээлийн хоршоодын ашиг орлого, тогтвортой байдалд заналхийлж буй гадаад хүчин зүйлүүд, ялангуяа эдийн засгийн уналтын үр дүнд нэмэгддэг байна. Гэсэн хэдий ч одоогоор Британид зөвхөн гадаад хүчин зүйлүүд зээлийн хоршооны дампууралд хүргэсэн гэх нотолгоо бараг байдаггүй. Гэсэн ч гаднын хүчин зүйлс бусад улс орнуудын нэгэн адил зээлийн хоршоодод сөргөөр нөлөөлж, Британийн зээлийн хоршоодын хувьд ихээхэн тодорхойгүй байдал үүсгэж болзошгүй юм.

Зээлийн хоршооны бүтэлгүйтлийн үндсэн шалтгаануудыг томъёолбол:

- ▲ Зээлийн хоршооны дампуурлын үндсэн шалтгаануудын цаана зээлийн хоршооны insolvency–төлбөрийн чадваргүй байдал болон default–өртэй байдал хоёрт үндсэн шалтгаан нь оршино. Эдгээр хоёр үндсэн хүчин зүйлээс бүтэлгүйтлийн бүх хүчин зүйл болон шууд шалтгаанууд үүсдэг. Энэ нь муу засаглал, муу менежмент юм.

■ Зах зээл дэх өөрчлөлтүүд

- Зах зээлийг хаах. Тухайн газарт компани хаагдах нь сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй зээлийн холбоонд нөлөөлөх. Зөвхөн 20, 30 зээлдэгчид төлбөрөө төлөхгүй байх шаардлагатай олон зээлийн хоршоодын зээл ноцтой асуудалд орох.
- Эдийн засгийн орчны өөрчлөлт
- Эдийн засгийн уналтын нөлөө. Анх зээлийн хоршоодын хувьд боломж мэт сэтгэгдэж байсан ч эдийн засгийн уналт нь зарим зээлийн хоршоодод сөргөөр нөлөөлж байгааг холбогдох судалгаануудад тогтоосон байдаг. Зээлдэгчдийн эргэн төлөлт, зээлийн хугацаа хэтэрч, найдваргүй өрийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр иргэд зээл авах дургүй болж, зээлийн хоршооны орлого ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Хадгаламжийг орлого авчрах зээл болгон хувиргах боломжгүй байгаа нөхцөлд зарим зээлийн хоршоод өөрийн хөрөнгийн хүрэлцээ, ногдол ашгийн хувь хэмжээг хэвээр хадгалахын тулд хадгаламж татан төвлөрүүлэхээс татгалзаж байна. Хөрвөх чадварын болон бусад хөрөнгө оруулалтын өгөөж буурсан нь зээлийн хоршоодын үр дүнд нөлөөлж байна.

■ **Үр дүнтэй засаглал дутмаг**

- Удирдах зөвлөлийн ур чадвар дутмаг. Судалгаануудад зээлийн хоршоодын дампуурал нь үндсэндээ ТУЗ–ийн асуудал бөгөөд энэ нь ихэвчлэн захирлуудын санхүүгийн болон бизнесийн чадвар дутлаас үүсдэг гэдгийг онцолсон. ТУЗ–ийн гишүүд санхүүгийн тайлангаа шүүн лавлаж магадлах, тэдэнд энэ нь юу хэлж байгааг асуух боломжгүй байдаг бол тухайн зээлийн хоршоод маш эрсдэлд мэдрэмтгий, эмзэг болдог. Гүйцэтгэх удирдлагуудын чадваргүй байдал, аливааг зөв шүүн тунгааж зөв асуулт тавьж, үүссэн бэрхшээл асуудлыг олж харах, илрүүлэх чадвар дутмаг байдал нь зээлийн хоршоодын үйл ажиллагаанд ноцтой хүндрэл учруулдаг. Удирдах зөвлөл нь чадалтай менежерийн нөлөөнд автсан тохиолдолд ч гэсэн тодорхой бэрхшээлүүд бий болдог.
- Шийдвэр гаргахдаа итгэл дутмаг байх. Хэрэв ТУЗ–үүд хэцүү шийдвэрүүдийг хурдан гаргахаас татгалзвал зээлийн хоршоод бэрхшээлтэй тулгарч байдаг. Жишээлбэл, Удирдах зөвлөлүүд ажилтнуудаа цомхотгох эсвэл үр ашиггүй, мэргэжлийн бус асуудлыг шийдвэрлэх талаар хатуу шийдвэр гаргахад хэцүү байдаг.
- Удирдах зөвлөлийн хэлэлцээ, тохиролцоо дутмаг байдал. Зээлийн хоршооны ахиц дэвшил, сайн сайхан байдалд удирдах зөвлөлийн гишүүдийн бодит оролцоо дутмаг байснаас бүтэлгүйтэл нэмэгддэг.
- Арилжааны /Бизнесийн/ соёл дутмаг байдал. Амжилтгүй болсон зээлийн хоршоодын удирдах зөвлөл дээр ихэвчлэн хүлээн зөвшөөрөгдөөгүй байгууллагын соёл, зүй бус хандлагатай байгаа нь ажиглагдаж байсан нь тухайн зээлийн хоршооны оршин тогтнох чадварыг хадгалахад сөрөг нөлөөтэй байсан. Ихэнхдээ удирдах зөвлөлүүд арилжааны зарчмуудыг баримтлан ажиллахад бэрхшээлтэй байдаг.
- Гаднын санхүүжилтэд хэт найдах. Амжилтгүй болсон зээлийн хоршоодод ихэвчлэн гаднын санхүүжилтийн урсгалд найдлага тавьдаг байсан ба ТУЗ–ийн гишүүд санхүүжилт олдохгүй, эсвэл хүссэнээр нь удирдаж чадахгүй үед ихээхэн түгшүүртэй ханддаг байсан. Ихэнх удирдлагуудын хандлага нь "аврагч, тэтгэгчдийг мөнхийн эрэлхийлэх (the Council being one)" байж болох юм. Иймээс бүтэлгүйтэл нь ТУЗ үүрэг хариуцлагадаа анхаарлаа хандуулдаггүй, хариуцлага хүлээх хүсэлгүй байгаагаас үүдэлтэй байж болно.
- Тасралтгүй залгамжлалын төлөвлөлт дутмаг. Хэд хэдэн бүтэлгүйтсэн зээлийн хоршоодын ТУЗ–ийн гишүүд зүгээр л "ran out of steam–хийж байгаа зүйлээ үргэлжлүүлэн хийх эрч хүч, сонирхлоо гэнэт алдсан". Бусад нь захирлууд зүгээр л хөгширч, тэднийг залгамжлах хэн ч байхгүй болохыг олж мэддэг.



■ Үр дүнтэй менежмент дутмаг

- Удирдлагын боловсон хүчний дутагдал. Олон жижиг зээлийн хоршоодод зээлийн хоршоог удирдах, хянах боловсон хүчин дутмаг, гол төлөв нэг эсвэл хоёр хүнээс хамааралтай байдаг. Хэрэв эдгээр хувь хүмүүс явах эсвэл өвдсөн тохиолдолд зээлийн хоршоо нь удирдлага хийх хүнгүй болох хүндрэлтэй тулгардаг. Цорын ганц удирдагч, жолоодогч байсан сайн менежерээ алдах нь зээлийн хоршоонд шууд хүндрэл учруулж болзошгүй юм. Олонд зээлийн хоршоодод дараагийн хариуцах хоёр дахь шатны чадварлаг удирдлага гэж бэлэн байдаггүй байна.
- Менежерүүдийн санхүүгийн мэдлэг, хэрсүү гярхай зан дутмаг байдал. Санхүүгийн буруу менежментийн үр дүнд зээлийн хоршоод дампуурдаг. Менежментэд санхүүгийн мэдлэг, санхүүгийн чиг хандлагыг унших ур чадвар дутмаг байвал зээлийн хоршоод бүтэлгүйтэж болзошгүй. Энэ нь зээлийн хоршоонд санхүүгийн харьцааны дүн шинжилгээ дутмаг байгаатай холбоотой байдаг.
- Санхүүгийн зөв process, procedures дутмаг байдал. Жишээлбэл, банкны тогтмол тооцоо, тохируулга хийгээгүй зээлийн хоршоод амархан хүндрэлд ордог.
- Мэргэшсэн, чадварлаг боловсон хүчин дутмаг байдал. Ажилтнууддаа мэргэжил эзэмшүүлэх, улмаар санхүүгийн асуудал шийдвэрлэх ур чадвараа хөгжүүлэхэд нь тусалдаг зээлийн хоршоод нь чадвар муутай, чадварлаг бус боловсон хүчнийг ажиллуулдаг хоршоодтой харьцуулахад бүтэлгүйтэх магадлал нь харьцангуй бага байдаг.
- Gatekeeper /хаалгач/ үүсгэн байгуулагч гишүүд. Зээлийн хоршооны үүсгэн байгуулагч гишүүд бизнес өргөжин тэлэхийн хэрээр чадварлаг менежерүүд болон санхүүгийн тохируулагч /controller/ нарт зам тавьж, зай тавьж өгөхгүй байвал хүндрэл үүсдэг. Зээлийн хоршоог үүсгэн байгуулсан хүн нь түүний цаашдын хөгжлийг удирдах хамгийн сайн хүн биш байх нь элбэг байдаг.

1.3. ЗЭЭЛИЙН ХОРШООГ ТОГТВОРЖУУЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ

Дэлхий даяар тогтворжуулах хөтөлбөрүүд нь зээлийн хоршоод гишүүдийн хадгаламжийн аюулгүй байдал, найдвартай байдлыг хангах замаар тэдний хадгаламжийг хамгаалахад чиглэгддэг. Бүтэлгүйтлийн үндсэн суурь болон хам шалтгаануудын нарийн төвөгтэй, харилцан хамааралтай шинж чанарыг мэдэж, бүх хөтөлбөрүүд тогтворжуулалтыг урт

хугацааны, стратегийн үүднээс авч үздэг. Хэн аль нь ч зээлийн хоршоод хүндрэлд орсон эсвэл сүйрлийн ирмэгт ирсний дараа дангаар бие даан хөндлөнгөөс оролцохыг хүсдэггүй. Бүх олон улсын тогтворжуулах арга барил нь зээлийн хоршоодыг дефолтод орсны дараа аврахаас илүү урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэгддэг.

Дэлхий даяарх тогтворжуулах хөтөлбөрүүд хууль, дүрэм журам, үйл ажиллагааныхаа хувьд өөр өөр байдаг. Заримыг нь засгийн газрын зохицуулагч (АНУ, Канад), заримыг нь хувийн хэвшлийн зээлийн хоршоодын leagues лиг болон холбоодоор (Ирланд, Польш, Узбекистан, Ямайка) дамжуулан удирддаг.

Гэвч хувийн хөтөлбөрүүдэд ч гэсэн хууль тогтоомжоор албан ёсоор тогтоосон эсвэл хүчтэй ажлын харилцаагаар зохицуулагчтай нягт холбоотой байдаг. Тухайлбал, Польшид зээлийн хоршоодын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, тогтворжуулахад Хоршооллын хадгаламжийн хоршоодын үндэсний холбооны /National Association of Co-operative Savings/ гүйцэтгэх үүргийг хууль тогтоомжид тусгасан. Узбекистаны хувьд тогтворжуулах хөтөлбөр нь зохицуулагчтай нягт уялдаа холбоотой байдаг ч илүү албан ёсны бус, хэлэлцээ тохиролцоо хийдэг. Олон улсын туршлагаас, тэр дундаа WOCSSU-ийн зүгээс санал болгож байгаагаар, хадгаламжийн даатгалын тогтолцооны нэг хэсэг болгон тогтворжуулах үйл ажиллагаанд засгийн газрын зохицуулалтын оролцоог нэмэгдүүлэх нь харьцангуй давуу талыг бүрдүүлдэг байна. Ирланд болон Ямайка улсын хувьд аль аль нь зээлийн хоршоодтой бөгөөд Ирландад энэхүү процесс үргэлжилж, харин Ямайкад энэ чиглэлд шилжилт хийж Засгийн газрын хадгаламж хамгаалах тогтолцоонд оруулсан. Ямайка улсын хувьд Төв банкаар дамжуулан захиргааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Тогтворжуулах хөтөлбөрүүд нь үйл ажиллагааны хэв маяг, соёлоороо ч ялгаатай. Зарим нь илэрхий дээрээс доош чиглэсэн, зааварчилгаатай байдаг бол мөн цэвэр хөрөнгө буурсан, зохицуулалт, тогтворжуулах хөтөлбөрийн дүрмийг дагаж

мөрдөөгүй тохиолдолд зээлийн хоршооны зөвлөл, удирдлагыг солих, зээлийн хоршоог тогтворжуулах, нэгтгэх, татан буулгах хүртэл түүний хяналтыг өөртөө авах эрхтэй байдаг.

Бусад хөтөлбөрүүд, ялангуяа хувийн хэвшлийн хувьд зохион байгуулагддаг зарим хөтөлбөрүүд нь доороос дээш чиглэсэн бөгөөд хэлэлцээр, нөлөөллийн замаар өөрчлөлтийг авчрахыг зорьдог байна. Гэсэн хэдий ч засгийн газар эсвэл хувийн хэвшлийн аль ч хөтөлбөрт хамрагдаж, оролцоход чанга хатуу нөхцөл, стандарт, дүрэм журам гэж байдаг. Тэд бүгдээрээ зээлийн хоршоодын үйл ажиллагааг эдгээр стандартуудын дагуу байнга хянаж, шалгаж байдаг бөгөөд бүтэлгүйтсэн тохиолдолд арга хэмжээ авах эрхтэй байдаг. Зээлийн хоршоодод асуудал үүссэний дараа аврахын тулд хөндлөнгөөс оролцдог түр тогтворжуулалтын хөтөлбөрүүдийн туршлага одоогоор дэлхийд байхгүй. Тогтворжилтын үр шимийг хүртсэн бүх зээлийн хоршоод өмнө нь бүтэц зохион байгуулалттай, нарийн хяналттай хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа уг үр дүнд хүрч чадсан байдаг.

Засгийн газрын зохицуулагч эсвэл хувийн хэвшлийнхний зүгээс явуулж байгаа ялгааг үл харгалзан тогтворжуулах үйл явц нь хөтөлбөрт хамрагдах, оролцох нөхцөл болох зохицуулалтын хэрэгжилт, нарийвчилсан, бат бөх гүйцэтгэлийн стандартыг хангасан олон нийтлэг зарчим дээр суурилдаг; тухайлбал, зайнаас болон газар дээр нь тогтмол хяналт, шалгалт, үзлэг хийх; сэргэлт сайжралыг хангахад нь зориулж тогтворгүй зээлийн хоршоодод санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэх; хөндлөнгөөс оролцох эрх мэдэл, зохицуулалтын аргыг хэрэглэх; хэрвээ шаардлагатай бол зээлийн хоршоог нэгтгэх,



татан буулгах үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг болно. Хэдийгээр өнгөрсөн хугацаанд зарим сөрөг жишээ, баримтууд байсан ч тогтворжуулах хөтөлбөрийн бүх мэдэгдэж буй жишээнүүд дээр тогтворжуулалтыг хадгаламжийн даатгалын бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг байна.

Тогтворжуулалт нь зээлийн хоршоодыг найдвартай, тогтвортой байгууллага болгох замаар хоршооны гишүүдийн хадгаламжийг хамгаалах зорилготой нэгдмэл цогц, зохион байгуулалтын бүтэцтэй үйл явц /process/ юм. Энэ нь зээлийн хоршооноос зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх, бизнесийн болон санхүүгийн гүйцэтгэлийн стандарт, сайн засаглал, үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэхийг шаарддаг учраас бүхэл нэгдмэл цогц /holistic insofar/ юм.

Тогтворжуулах үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг тодорхойлбол:

1. ТОГТВОРЖУУЛАЛТ НЬ ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛААР ХАРИЛЦАН БИЕ БИЭЭ НӨХДӨГ

Их Британид FSCS нь зээлийн хоршоод бүтэлгүйтэж, төлбөрийн чадваргүй болсны дараа хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр олгох замаар гишүүдийн хадгаламжийг хамгаалдаг. Тогтворжуулалтын хөтөлбөрүүд нь зээлийн хоршоодыг дампуурахад тэдний хадгаламж эзэмшигчдэд нөхөн төлбөр төлдөг хадгаламжийн баталгааны схемтэй холбоотой байдаг. Гэсэн хэдий ч тогтворжуулах үйл явц нь дампуурсан зээлийн хоршоодын хадгаламж эзэмшигчдийн эцсийн төлбөрийг хэзээ ч бодитоор хийх шаардлагагүй болгох зорилготой юм. Гишүүдийн хуримтлалыг санхүүгийн

хямралд орсны дараа төлж барагдуулах замаар бус асуудалтай байгаа зээлийн хоршоодод тухайн үед нь туслах, дэмжих замаар хамгаалах зарчим нь тогтворжуулалтын үндэс суурь юм. Жишээлбэл, Ирландад Тогтворжилтыг хамгаалах схемийн үр дүнд Ирландын зээлийн хоршоод хэзээ ч дефолт зарлаагүй бөгөөд нөхөн олговрын сангаас ямар ч ажиллагаа хийгдэх захиалга ирээгүй байдаг. Тогтворжилт нь зээлийн хоршоодыг гаднын тусламжгүйгээр хамгаалдаг шигээ хадгаламжийн баталгааны сангийн хөрөнгийг мөн адил хамгаалдаг /Stabilisation protects the assets of the deposit guarantee fund as much as it protects credit unions themselves/.

2. ТОГТВОРЖИЛТ НЬ ҮР ДҮНТЭЙ, АЛБАН ШААРДЛАГААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ, ЗАЙЛШГҮЙ ДАГАЖ МӨРДҮҮЛЭХ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭЭС ШАЛТГААЛДАГ.

Тогтворжуулах хөтөлбөрт оролцох, түүний дотор хадгаламж эзэмшигчийн хамгаалалтад хамрагдах нь заавал дагаж мөрдөх зохицуулалтын санхүүгийн болон үйл ажиллагааны стандартыг хэрхэн хэрэгжүүлснээс хамаарна.

Зохицуулалт сул буюу "light-touch-хөнгөн мэдрэгчтэй" улс орнуудад тогтворжуулах хөтөлбөрийн оролцоо нь хөтөлбөр өөрөө санхүүгийн болон үйл ажиллагааны бат бөх стандартыг дагаж мөрдөхөөс хамаарна.

Үл зохицол, нийцэл нь зохицуулагчийн хатуу чанд хөндлөнгийн оролцоо ба түүнийг удирдаж буй national credit union trade association болон

хөтөлбөрөөс гаргах аль алианаас нь шалтгаалдаг. Ирландаас Узбекистан улс хүртэл national trade association гишүүн байх нь санхүүгийн болон үйл ажиллагааны стандартыг дагаж мөрдсөн эсэхээс хамаардаг бөгөөд эдгээр стандартыг үүнийг үр дүнтэй гүйцэтгэлийн үндсэн шаардлага гэж тодорхойлсон.

Дэлхий даяарх санхүүгийн болон үйл ажиллагааны стандартууд харилцан адилгүй янз бүр боловч хоорондоо харьцангуй авцалдаа нийцтэй байдаг.

Ер нь тогтворжилт нь зээлийн хоршоодын хөрөнгө, хөрвөх чадвар, төлбөрийн чадваргүй байдлын чиглэлээр тогтоосон харьцааны үндсэн багц зорилтыг хэрхэн биелүүлж, бататгаснаас хамаарна.

Жишээлбэл, Узбекистан дахь WOCUU-ийн дэмжлэгтэй хөтөлбөрт тогтворжуулах хөтөлбөрт хамрагдахыг хүсэлтэй зээлийн хоршоодын цэвэр өөрийн хөрөнгийн харьцаа 4%-аас багагүй, зээлийн зөрчлийн харьцаа 10% ба түүнээс бага, үйл ажиллагааны зардал хөрөнгийн харьцаа 19%-аас ихгүй байхыг шаарддаг байна.

Ирландад Ирландын Холбооны Лигийн журмын дагуу, зээлийн хоршоод хадгаламжийг хамгаалах тогтолцоо болон Лигт гишүүн хэвээр үлдэхийн тулд өөрийн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа заавал 8%-аас доошгүй байх ёстой шаардлагыг хангаж, хадгалдаг уламжлалтай байдаг. АНУ-д өөрийн хөрөнгийн харьцаа 6%-аас доогуур байгаа аливаа зээлийн хоршоод заавал дагаж мөрдөх хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Хэрэв энэ харьцаа 4%-аас доош унавал зээлийн хоршоо нь маш хангалтгүй буюу дутуу хөрөнгөжсөн гэж үзэж, тогтворжуулах тусламж шаардлагатай байдаг.

Хэрэв зээлийн хоршооны өөрийн хөрөнгө/нийт хөрөнгийн харьцаа 2%-аас доош унасан бол түүнийг бараг дампуурсан гэж үзэж зохицуулагчийн мэдэлд очуулах, нэгтгэх, татан буулгах шаардлагатай болдог. Санхүүгийн стандартууд нь зээлийн хоршоодын дагаж мөрдөх ёстой бизнесийн болон үйл ажиллагааны стандартуудаар харилцан нөхөгддөг байна.

3. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ НЬ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОХИЦУУЛАЛТ, ЗАХИРГААНЫ ЭСВЭЛ ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГААС ХАТУУ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, БАЙЦААЛТ ХИЙХИЙГ ШААРДДАГ.

Тогтворжилт нь зөвхөн санхүүгийн болон үйл ажиллагааны стандарт байгаа эсэхээс гадна тэдгээр стандартыг дагаж мөрдөж байгаа эсэх, дагаж мөрдөж байгаад хяналт шалгалт хийдэг эсэх, тогтворжуулах хөтөлбөрт оролцох нөхцөлийн шаардлагаас хамаардаг.

Бүх кейс судалгаан дээр хариуцсан зохицуулах байгууллага нь санхүүгийн мэдээлэлд статистикийн харьцааны дүн шинжилгээ хийх, ихэвчлэн PEARLS хяналтын системийг ашиглан, тогтворжуулах хөтөлбөрт оролцох зээлийн хоршоодын гишүүнчлэлийн нөхцөл болгон тогтмол ирүүлдэг тайланг шалгах замаар санхүү, байгууллагын гүйцэтгэлд газар дээрээс нь байнгын хяналт тавьдаг байна. Жишээлбэл, Канадад зохицуулагч нь зээлийн хоршоо бүрийн санхүүгийн мэдээлэлд цахимаар шууд хандах боломжтой бөгөөд санхүүгийн чиг хандлагыг хянахын тулд нарийвчилсан, тасралтгүй санхүүгийн шинжилгээ хийдэг. Ирландын League of Credit Unions /зээлийн



хоршоодын лиг/ нь лигийнхээ гишүүнчлэлийн нөхцөл болгодог шаардлага болох бүх гишүүн зээлийн хоршоодын мэдээлэлд ижил түвшинд хандахаас гадна PEARLS харьцааг тогтмол хянадаг байна.

Бүх тохиолдолд хариуцаж зохицуулах байгууллага нь зээлийн хоршоонд очиж, нягтлан бодох бүртгэл, бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналт, зээлийн хоршооны засаглал, менежментэд газар дээр нь шалгалт хийх эрхтэй байдаг. Эдгээр үзлэг шалгалтыг ихэвчлэн жил бүр эсвэл газар дээр нь хяналт тавих ажиллагааг санаа зовоож, анхаарал татсан асуудал гарсан тохиолдолд хийдэг.

Бүх судалгаанд авч үзсэнээр хяналт шалгалтууд нь ихэвчлэн эрсдэлд төвлөрдөг бөгөөд гол асуудал болохоос нь өмнө асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх зорилготой байдаг. Ерөнхийдөө хянан шалгагч, байцаагчдын анхаарлын төвд үргэлж байдаг бөгөөд хамгийн их анхаарал хандуулдаг асуудал бол зээлийн хугацаа хэтрэлт, аливаа залилан мэхлэлт, найдваргүй өр зээл, өөрийн хөрөнгийн хүрэлцээ муудах зэрэг дампуурах, төлбөрийн чадваргүй болгодог гол хүчин зүйлүүд юм.

4. ТОГТВОРЖИЛТ НЬ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТЫГ БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛД УНАЛТАД ОРОХОД ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХ ЭРХ МЭДЭЛТЭЙ БАЙХЫГ ШААРДДАГ.

Гэмт хэрэг, зөрчил дутагдал өсөх, найдваргүй өрийг төлүүлэх хүчин чармайлт буурах эсвэл өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурах аливаа

хандлага нь бүх кейс судалгаанд хариуцагч эрх бүхий байгууллагаас нэн даруй анхаарал хандуулж, мөрдөн шалгаж, арга хэмжээ авах ёстой байдаг. Канад, АНУ зэрэг засгийн газрын схемд зохицуулагч нь Британи дахь FSA-ийн эзэмшиж буй үйл ажиллагаанаас гадна асуудалтай зээлийн хоршоодтой холбоотой зохицуулалт хийх ихээхэн эрх мэдэлтэй байдаг.

Асуудал гарвал төрийн зохицуулагч нь асуудал шийдэгдэх хүртэл зээлийн хоршоог өөрийн хяналтад байлгаж анхааруулга өгөх, торгууль ногдуулах, зээлийн хоршооны үйл ажиллагааг хязгаарлах, олон төрлийн засаж залруулах арга хэмжээ авах, тэр ч байтугай ТУЗ-ийн гишүүд, удирдлагыг сольж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хянах боломжтой байдаг. Хувийн зохицуулалтын схемд хариуцах эрх бүхий байгууллага нь хэрэгжүүлэх боломжтой ижил хэмжээний хөндлөнгийн оролцооны эрх мэдэлтэй байдаг боловч ихэвчлэн зохицуулалт хийх харилцан тохиролцооноос хамаардаг бөгөөд тогтворжуулах хөтөлбөр болон national trade association хасах шахалтын дор хуулийн хэрэгжилтийг хангаж ажилладаг. Ямайка улсад trade association нь ийм эрх мэдэлтэй байдаг бөгөөд зохицуулагчтай тохиролцсоны дагуу асуудалтай зээлийн хоршоодыг хяналтдаа авч, үйл ажиллагааг нь шууд удирдаж, дахин зохион байгуулах эрхтэй байдаг.

Хэдийгээр ихэнх тохиолдолд зээлийн хоршоод өөрсдөө тогтворжуулах хөтөлбөрөөс тусламж хүсдэг хэдий ч тогтворжуулах хөтөлбөр нь зөвхөн зээлийн хоршоодыг тогтворжуулах, гишүүдийнхээ хадгаламжийг хамгаалахад төдийгүй мөн түүнчлэн зээлийн хоршоодын нэр хүндийг бүхэлд нь, хамгийн гол нь тогтворжуулалтын сангийн хөрөнгийг хамгаалахад хөндлөнгөөс оролцох нэн үүрэг

хариуцлагатай байгууллага гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Залруулах арга хэмжээ авах ноцтой чухал байдал нь сангийн хөрөнгийг хамгаалахтай шууд холбоотой бөгөөд түүний хомсдол барагдуулалт нь бусад оролцогч зээлийн хоршоодод зардал болж очиж нөлөөлдөг.

5. ТОГТВОРЖИЛТ НЬ АСУУДАЛТАЙ БАЙГАА ЗЭЭЛИЙН ХОРШООДОД ТЕХНИКИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛДЭГ.

Бүх тогтворжуулалтын хөтөлбөрүүд нь асуудалтай зээлийн хоршоодод мэргэжлийн техникийн туслалцаа, зөвлөгөө, санхүүгийн дэмжлэгийг санал болгож, тэднийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь тусалдаг. Зарим улс орнуудад энэхүү техникийн болон санхүүгийн тусламж нь заавал байх ёстой (жишээ нь, АНУ–д яаралтай залруулах арга хэмжээ авах ёстой) бол, заримд нь зээлийн хоршоодын зөвлөл, удирдлагатай зөвлөлдсөний үндсэн дээр санал болгодог. Өмнө дурдсанчлан тогтворжуулах хөтөлбөрүүд нь хамгийн асуудалтай тохиолдолд зээлийн хоршооны хөрөнгийг эзэмших, зээлийн хоршоо өөрөө хяналтаа сэргээх чадвартай болох хүртэлх бизнесийн хяналт, үйл ажиллагааг хариуцах эрхтэй. Санхүүгийн тусламжийн хүртээмж нь тогтворжуулах хөтөлбөрүүдийн хооронд харилцан адилгүй байдаг ба санхүүгийн тодорхой хэрэгслийг өөр өөр зорилгоор ашигладаг. Жишээлбэл, Узбекистан дахь WOCU–ийн дэмжлэгтэй хөтөлбөрт хөрвөх чадвартай хадгаламжийг зөвхөн

шууд дампуурлын эрсдэлд ороогүй, хамгийн багадаа өөрийн хөрөнгийн 3%–ийн харьцааг хангах эх үүсвэр эсвэл мөнгөн урсгалтай бөгөөд үндсэн зээлийг хүүтэй нь төлж чадах зээлийн хоршоодод олгодог. Харин хувьцааны хадгаламжийг шууд дампуурах эрсдэлтэй, бараг л дампуурч байгаа эсвэл сөрөг цэвэр орлоготой, үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг төлөөд хамгийн бага эх үүсвэртэй өөрийн хөрөнгийн харьцаа 3 хувиас бага байх зээлийн хоршоодод ашиглагддаг. Санхүүгийн мөнгөн тусламжийг онцгой нөхцөл байдалд дампуурсан зээлийн холбоог шинэ удирдлагатай болгох эсвэл маш ноцтой нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэхэд ашигладаг. Их Британийн зээлийн хоршоодын сонирхлыг татах нэг санхүүгийн хэрэгсэл бол хөрөнгө худалдан авах явдал юм. АНУ–д зохицуулагч нь тогтворжуулахад туслахын тулд асуудалтай зээлийн хоршоодын хөрөнгийг худалдан авах боломжтой. Ер нь хэд хэдэн том зээл муудаж, зээлийн хоршоог тогтворгүй болгох магадлалтай бол зохицуулагч эдгээр зээлийн хөрөнгийг худалдан авч, эргэн төлөлтийг гишүүд өөрсдөө хөөцөлдөж, зээлийн хоршооны балансаас хасаж цэвэрлэж болно. Энэ нь зээлийн хоршоог нөхөн сэргээхэд шууд туслах зорилготой юм. Гэсэн хэдий ч, ихэнх тохиолдолд, санхүүгийн тусламжийг буцалтгүй тусламж гэж үздэггүй, харин зээлийн хоршоог тогтворжуулах түр зуурын зохицуулалт гэж үздэг бөгөөд шаардлагатай бол зээлийн хоршоог нэгтгэх, татан буулгах ажлыг зохион байгуулах ёстой гэж үздэг. Зээлийн хоршоо дахин тогтворжсоныхоо дараа санхүүгийн тусламжийг ихэвчлэн хүүтэй нь хамт тогтворжуулах санд эргүүлэн төлдөг байна.



6. ТОГТВОРЖУУЛАЛТ НЬ ЗЭЭЛИЙН ХОРШООГ ДАХИН САНХҮҮЖҮҮЛСНЭЭР ЦААШИД ТОГТВОРТОЙ БАЙХ ЭСВЭЛ НЭГДЭХ БОЛОМЖТОЙ ГЭЖ ҮЗЭЖ ХИЙСЭН СТРАТЕГИЙН БОЛОН ХЯНАЛТТАЙ ХЭРЭГЖИХ "WORK-OUT БИЕЛЭГДЭХ" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАМААРДАГ.

Асуудалтай зээлийн хоршоонд тогтворжуулах хөндлөнгийн оролцоо нь зээлийн хоршоог тасралтгүй үйл ажиллагаа явуулахад эсвэл ажил хэргээ, гэрээгээ өөр зээлийн хоршоонд шилжүүлэхэд хангалттай хүчтэй байхын тулд бүтцийн өөрчлөлт, нөхөн сэргээх төлөвлөгөөний дагуу зээлийн хоршооны захирлууд, менежерүүдтэй хамтран ажиллахыг хэлнэ. Сүүлийн үеийн жишээгээр, өөрчлөхийн өмнө зээлийн хоршоог хангалттай тогтворжуулах нь чухал бөгөөд эс тэгвээс өөрчлөлт нь хүлээн авагч зээлийн холбоог тогтворгүй болгож болзошгүй юм. Техникийн тогтворжуулах баг бүр санхүүгийн болон үйл ажиллагааны нарийвчилсан, хүрч болохуйц зорилттойгоор сэргээн босгох road map замын зураг дээр асуудалд орсон зээлийн хоршоотой хамтран ажилладаг. Үүнийг ихэвчлэн хатуу хянаж, шалгадаг. Жишээлбэл, Узбекистан улсын Үндэсний холбооны шинжилгээний алба (CUA) нь сар бүр зайнаас PEARLS шинжилгээ хийж, шаардлагатай гэж үзвэл олон удаа газар дээр нь очиж танилцах замаар "work out үр ашигтай байх" тохиролцоо гэрээний ахиц дэвшил, хэрэгжилтийг үнэлдэг. Хянан шалгагч ямар нэгэн сөрөг хандлагыг илрүүлсэн тохиолдолд нэн даруй арга хэмжээ авч, зохих арга хэмжээг эхлүүлнэ.

7. ТОГТВОРЖУУЛАХ ХУГАЦАА ХЯЗГААРЛАГДМАЛ

Бүтцийн өөрчлөлт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд хуваарилсан хугацаа нь нэг хөтөлбөрөөс нөгөөд өөр өөр байдаг. Гэхдээ ерөнхийдөө дээд тал нь дэмжигдсэн зээлийн хоршоо нь 2 жилийн дотор, ихэнхдээ илүү богино хугацаанд өөрийгөө бие даах чадвартай болох ёстой. Энэ хугацаанд амжаагүй л бол, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд дээд тал нь 2 жилийн хугацаанд тогтворжиж чадаагүй зээлийн хоршоодыг өөр зээлийн хоршоонд шилжүүлэх буюу татан буулгах болно. Тогтворжуулалтын хатуу чанга байдал нь тогтворжуулалтын сангийн хөрөнгийг дутуу гүйцэтгэлтэй, эрсдэлтэй зээлийн хоршоодын үйл ажиллагаанд зарцуулж, удаан үргэлжлүүлэхийг зөвшөөрдөггүй.

8. ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨРТ БИЕ ДААН ОРШИН ТОГТНОХ ЧАДВАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ НЭГТГЭХ, ТАТАН БУУЛГАХ АРГА ХЭМЖЭЭ БАГТАНА.

Тогтворжуулах арга хэмжээ нь ямар ч тохиолдолд зээлийн хоршоонд тавигдах санхүүгийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг шаарддаг. Узбекистан улс дахь WOCSSU-ийн дэмжлэгтэй хөтөлбөр нь тогтворжуулах хөтөлбөрүүдийн ердийн жишээ бөгөөд хэрэв тохирох зээлийн хоршоо олдохгүй бол хооронд нь нэгтгэх эсвэл татан буулгахыг зөвлөдөг байна.

Үүнд дараах шалтгаанууд хамаарна:

- Чадварлаг эсвэл туршлагатай удирдлага дутагдалтай бол;
- Зээлийн хоршооны санхүүгийн уналт доройтлоос шалтгаалан хууль, дүрэм, журам, хамтын ажиллагааны гэрээ, зөвшилцлийг ноцтой зөрчсөн бол;
- Зээлийн хоршооны үнэлгээ бага (5 зэрэглэл), дараагийн 6 сарын хугацаанд энэ зэрэглэлийг сайжруулах боломжгүй бол;
- Өөрийн хөрөнгийн харьцаа 2%–аас бага бол;
- 3 сар дараалан шаардлага, зохистой харьцаанд үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн тайлан ирүүлсэн бол;
- Хуульд заасны дагуу жилийнхээ аудитыг хийлгэж гаргаж өгөөгүй бол;
- Өмнөх 4 улирлын цэвэр алдагдал, түүний цаашдын чиг хандлагыг өөрчлөх боломжгүй бол;
- Үл тоох, илт хайхрамжгүй байдал гаргах, шударга бус үйлдэл ба/эсвэл залилан мэхлэх тохиолдол гаргасан бол;
- Зээлийн хоршооны удирдлага удирдамжийг хүлээж авах хүсэлгүй, эсвэл шаардлагатай залруулга, шийдвэр гаргаагүй бол;
- Гишүүнчлэлийн салбар, хэсэг орших боломжгүй болсон бол;

Тогтворжуулах хөтөлбөрүүд нь зээлийн хоршооны урт хугацааны оршин тогтнох чадамжийг нарийн оношлохоос шалтгаалдаг бөгөөд сэргэлт, шилжилтийг бодитой гэж үнэлэхгүйгээр тогтворжуулах оролдлого хийдэггүй. Ийм учраас тогтворжуулах хөтөлбөрүүд нь зээлийн хоршоодод engagement ажил хэргээ шилжүүлэх эсвэл татан буулгахад үргэлж тусалдаг.

АНУ–д зохицуулагч нь зээлийн хоршоог татан буулгасны дараа худалдан авах, хүлээн авах (P&A) сонголттой байдаг бөгөөд эдгээрийн нэгдэхээс ялгаатай нь зээлийн хоршоо нь зөвхөн тодорхой хөрөнгийг худалдан авах буюу, зөвхөн тодорхой тодорхой өр төлбөрийг хүлээн авдаг бөгөөд үүнд хувьцаа болон зээлийн данснууд багтдаг. Худалдан аваагүй хөрөнгө, хүлээлцээгүй өр төлбөрийг тогтворжуулалтын сан хариуцна.

Практикт энэ нь зээлийн хоршооны үйл ажиллагааг хаагдсан зээлийн хоршооны үйлчилдэг хэсэгт хүлээн авагч зээлийн хоршоод зөвшөөрөлгүйгээр үргэлжлүүлж хаагдаж буй зээлийн хоршооны алдагдлыг шийдвэрлэх боломжийг олгодог.

1.4. ЗЭЭЛИЙН ХОРШООГ ТОГТВОРЖУУЛАХ ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА

Их Британид 2002–2009 оны долоон жилийн хугацаанд 42 зээлийн хоршоо дампуурсан бөгөөд санхүүгийн үйлчилгээний нөхөн олговрын схемээр (FSCS) дефолт зарласан байдаг. Бүртгэгдэж, мэдэгдээгүй байдлаар зээлийн хоршоонууд мөн бүтэлгүйтсэн боловч орон нутгийн засаг захиргаа, DWP, сэргээн босголт эсвэл бусад гаднын агентлагуудын

санхүүгийн дэмжлэгтэйгээр аврагдаж эсвэл бусад хүчирхэг зээлийн хоршоод руу шилжсэн (нэгдсэн) байдаг. Өөрөөр хэлбэл Их Британид 2002–2009 оны хооронд зээлийн хоршоодын 10–аас доошгүй хувь нь дампуурсан гэж тооцоологддог. Үнэн хэрэгтээ бүтэлгүйтээгүй ч санхүүгийн хувьд бэрхшээлтэй олон зээлийн хоршоод байдаг бөгөөд тэд бүтэлгүйтэлд маш



өртөмтгий байдгийг онцолдог. FSCS-ийн зүгээс зээлийн хоршооны дампуурлын тоо буурч байгаа шинж тэмдэг байхгүй гэж мэдээлсэн бөгөөд эдийн засгийн хямралын үед энэ нь өсөх вий гэсэн болгоомжлолтой байдаг.

Амжилтгүй болсон 42 зээлийн хоршоодын дийлэнх нь зээлийн төлбөрийн чадваргүй байдлын түвшин харьцангуй бага буюу нэг зээлийн хоршоонд дунджаар 73 мянган фунт стерлинг байсан ч нэг тохиолдол нь 908 мянган фунт стерлинг байжээ. Цаашилбал, зээлийн хоршооны дампуурлын түвшин нь хоршооны салбарт сөргөөр нөлөөлсөн гэх нотолгоо байдаггүй. Хамгийн олон нийтэд танигдсан бүтэлгүйтлийн нөлөө нь зах зээлд маш бага сөрөг нөлөө үзүүлжээ. Жишээлбэл, Их Британийн Rochdale дэх Streetcred Credit Union-ийн бүтэлгүйтэл нь түүнээс хэдхэн км-ийн зайд байрлах Манчестер Кредит хоршоонд огт сөрөг нөлөө үзүүлээгүй буюу огт бүртгэгдээгүй байна.

Олон судалгаагаар олон улсын зээлийн хоршоодын туршлагаас суралцах зорилгоор дэлхийн хэмжээнд зээлийн хоршоог тогтворжуулах хөтөлбөрүүдийг харьцуулан судлахыг зорьсон байдаг. Тогтворжуулах зарчмуудыг олон улсын жишээн дээр харьцуулан боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судалсан байдаг. Олон улсын хэмжээнд тогтворжуулах сан, хөтөлбөрүүдийн янз бүрийн

загварууд байдаг бөгөөд тэдгээр нь хууль, үйл ажиллагааныхаа хувьд өөр өөр байдаг. Заримыг нь Засгийн газрын зохицуулагч (АНУ, Канад (*Ньюфаундленд, Лабрадор*), заримыг нь зээлийн хоршоодын /leagues/ лиг, холбоод (Ирланд, Польш, Узбекистан, Ямайка) хувийн хэвшлээр удирдагддаг.

Польшийн тогтворжуулах хөтөлбөрийн зарчмууд нь ерөнхийдөө гайхалтай нийтлэг бөгөөд тууштай тогтворжуулах зарчмуудад тусгагдсан байдгийг онцолмоор байна. Олон талаараа эдгээр зарчмууд нь Монгол Улсад тогтворжуулах хөтөлбөрийг боловсруулахад тус дөхөм болох тул зарчмууд нь хамгийн чухал юм.

Төрөл бүрийн загваруудын тухайд, олон улсад, тэр дундаа WOCCU-ийн зүгээс депозитыг хамгаалах тогтолцооны нэг гол хэсэг бол засгийн газрын зохицуулалтын оролцоог нэмэгдүүлэх явдал гэж үздэг. WOCCU-ын мэдээлснээр, зээлийн хоршоодын хувийн тогтворжуулах сан, хөтөлбөрүүд рүү шилжих шилжилт улам бүр цөөрсөөр байгаа бөгөөд үнэн хэрэгтээ Засгийн газрын зүгээс албан ёсоор хадгаламжийг хамгаалах тогтолцоог нэвтрүүлж байгаа нь үүний гол шалгаан болж байна. Энэ нь Шинэ Зеланд, Тринидад Тобаго зэрэг улсын жишээгээр тодорхой харагддаг гэж WOCCU тэмдэглэсэн байдаг.

1.4.1. КАНАДЫН УЛСЫН ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ХАДГАЛАМЖИЙН БАТАЛГААНЫ КОРПОРАЦ /THE CREDIT UNION DEPOSIT GUARANTEE CORPORATION/

Ньюфаундленд ба Лабрадор бол Канадын хамгийн зүүн мужууд бөгөөд Их Британиас дөрөвний гурав дахин том боловч ердөө 509,677 хүн амтай. Мужийн хэмжээнд 11

зээлийн хоршоо, тэдгээр нь 41 салбартай. 2010 оны байдлаар нийт хөрөнгө нь 740 сая канад доллар (буюу 416 сая фунт стерлинг) байсан. Зээлийн хоршоодоос хамгийн том нь 390 сая

канад доллартойгоос (211 сая фунт стерлинг) эхлээд 6 сая канад доллар (3.4 сая фунт) хүртэлх зээлийн хоршоод байдаг.

Тус мужууд дахь зээлийн хоршоодыг 1991 онд байгуулагдсан мужийн “Crown Corporation” буюу Зээлийн Хоршооны Хадгаламжийн Баталгааны Корпорац зохицуулж, хянаж, даатгаж, техникийн туслалцаа үзүүлдэг. 2009 оны Ньюфаундленд ба Лабрадорын зээлийн хоршооны тухай хуулийн дагуу тус корпорац нь зээлийн хоршоодын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хууль тогтоомжийг дагаж мөрдөх, бизнесийн оновчтой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүний удирдах зөвлөл нь зургаан хүний бүрэлдэхүүнтэй, гурав нь хариуцсан сайдын зүгээс томилдог Засгийн газрын төлөөлөгч, гурав нь тухайн мужууд дахь зээлийн хоршоодын санал болгосон хоршоодын төлөөлөл багтдаг.

Хадгаламжийн баталгааны сан

Тус корпорац нь хадгаламжийн баталгааны санг хариуцдаг бөгөөд энэ нь Их Британи дахь FSCS-ийн нэгэн адил зээлийн хоршоо татан буугдаж, хугацаа хэтэрсэн тохиолдолд хадгаламж эзэмшигчдийн гомдлыг барагдуулах зорилготой юм. Одоогоор энэ сан нь депозитын төрөл бүрийн данс тус бүрд 250,000 канад доллар (142 мянган фунт стерлинг) хүртэлх гишүүний депозитийг (хадгаламж) даатгадаг байна.

Гэсэн хэдий ч батлан даалтын сан нь зээлийн хоршоодод хүндрэлтэй тулгарах үед тогтворжуулах зорилгоор санхүүгийн болон бусад тусламж үзүүлэх бас давхар зорилготой юм. Батлан даалтын сангийн баталгаа гаргагчийн хувьд тус корпорац нь дампуурсан зээлийн хоршоодын тогтвортой байдлыг

сэргээхийн тулд чадах бүхнээ хийх үүрэгтэй бөгөөд ингэхдээ тэдгээрт сангийн хөрөнгийг ашиглах эсвэл бууруулах шаардлагагүй юм. Тиймээс Корпорац нь асуудалтай зээлийн хоршоодын үйл ажиллагааг тогтворжуулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зээлийн хоршоодын хадгаламжийг санхүүгийн алдагдал, төлбөрийн чадваргүй байдлаас үүсэх үнэ цэнгийн бууралтаас хамгаалах хуулийн дагуу тусгайлан үүрэг хүлээдэг.

Корпорац нь Их Британи дахь FSA-ийн нөлөөний зээлийн хоршоодтой холбоотой үйл ажиллагаа явуулах зохицуулалтын болон санхүүгийн ихээхэн эрх мэдэлтэй. Зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хатуу хяналт тавьж, санхүүгийн болон зохион байгуулалтын шалгалтыг тогтмол хийдэг. Асуудал үүссэн тохиолдолд түүнд хөндлөнгөөс оролцож, дутагдлыг арилгах, дампуурсан зээлийн хоршоодын үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор үйл ажиллагаа явуулах өргөн эрх мэдэлтэй байдаг. Зээлийн хоршоо ямар нэг талаараа дампуурч байна гэж үзвэл Корпорац нь тухайн байгууллагыг хяналтдаа авч, ТУЗ-ийн гишүүд болон удирдлагыг хоёуланг нь сольж, асуудлыг шийдвэрлэх хүртэл зээлийн хоршоог өөрийн хяналтад байлгах эрхтэй.

Хэдийгээр Корпорацаар удирддаг ч, батлан даалтын санг зээлийн хоршоод өөрсдөө санхүүжүүлж, Корпорацаас жил бүр хэмжигдэж, үнэлэгддэг хэд хэдэн шимтгэл, хураамж, татварыг төлдөг. Корпорацын нийт ажилчдын орон тооны долоон гишүүний бүх цалин, зардлыг зээлийн хоршооны системээр дамжуулан санхүүжүүлдэг. Корпорацын нэмэлт орлого нь зээлийн хоршооны даатгалын үндсэн бодлого боловсруулагчийн үүрэг гүйцэтгэснээс үүдэлтэй гарч ирдэг. Одоогийн байдлаар тус сан нь 6 сая



канад долларын хөрөнгө оруулалттай байна. Хэрэв ямар нэг зээлийн хоршоо бүтэлгүйтсэн тохиолдолд уг сан нь тус алдагдлыг нөхөхөд хүрэлцэхгүй байвал Корпорац Засгийн газарт хандаж зээл авах эсвэл санхүүгийн тусламж дэмжлэг авах бүрэн боломжтой байдаг. Зээлийн хоршооны системд Засгийн газраас зээлсэн буюу тусалсан санхүүжилт аливаа мөнгийг эцэст нь зээлийн хоршооны систем өөрөө төлдөг.

Зээлийн хоршоодын бизнесийн болон санхүүгийн зөв сайн туршлагыг дэмжих, сурталчлах

Корпорацийн зээлийн хоршоодыг тогтворжуулахад баримталж буй арга нь юуны түрүүнд урьдчилан сэргийлэх арга юм. Зээлийн хоршоодын үйл ажиллагаанд учирч болох бэрхшээл, алдагдлыг бууруулахын тулд Корпорац бүх зээлийн хоршоодоос хуулиар тогтоосон санхүү, зохион байгуулалтын стандартыг дагаж мөрдөхийг шаарддаг бөгөөд эдгээрийг хатуу мөрдүүлдэг. Жишээлбэл, зээлийн хоршоод өөрийн хөрөнгийн харьцаа /CAR/ 5%–аас багагүй (2% нь хувь нийлүүлсэн хөрөнгө, үлдсэн хэсэг нь хуримтлагдсан ашгаас), 6–аас доошгүй хувийн хөрвөх чадварын харьцаатай байхыг шаарддаг. Энэхүү стандартаас хазайх аливаа хазайлт, гажилтын нөлөөлөлд өртсөн зээлийн хоршооны Удирдах зөвлөлөөс зээлийн хоршоо хууль, журмын дагуу хэзээ, хэрхэн буцаж залруулахыг харуулсан төлөвлөгөө гаргаж өгөхийг Корпорацийн зүгээс шаардахад хүргэдэг. Төлөвлөгөөг Корпорацийн Удирдах зөвлөл хянаж, батлагдвал Корпорацийн ажилтнууд хяналт тавьж ажиллана. Төлөвлөгөөг биелүүлээгүй тохиолдолд зээлийн хоршоог Корпорацийн хяналтад оруулахад хүргэж болзошгүй.

Корпорац нь зээлийн хоршоодын удирдлага, санхүүгийн чадавхыг зохих стандартад нийцүүлэхэд нь туслахыг хичээдэг бөгөөд энэ нь хуульд заасан "бизнесийн зөв практикийг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх" болон "алдагдлаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр, хяналтыг бий болгож хэрэгжүүлэх" үүргийн тодорхойлолтод нийцдэг юм. Корпорац нь зээлийн хоршоодын зохицуулалтад оролцохдоо маш практик арга барилаар ханддаг бөгөөд бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны олон талтай холбоотой удирдамж, зааварчилгаа гаргах эрхтэй байдаг.

Жишээлбэл, Корпорац нь зээлийн хоршоодын тогтвортой байдал, санхүүгийн чадавхад сайн талтай гэж үзвэл "зээлийн хоршоодын зээлийн үйл ажиллагаа, зээлийн бодлоготой холбоотой нөхцөл, тодорхой хязгаарлалт, шаардлагыг тогтоох" боломжтой байдаг.

Удирдамж гаргаж хэрэгжүүлэх нь Корпорацийн хувьд хоршоодын ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг сургаж хөгжүүлэх чиг үүрэгт хамаарагддаг. Корпорацийн ахлах албан тушаалтнуудын нэг нь өгсөн ярилцлагадаа Корпорацийн сургалтад хамрагдах нь зээлийн хоршоог тогтворжуулахад чиглэсэн цогц арга барилд чухал байр суурь эзэлдэг гэдгийг онцолжээ. Сүүлийн жилүүдэд зээлийн хоршоодын тогтвортой байдлыг хангахын тулд Корпорац жишээлбэл, зээлийн хоршоодын компанийн засаглалыг сайжруулахад нэн тэргүүнд анхаарч, захирлуудын сургалтын хөтөлбөр, компанийн засаглалын хурал зэрэгт ихээхэн хөрөнгө зарцуулж байна. Зээлийн хоршоодын удирдах зөвлөлд мэргэшсэн, хариуцлага хүлээх чадвартай хүмүүсийг ажиллуулахын ач холбогдлыг Корпорац зээлийн хоршооны урт хугацааны тогтворжилтын гол

цөм нь гэж үздэг. Ярилцлагад хамрагдсан албан тушаалтны хэлснээр, зээлийн хоршоодын алдагдал, бүтэлгүйтэл нь тухайлбал, чадваргүй, хариуцлагагүй менежмент болон зээлийн буруу туршлагаас үүдэлтэй байдаг.

Удирдах зөвлөл дээр зөв асуудлуудыг хөндөж тавьж, удирдлагад хариуцлага тооцох чадавхыг бэхжүүлэх нь урт хугацаанд амжилтад хүрэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг. Компанийн засаглалыг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгснөөр тус мужууд дахь зээлийн хоршоодын тогтвортой байдал, гүйцэтгэл мэдэгдэхүйц сайжирсан гэж албаны хүн мэдээлсэн байдаг.

■ **Зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх**

Хадгаламжийн баталгааны сангийн үйл ажиллагаанд оролцохын тулд зээлийн хоршоодын үйл ажиллагаанд Корпорацаас тогтмол хяналт, шалгалт хийх шаардлагатай болдог. Ньюфаундленд, Лабрадор мужууд асар их зайтай байсан ч Корпорац зээлийн хоршооны үйл ажиллагаа, гүйцэтгэлийг сайтар хянаж байдаг. Энэ нь зээлийн хоршоо бүрийн санхүүгийн мэдээлэлд цахимаар шууд хандах боломжтой бөгөөд санхүүгийн үзүүлэлтийн чиг хандлагыг хянах зорилгоор санхүүгийн нарийвчилсан дүн шинжилгээ тогтмол хийдэг. Мөн бүх зээлийн хоршоод сар бүр санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа Корпорацад ирүүлж байх ёстой.

Жилд хоёр удаа Корпорацын аудиторууд жилийн эцсийн хөндлөнгийн аудитаас давсан шалгалтыг хийдэг байна.

Ингэхдээ Корпорац нь зээлийн хоршоодын үйл ажиллагаа, бүтэлгүйтэх эрсдэлд хяналт тавьдаг. Корпорацын хамгийн их анхаарах

ёстой хоёр зүйл бол зээлийн багцын чанар болон зээлийн багцын эрсдэлийн үнэлгээний асуудал юм. Дутагдалтай зээл олголт (нийт хөрөнгө ба идэвхтэй зээлийн үлдэгдлийн харьцаа бага), найдваргүй өр болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ муудаж байгаа нь зээлийн хоршоог дампуурахад хүргэдэг гол хүчин зүйл гэж Корпорац үздэг байна. Loan book /идэвхтэй зээлийн нийт үлдэгдлийн багцын чанар/ нөхцөл байдал, эргэлзээтэй өр төлбөрт гол анхаарлаа хандуулдаг. Корпорацын үзэж байгаагаар залилан мэхлэх болон зардал орлогын харьцаа өндөр байх асуудал нь тус мужийн зээлийн хоршоодын хувьд харьцангуй бага байдаг байна.

Зээлийн хоршоодын дунд улам бүр түгээмэл болж байгаа зээл олголт /идэвхтэй зээлийн үлдэгдэл/ болон хөрөнгийн харьцаа бага байгаа нь алсдаа орлогын бууралт, хөрөнгийн хүрэлцээг хадгалах чадавх буурахад хүргэдэг тул мониторингийн гол асуудал болж байна гэж мэдэгдсэн. Гэсэн ч ерөнхийдөө муу өр зээл нь Ньюфаундленд, Лабрадор дахь зээлийн хоршоодын тогтворгүй байдлын гол шалтгаан болсон. Тухайлбал, сүүлийн жилүүдэд менежерүүд зөвшөөрөлгүй их хэмжээний арилжааны зээл олгож, улмаар зээлдэгчид төлбөрөө төлж барагдуулахгүй байх тохиолдол цөөнгүй бүртгэгдсэн. Тийм ч учраас тус Корпорацын зүгээс зээл болон хугацаа хэтэрсэн харьцааг сайтар хянаж байдаг. Зээл нийт хөрөнгийн харьцаа бага байгаа нь санаа зовоосон асуудал мөн боловч нөгөөтээгүүр loan book /идэвхтэй зээлийн үлдэгдэл/ гэнэт өсөх нь үргэлж, Корпорацын эрх бүхий албан тушаалтны хэлснээр нэмэлт хяналт шалгалт хийх шаардлагатай болдог, учир нь энэ нь ихэнхдээ эргэн төлөлтийг зохих ёсоор тооцолгүйгээр их хэмжээний зээл олгосон байдаг ажээ. Хэрэв



Найдваргүй өр өссөн, өөрийн хөрөнгийн харьцаа 5 хувиас доошилсон эсвэл бусад шалтгаанаар анхаарал татах асуудал, шалтгаан байгаа бол Корпорац тухайн зээлийн хоршоонд очиж, нарийвчилсан шалгалт хийх эрхтэй. Үүнийг Корпорацийн тогтворжуулах баг гүйцэтгэдэг бөгөөд бүгд зээлийн хоршоонд өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэшсэн боловсон хүчин байдаг. Багийнхан тухайн хоршооны гишүүдийн зээлийг нэг бүрчлэн шалгаж, бодлогогүй эсвэл болгоомжгүй хийсэн үйлдэл эсэхийг тогтоодог байна.

Тогтворжуулах баг үргэлж хоршооны удирдлагаас тайлбар авах эрхтэй бөгөөд, тухайлбал, ялангуяа нийт зээлийн багцын 40 хувиас дээш хэмжээтэй зээл авсан байх тохиолдол юм. Ийм зээлийг маш өндөр эрсдэлтэй гэж үздэг байна. Ихэнх тохиолдолд, тогтворжуулах багийн тодорхойлсон өндөр эрсдэлтэй зээлийн хэмжээ нийт зээлийн дансны 20 хувиас дээш байвал зээлийн хоршоонд цаашид шаардлагатай арга хэмжээ авахыг шаарддаг байна. Тогтворжуулах багийн зөвлөмжийн дагуу Корпорац нь зээлийн хоршооны зээлийн үйл ажиллагааг хэт өндөр эрсдэлтэй гэж үзвэл хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хаах эрхтэй бөгөөд Корпорац тухайн зээлийн хоршооноос ирээдүйд учирч болзошгүй алдагдлыг нөхөх зорилгоор нөөц бүрдүүлэхийг шаардаж болно.

■ **Хяналт шалгалт зохион байгуулж зээлийн хоршоодод туслах**

Корпорац нь зээлийн хоршоог өр төлбөрөө төлөх чадваргүй, санхүүгийн хүндрэлд орсон, бизнесээ хууль тогтоомж, бизнесийн зөв практикт нийцээгүй гэж үзвэл уг хуулийн дагуу

зээлийн хоршоог хяналтдаа авах эрхтэй бөгөөд Корпорац эсвэл бусад эрх бүхий этгээдийн хяналт дор байхыг мэдэгддэг.

Корпорац нь зээлийн хоршоог хяналтдаа авах, удирдлага, үйл ажиллагааг бүрэн хариуцуулах хяналтын багийг илгээх эрх мэдэл нь Канадын тогтворжилтын арга барилын гол онцлог шинж чанар юм. Хяналтын баг нь хяналт дороо байлгах хугацаандаа зээлийн хоршооны асуудлыг судлах, ТУЗ болон удирдлагын бие даасан гишүүдийг огцруулах, солих, бодлого, журмыг өөрчлөх, нөхөн сэргээх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулахад ажилтнуудыг чиглүүлэх эрхтэй.

Хяналтын дор Корпорацаас илгээсэн баг зээлийн хоршоог тасралтгүй үйл ажиллагаа явуулах хэлбэрээр дахин зохион байгуулах эсвэл шаардлагатай бол өөр зээлийн хоршоотой нэгдэх эсвэл татан буулгах шийдвэр гаргадаг. Ийм нөхцөлд "зээлийн хоршоог өөрчлөн зохион байгуулах, нэгтгэх, татан буулгах болон бусад хэлбэрээр зохион байгуулах" эрх нь удирдах зөвлөл эсвэл гишүүдэд биш харин томилогдсон хянагч нарт шилждэг (*Зээлийн хоршооны тухай хууль: 176.1*) байна. Бараг бүх тохиолдолд хяналт явуулсны үр дүнд зээлийн хоршооны удирдлагыг солиход хүргэдэг. Эрх хүлээн авагч хянан шалгагч /supervisor/ нь шинэ менежер хайж, удирдлагын болон удирдах зөвлөлийн ур чадварыг тогтнож, бий болгохын тулд удирдах зөвлөлийн техникийн туслалцаа, сургалтыг үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Корпорац нь зээлийн хоршоодод санхүүгийн тусламж үзүүлэхийн тулд хадгаламжийн баталгааны санг ашиглах эсвэл Засгийн газар болон бусад байгууллагаас нэмэлт хөрөнгө зээлж болно. Энэхүү санхүүгийн тусламжийг зээлийн хоршоог дахин хөрөнгөжүүлэх, түүний

өр төлбөр, хөрөнгийг худалдах, өөртөө авах, эсвэл Корпорацын зохих ёстой арга хэмжээ гэж үзсэн бусад шалтгаанаар олгож болдог. Жишээлбэл, нэг зээлийн хоршоо 7 сая канад долларын алдагдал хүлээсэн бөгөөд үүний нэг хэсэг нь Понзи схемийн хэлбэрээр залилан мэхлэгдсэн гишүүнд 1.2 сая канад долларын зээлийн шугамыг сунгасантай холбоотой байсан. Мөн нэг гишүүнд ойролцоогоор 2.9 сая канад доллароор зөвшөөрөлгүй арилжааны зээл олгосон байсан нь тогтоогдсон бөгөөд зээлийн хоршооны менежер нь мөн зээлийн хоршооны гишүүдээс гуйж гувшиж зээл аваад Понзи схемд хөрөнгө оруулсан болохыг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр зээлийн ихэнх нь шаардлага хангаагүй байсан бөгөөд зээлийн хоршоод бүгд алдагдал хүлээсэн. Зээлийн хоршоо нь даатгалын бондоо ашиглан зарим алдагдлаа нөхсөн боловч Корпорац алдагдлаа бүрэн барагдуулах хүртэл санхүүгийн дэмжлэг болгон зээлийн хоршоонд жил бүр 400,000 канад доллар төлж, үлдсэн хохирлыг нөхөн төлөхийг шаардсан. Эцэстээ энэ зээлийн хоршоо өөр зээлийн хоршоонд нэгдсэн боловч хадгаламжийн баталгааны сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр энэ шилжүүлгийг хийх боломжтой болсон байна.

Санаа зовоосон асуудал шийдэгдэж, зээлийн хоршоо нь зохион байгуулалт, санхүүгийн хувьд үр дүнтэй тогтворжсон гэдэгт Корпорац сэтгэл хангалуун байх үед л зээлийн хоршоодыг хяналтаас чөлөөлдөг. Мэдээжийн хэрэг, энэ нь зээлийн хоршооноос доод тал нь 5% –ийн өөрийн хөрөнгийн шаардлагыг хангаж байгаагаас хамаарна.

Хяналтын тогтоолыг шүүхээр дамжуулан давж заалддаг тогтолцоо байдаг ч энэ асуудлыг удирдах зөвлөл барагдуулдаггүй, эсхүл шийдвэрлэсэн тохиолдолд үр дүнд хүрэх нь

ховор байдаг. Хяналт шалгалтын зардлыг хоршоодын ТУЗ ихээхэн эсэргүүцдэг ч Корпорацын дэмжлэггүйгээр зээлийн хоршоод бүтэлгүйтэх магадлал маш өндөр байдаг. Зээлийн хоршоог хүчирхэг зээлийн хоршоонд албадан шилжүүлэхийг гишүүдийн цөөнх, тухайлбал, гурван жил орчим эсэргүүцэж байсан ч Корпорац эцэст нь шүүхэд ялж, нэгдэх ажиллагаа явагдсан байдаг. Уг нэгтгэгдсэн зээлийн хоршоо нь одоо томоохон зээлийн хоршооны салбар болж үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд маш амжилттай ажиллаж, ард иргэд, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үнэ цэнтэй үйлчилгээг үзүүлсээр байна.

Дүгнэлт

Ньюфаундленд, Лабрадорын асуудалтай зээлийн хоршоодыг тогтворжуулах арга барил нь хатуу бөгөөд бат бөх суурьтай байна. Энэ нь санхүүгийн харьцааны тодорхой, мөрдөгдөж болох стандартуудыг тогтоох, бизнесийн болон санхүүгийн зөв практикийг дэмжих, гаднын Корпорацын техникийн ажилтнуудын байнгын хяналт, шалгалт, олон тооны эрх мэдлийг хангах зэрэг олон хүчин зүйлийг хамарсан хөндлөнгийн оролцоо, хяналтад байгаа зээлийн хоршоодод туслах системтэй, дээрээс доош чиглэсэн цогц арга хэмжээ юм.

Бусад орны нэгэн адил зээлийн хоршооны тогтворжилт нь хадгаламжийн баталгааны сантай холбоотой байдаг бөгөөд Корпорацаас авч буй арга хэмжээ нь аливаа асуудалтай зээлийн хоршооных шиг сангийн хөрөнгийг хамгаалахад чиглэдэг.

Ерөнхийдөө Ньюфаундленд, Лабрадор дахь зээлийн хоршооны тогтолцоо нь санхүүгийн хувьд найдвартай байдаг гэж Корпорацын албаны хүн ярилцлагадаа дурджээ. Өсөн



нэмэгдэж буй газрын тосны үйлдвэрлэлээрээ тус муж дэлхийн эдийн засгийн хямралд бага өртдөг бөгөөд, зээлийн хоршоод нь дэлхийн бусад хэсэгт тохиолдож байсан уналтыг төдийлөн амсдаггүй байна. Гэсэн хэдий ч, 2010 оны 3 сарын үед арван нэгэн мужийн зээлийн хоршооны гурав нь корпорацийн хяналтад байжээ. Тэдний өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа буурахад хүргэсэн байнгын асуудал бол зээлийн өрийн үлдэгдлийн чанар болон бүтээмж байв. Зээл олголт муу, найдваргүй өр ихтэй, зээлийн хөрөнгийн харьцаа бага зэрэг нь зээлийн хоршоо дампуурахад хүргэсэн.

Ньюфаундленд, Лабрадор мужид зээлийн хоршоо нь тус мужийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Корпорацийн албаны хүний тайлбарласнаар "Хэн нэгний хүсэж буй хамгийн сүүлчийн зүйл бол зээлийн хоршоог хаа явдал байж болох юм". Гэвч зээлийн хоршоо дампуурснаар тус мужийн эдийн засгийн амьдрал, хөгжил цэцэглэлтэд мэдэгдэхүйц

нөлөө үзүүлнэ. Ийм учраас төрөөс хадгаламжийн баталгааны санг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хөндлөнгийн оролцооны өргөн эрх мэдэл бүхий Корпорац байгуулсан. Ньюфаундленд, Лабрадор дахь зээлийн хоршоодын аюулгүй байдал, найдвартай байдлыг зохицуулагч нь зээлийн хоршоодын өөрсдөөс нь илүү биш юмаа гэхэд дутахааргүй хяналт тавьж ажилладаг.

1991 онд Корпорац байгуулагдахад тус мужид ойролцоогоор 100 сая канад долларын хөрөнгөтэй 18 зээлийн хоршоо ажиллаж байжээ. Эдгээр 18 зээлийн хоршооны 12 нь алдагдал хүлээсэн байна. 2010 онд нийт 4.7 хувийн нийлмэл хөрөнгөтэй /combined capital/ 11 зээлийн хоршоо үйл ажиллагаагаа явуулж байсан. 2010 онд нэг зээлийн хоршооноос бусад нь ашигтай байх төлөвтэй байсан. Алдагдалтай байж болзошгүй нэг зээлийн хоршоо нь зөвхөн 30,000 канад долларын алдагдал хүлээхээр байжээ.

1.4.2 АНУ-ЫН ҮНДЭСНИЙ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ДААТГАЛЫН САН /THE NATIONAL CREDIT UNION SHARE INSURANCE FUND/

Холбооны бие даасан агентлаг, Үндэсний Зээлийн Хоршооны Захиргаа/удирдлага нь (NCUA) холбооны зээлийн хоршоодыг бүртгэж, зохицуулж, хянадаг. Мөн NCUA нь гишүүдийн хадгаламжийг хамгаалж, зээлийн хоршоодод хүндрэлтэй үед нь техникийн болон санхүүгийн тусламж үзүүлдэг Үндэсний Зээлийн Холбооны Даатгалын Санг (NCUSIF) ажиллуулж, удирддаг байна. NCUA нь зохицуулалт, хяналтын чиг үүргээ хадгаламжийн даатгал, асуудалтай зээлийн хоршоодыг тогтворжуулахад чиглэсэн үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлдэг.

АНУ-д зээлийн хоршоод нь холбооны болон муж улсын дүрэмтэй байж болно. NCUA нь 5,000 холбооны дүрэмтэй зээлийн хоршоодын зохицуулалт, хяналтыг бүрэн хариуцдаг бөгөөд төрийн хяналтын агентлагуудтай хамтран NCUSIF-д оролцохоор сонгосон олон тооны 3,800 гаруй улсын дүрэмт зээлийн хоршоодыг хянадаг. Их Британи дахь FSA эсвэл FSCS-ээс ялгаатай нь NCUA нь зөвхөн зээлийн хоршоог хариуцдаг.

Үндэсний зээлийн хоршооны даатгалын сан (NCUSIF)

Үндэсний зээлийн холбооны даатгалын санг (NCUSIF) анх 1970 онд АНУ-ын Конгресс үүсгэн байгуулсан. Тэр цагаас өмнө хэд хэдэн худалдааны холбоод хувийн даатгал, тогтворжуулалтын сангуудыг зохион байгуулдаг байсан ч эцэст нь тэдгээр нь хангалттай хүч нөлөөтэй биш, эсвэл томоохон хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэхэд хангалттай том гэж тооцогддоггүй байв. NCUSIF нь АНУ-ын засгийн газрын "бүрэн итгэл, зээл"-ээр ивээн тэтгэгддэг. Гэхдээ зээлийн хоршоодын хөрөнгөөр бүхэлдээ санхүүжигдэг. NCUSIF нь анх худалдааны холбоодын хадгаламжийн даатгалын хөтөлбөрийн үлдэгдэл хөрөнгөөр хөрөнгөжсөн байна. Энэ нь нийт даатгуулсан хадгаламжийн 0.3 орчим хувийг эзэлж байсан. NCUSIF-ийг 1985 онд зээлийн хоршоо бүр өөрийн даатгуулсан хадгаламжийн 1%-ийг тус санд байршуулснаар дахин хөрөнгөжүүлсэн. Үүний үр дүнд зээлийн хоршооны гишүүдийн нийт хадгаламжийн 1.3 орчим хувийг хамрах сан бүрдүүлж чаджээ. Зээлийн хоршоод гишүүдийнхээ хадгаламжийн 1%-ийг NCUSIF-д хадгалах ёстой бөгөөд хадгаламж нэмэгдэхийн хэрээр уг хадгаламжийг нэмж оруулах ёстой.

Үүнийг NCUSIF-д оруулсан хөрөнгө оруулалт гэж бүртгэх бөгөөд хэрэв зээлийн хоршоо нь өөр санхүүгийн дүрэмд шилжих, холбооны бус даатгалд шилжих, эсвэл сайн дураараа татан буугдахаар сонгосон бөгөөд тухайн үед төлбөрийн чадвартай бол барьцааг буцаан олгоно.

Ихэнх тохиолдолд энэхүү 1 хувийн хадгаламж нь хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагааг хангахад хангалттай, үр дүнтэй

болох нь батлагдсан байна. 1992 онд гурван том зээлийн хоршоо бүтэлгүйтсэний дараа NCUA өнөөдрийг хүртэл зөвхөн нэг нэмэлт шимтгэл авчээ. Гэсэн хэдий ч сүүлийн үеийн санхүүгийн хямрал, эдийн засгийн уналт нь зээлийн хоршоод иргэний зээлийн хоршоодтой холбоотой хүлээгдэж буй алдагдлыг NCUSIF-ийг дахин хөрөнгөжүүлэх мөн Аж ахуйн нэгжийн тогтворжуулалтын сан байгуулахад зээлсэн хөрөнгийг эргүүлэн төлөхийн тулд даатгуулсан хадгаламжийн 0.15%-ийн нэмэлт шимтгэл хураахад хүргэж байна.

Тогтворжуулалтын сан нь хоршоолол, хамтралжуулалтын систем бөгөөд хэрэв шаардлагатай бол зээлийн хоршоод өөрсдөө хөрөнгөжүүлж байх ёстой байдаг. Хадгаламжийн даатгал нь АНУ-ын зээлийн хоршоодын дийлэнх хувийг төлөөлдөг холбооны дүрэмтэй 5000 зээлийн хоршоог бүхэлд нь хамардаг бөгөөд дүрэм журмын дагуу уг хөтөлбөрт заавал оролцох ёстой. NCUSIF нь оролцохоор сонгогдсон муж улсуудын ихэнх буюу 3,800 зээлийн хоршоодод үйлчилдэг. Одоогийн байдлаар NCUSIF нь даатгуулсан зээлийн хоршоодын бүх гишүүдэд 250,000 долларын хувийн дансны даатгалд хамруулж байна.

Хадгаламжийн даатгалын жижиг сан болох American Share Insurance (ASI) нь NCUSIF-д хамрагдаагүй мужийн хэмжээний 200 орчим хууль ёсны зээлийн хоршоодод үйлчилдэг. ASI нь NCUSIF-ийн даатгуулсан зээлийн хоршоодод нэмэлт даатгал санал болгодог бөгөөд хэрэв тэд нэмэлт даатгалаар (ASI-ийн бүтээгдэхүүнээр) хувийн данс тус бүрийг 500,000 доллароор нөхөн төлбөр авахыг хүсэж байвал байвал даатгуулж болдог.



NCUA–ын зээлийн хоршоодын хяналт ба магадалгаа Тогтворжуулалтын сангийн түүх /Stabilization Fund History/

Зээлийн холбоог тогтворжуулах түр санг /The Temporary Corporate Credit Union Stabilization Fund/ 2009 оны тавдугаар сард байгуулсан бөгөөд энэ нь дампуурсан таван corporate зээлийн хоршоодын хохирлыг тооцох, даатгуулсан зээлийн хоршоодын хохирлыг цаг хугацааны дарааллаар үнэлэх зорилготой юм. Харин Тогтворжуулалтын санг бий болгохын тулд эдгээр алдагдлыг Зээлийн нэгдсэн хоршооны даатгалын сангаас /National Credit Union Share Insurance Fund/ хариуцаж, Даатгалын сангийн /Share Insurance Fund/ хуримтлагдсан ашгийг шавхаж, зээлийн хоршоодын нэг хувийн хөрөнгө оруулалтыг үлэмж хэмжээгээр алдагдуулах байсан.

Тогтворжуулалтын санг мөн компанийн тогтолцоог шийдвэрлэх хөтөлбөрийн зардлыг тооцох, орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас, арилжааны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас, бусад хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны багцыг шийдвэрлэхэд богино болон урт хугацааны санхүүжилт олгох, болон корпорацын бондыг хамтад нь өвлөн авсан хөрөнгө гэж нэрлэдэг. Корпорацын системийг шийдвэрлэх хөтөлбөрийн хүрээнд NCUA нь дахин үнэт цаасжуулах хөтөлбөрийг бий болгож, NCUA нь хуучин эд хөрөнгийг урт хугацааны санхүүжилтээр хангах зорилгоор хөрөнгө оруулагчдад худалдсан NCUA–ийн баталгаат өрийн бичгийг /NCUA Guaranteed Notes/ гаргажээ.

2017 оны 9–р сарын 28–ны өдөр NCUA–ийн Удирдах зөвлөлөөс 2021 оны 6–р сарын 30–ны өдөр хугацаанаас өмнө 2017 оны 10–р сарын

1–ний өдрөөс эхлэн хэрэгжих Түр зуурын Зээлийн Холбооны Тогтворжуулалтын Санг /Temporary Corporate Credit Union Stabilization Fund/ хаахаар санал нэгтэй тохиролцсон байсан. Үндэсний Зээлийн Холбооны Даатгалын Сан /National Credit Union Share Insurance Fund/ нь тус хөтөлбөрийг зогсооход чухал алхам болсон.

Тогтворжуулалтын санг зогсоож, даатгалын сангийн /Share Insurance Fund/ үйл ажиллагааг хэвийн болгох

National Credit Union Administration–ын /NCUA/ ТУЗ 2017 оны есдүгээр сарын нээлттэй хурлаар 2017 оны 10 дугаар сарын 1–ний өдрөөс эхлэн Temporary Corporate Credit Union Stabilization Fund үйл ажиллагааг хааж, Тогтворжуулалтын сангийн бүх хөрөнгө, чиг үүргийг National Credit Union Share Insurance Fund /NCUSIF/–д шилжүүлсэн.

Үүний зэрэгцээ даатгалын сангийн хэвийн үйл ажиллагаа явуулах зохимжтой түвшинг 1.39 хувь байхаар тогтоохыг ТУЗ–аас баталсан. Холбооны Зээлийн Хоршооны тухай /Federal Credit Union Act/ хуулийн дагуу үйл ажиллагааны хэвийн түвшин нь NCUA–ийн ТУЗ–аас тогтоосон өөрийн хөрөнгийн харьцаа /equity ratio/ бөгөөд 1.20 хувиас багагүй, 1.50 хувиас ихгүй байхаар зохицуулсан. Даатгалын сангийн өөрийн хөрөнгийн харьцаа нь зээлийн хоршоодын оруулсан нийт хадгаламжийн үлдэгдлийн нэг хувийн шимтгэл болон хуримтлагдсан ашгаас хөрөнгө оруулалтын ашиг, алдагдлыг хасаж нийт даатгуулсан депозитод хуваасан харьцааны дүн юм.

Хөрөнгө, санхүүжилтийг хуваарилсны дараа NCUA–ийн ТУЗ 2018 оны 2–р сарын нээлттэй хурлаар шаардлага хангасан зээлийн

хоршоодод 736 сая ам.долларын даатгалын нөхөн олговрын хуваарилалтыг 2018 оны 3-р улиралд төлөхөөр баталсан.

Цаашид хадгаламжийн даатгалын нөхөн олголт нь даатгалын сангийн үйл ажиллагааны гүйцэтгэл болон ТУЗ-өөс тогтоосон хэвийн үйл ажиллагааны түвшингээс хамаарна.

Корпорацийн хэмжээний системийг шийдвэрлэх хөтөлбөрөөс /Corporate System Resolution Program/ хэрэгжээгүй үлдсэн үүрэг хариуцлага бий. Төлөөлөн удирдах зөвлөл /Share Insurance Fund-ийн/ эдгээр үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг үлдээсэн тохиолдолд Хувьцааны даатгалын сан /Share Insurance Fund-ийн/ зохих түвшний эрсдэлийг хариуцаж чадна гэдгээ илэрхийлсэн байдаг.

Тогтворжуулалтын сантай холбоотой цэвэр тооцоолсон үнэлгээний болон бусад цахим хуудасны үзмэр, холбооснууд хамааралгүй болсон ч энд лавлагаа болгон хадгалсан болно.

NCUSIF-ийн үр дүнтэй үйл ажиллагаа нь урьдчилсан шалгалт, эрүүл, тогтмол хяналт шалгалтын хөтөлбөрөөс хамаарна гэдгийг NCUA-ийн ажилтнууд онцолж байна. Холбооны Зээлийн Хоршооны тухай хуулийн дагуу, NCUA-ийн шалгуулагч нар аудит, нягтлан бодох бүртгэл, бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналт, зээлийн хоршооны засаглал, менежментийн шалгалт хийх зорилгоор холбооны дүрмийн дагуу зээлийн хоршоод элсэх эрхтэй. Энэ нь ихэвчлэн жил бүр болдог. Үүнтэй төстэй NCUA-д элсэх эрх нь NCUSIF-д оролцдог төрийн тусгайлсан зээлийн хоршоодод байдаг боловч энэ нь ерөнхийдөө NCUA-ийн шалгуулагчдыг улсын шалгуулагчид дагалдан явуулахаас хамаарна. NCUA нь улсын зээлийн хоршоодын хянагч нартай шалгалт явуулах үйл

явц, хяналтын харилцаатай холбоотой гэрээ, хэлэлцээр байгуулдаг. NCUA-ийн үзлэг нь эрсдэлд төвлөрсөн бөгөөд гол асуудал болохоос нь өмнө асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх зорилготой. NCUA-ийн шинжээчид эрсдэлд гол долоон чиглэлээр анхаарлаа хандуулдаг. Үүнд: (1) зээл; зээл эсвэл хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг төлөхгүй байх эрсдэлийг тодорхойлох; (2) хүүгийн түвшин; зах зээлийн ханшийн өөрчлөлт нь орлогод сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлох; (3) хөрвөх чадвар; үүргийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх боломжгүй болох эрсдэлийг тодорхойлох; (4) гүйлгээ; гүйлгээний боловсруулалтад бүтээгдэхүүн хүргэх, өрсөлдөх чадвараа хадгалах, мэдээллийг удирдах чадваргүй болох залилан мэхлэх, үйл ажиллагааны асуудлуудыг тодорхойлох; (5) дагаж мөрдөх; хууль тогтоомж, зохицуулалтыг зөрчих, дагаж мөрдөхгүй байх эрсдэлийг тодорхойлох; (6) стратегийн; бизнесийн сөрөг шийдвэр гаргах эрсдэлийг тодорхойлох; ба (7) нэр хүнд; итгэл алдагдах ба/эсвэл харилцаагаа таслахад хүргэдэг сөрөг олон нийтийн санаа бодол, төсөөллийн эрсдэлийг тодорхойлох.

Хянан шалгагчдын анхаарлын төвд байдаг эрсдэлийн хоёр гол хүчин зүйл бол зээлийн хугацаа хэтэрсэн байдал болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ юм. NCUA-ийн эрх бүхий албан тушаалтан уг шалгалт нь дотоод аудит биш хэдий ч, гэхдээ энэ нь loan book-ыг шалгаж, зээлийн андеррайтерийн үнэлгээ хийх зэрэг арга хэмжээнүүдийг багтаадаг гэж тайлбарласан байдаг.

NCUA-ийн хяналт шалгалтын мэргэжилтнүүд зөрчлийн чиг хандлагыг ажиглаж, 2 сараас дээш хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг шийдвэрлэх чадварт үнэлгээ өгдөг. Тэд зээлийн алдагдлыг нуух ердийн арга болох зээлийн



өөрчлөлт (хугацааг өөрчлөх) зэрэгт онцгой анхаарал хандуулдаг.

Хөрөнгийн (цэвэр хөрөнгө) харьцааг үнэлэх нь заавал хийгдэх ёстой байдаг. Зээлийн хоршооны үндсэн шинж чанар, насжилт зэрэг тодорхой хувьсагчууд байдаг хэдий ч ихэвчлэн зээлийн хоршооны хөрөнгийн капиталжуулалтын хэмжээ 7% ба түүнээс дээш хувьтай байвал маш сайн, 6-аас 6.99% хүртэл байвал хангалттай хөрөнгөжсөн, харин 6% хувиас бага харьцаагаар цэвэр хөрөнгө капиталжсан байвал дутуу хөрөнгөжүүлсэн гэж үзэгддэг.

"Шуурхай залруулах арга хэмжээ" (РСА)-ны горимын дагуу заавал хийх хэд хэдэн арга хэмжээг капиталжуулалт нь 6%-аас доош хөрөнгийн харьцаатай аливаа зээлийн хоршоод хэрэгжүүлэх ёстой бөгөөд энэ нь бүх тохиолдолд хөрөнгийн өсөлтийг хязгаарлах, бизнесийн зээл олгохыг хазаарлах, цэвэр хөрөнгийг сэргээх хөгжлийн төлөвлөгөө зэргийг багтаасан байдаг.

Хэрэв энэ харьцаа 4 хувиас доош унавал зээлийн хоршоо нь маш дутуу хөрөнгөжсөн гэж тооцогдож, тогтворжуулах тусламж нэн яаралтай шаардлагатай байдаг. Хэрэв зээлийн хоршооны капиталжуулалтыг 2%-аас доош унасан бол түүнийг маш дутуу хөрөнгөжүүлсэн гэж үнэлдэг бөгөөд NCUA (консерватор) хүлээн авах, нэгтгэх эсвэл татан буулгах шаардлагатай болдог.

Жил бүрийн шалгалтын дараа NCUA-ийн хянан шалгагч хүлээн зөвшөөрөгдөөгүй эрсдэлтэй нөхцөл байдлыг засах боломжит арга замыг тодорхойлж, санал болгож, Шийдвэрлэх Арга хэмжээний баримт бичгийг (DOR- Documents of Resolution) боловсруулж бэлтгэдэг. NCUA нь төлбөрийн чадваргүй эсвэл төлбөрийн чадваргүй болох аюулд орсон болон/эсвэл

амьдрах чадвар нь эргэлзээтэй байгаа NCUSIF-ийн даатгуулсан зээлийн хоршоодод тусгай тусламж үзүүлэх эрх үүрэгтэй. Зорилго нь санхүүгийн чадавхтай, бие даан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эсвэл өөр зээлийн хоршоодтой нэгдэх, худалдан авах, эзэмшихэд нь туслах явдал юм. Өмнө дурдсанчлан хөрөнгийн харьцаа буурсан тохиолдолд шалгуулагчид РСА-ын зайлшгүй арга хэмжээ авахаас өөр сонголт байдаггүй. NCUSIF-ийн дагуу NCUA шалгалтын зардлыг зээлийн холбоод өөрсдөө хариуцдаг. Хяналт шалгалтын зардлын төлбөр нь хөрөнгийн хэмжээтэй шууд пропорциональ хамааралтай. 2 сая доллароос доош хөрөнгөтэй зээлийн хоршоодын хяналт шалгалтын төлбөр нь чөлөөлөгддөг байна.

Асуудалд өртсөн зээлийн хоршоодод NCUA тусламж үзүүлэх

Холбооны Зээлийн Хоршооны тухай хуулийн дагуу NCUA нь дампуурсан зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, тэдэнд туслах өргөн бөгөөд чухал эрх мэдэлтэй байдаг бөгөөд энэ тухай NCUA-ийн шалгалтад зориулсан гарын авлагад дурдсан байдаг:

"FCU хуулийн §208(a)-д дараах зорилгоор тусгай тусламж үзүүлэхийг зөвшөөрсөн:

Хаагдсан, даатгуулсан зээлийн хоршоог дахин нээх; даатгуулсан зээлийн хоршоо хаагдах аюулаас урьдчилан сэргийлэх; эсхүл төлбөрийн чадвартай зээлийн хоршоог сайн дураар татан буулгахад туслах;

NCUSIF буюу зээлийн хоршооны гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах; эсвэл (1) Эрсдэлийг бууруулах, (2) NCUSIF-д учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх, нэг

даатгуулсан зээлийн хоршоог нөгөөтэй нэгтгэх, эсвэл (3) нээлттэй буюу хаалттай зээлийн хоршооны хөрөнгийг өөр этгээд өөрийн өр төлбөрийг өөртөө үүрүүлэх зорилгоор худалдах үйл ажиллагааг хөнгөвчлөх" гэж зээлийн хоршоодын ноцтой асуудлыг шийдвэрлэхийн тулд NCUA нь дараагийн хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан олон арга хэмжээ авах боломжтой байдаг. Гэсэн хэдий ч NCUA-гээс үзүүлэх тусламжийг буцалтгүй тусламж гэж үзэхгүй, харин зээлийн хоршоог дахин тогтворжуулах, нэгдэх, худалдан авах, таамаглах, шаардлагатай бол NCUSIF-ээс тусламж эрэхгүйгээр татан буулгах зорилгоор зээлийн холбоог сэргээх түр зуурын зохицуулалт гэж үзэх ёстойг онцлон тэмдэглэдэг байна.

Зээлийн хоршоод бие даан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд тусгай тусламж авдаг бөгөөд "тусгай тусламж авах үндэслэлээ батлах ёстой ба тухайн тусламж нь зээлийн хоршоог санхүүгийн хувьд чадавхтай санхүүгийн байгууллага болгоход тусална гэдгийг харуулах ёстой". NCUA-ийн албан тушаалтны хэлснээр "оршин тогтнох чадвар ба удирдлагын багийн амжилт" нь хоёр гол хүчин зүйл бөгөөд тусламжийг өөр зээлийн хоршоотой хослуулахыг эрэлхийлэхийн оронд зээлийн хоршоог нээлттэй байлгахад ашиглагдаж байгаа эсэхийг тодорхойлоход үнэлгээ өгдөг. NCUA тусламж нь түр болон байнгын хэлбэртэй байж болно. Түр зуурын тусламж нь ихэвчлэн 6 сараар хязгаарлагддаг бөгөөд байнгын тусламж нь 24 сарын "workout/туршлага"-ын хугацаатай байдаг. Ер нь байнгын тусламж нь тийм ч хялбар биш боловч урьдчилсан 9 шаардлагыг хангасан эсэхээс хамаарна. Зээлийн хоршоог тогтворжуулах оролдлого хийхээс өмнө түүний урт хугацааны оршин тогтнох боломжийг сайтар

үнэлдэг. 9 шаардлага нь NCUA гарын авлагад дурдсанчлан:

1. Гишүүнчлэлийн хэрэгжих боломжтой талбар
2. Чадамгай менежмент
3. Үнэн зөв, нягт бүртгэл, данс тооцоо
4. Санхүүгийн мэдээллийг бүрэн дүүрэн, нээлттэй ил тод байлгах
5. Зүй зохистой бичигдсэн бодлого болон дүрэм журмууд (эсвэл тэдгээрийг хэрэгжүүлэх бодит төлөвлөгөө)
6. Дэмжигдсэн цэвэр хөрөнгийг нөхөн сэргээх төлөвлөгөө эсвэл эрсдэлд суурилсан төлөвлөгөө (тусламжийн эргэн төлөлтийн нөлөөллийг багтааж оруулаад)
7. Санхүүгийн гүйцэтгэл, асуудлыг шийдвэрлэсэн эерэг түүх, туршлага
8. Үндсэн асуудлуудыг залруулах
9. Тасралтгүй гүйцэтгэлийг хянах систем

2008 болон 2009 он хүртэл NCUA нь " хувь хүмүүст үйлчилдэг" зээлийн хоршоодод 1.1 тэрбум долларын тусламж үзүүлсэн байна. NCUA-ийн албаны хүмүүсийн тооцоолсноор сүүлийн 5 жилийн хугацаанд 25 зээлийн хоршоо тогтворжуулах хөтөлбөрөөр тусламж авсан боловч ихэнхдээ хоорондоо нэгдэхийг хялбарчлах эсвэл хөрөнгө, өр төлбөрийг хүлээн авах, өөртөө авах зорилгоор ашиглагдсан.

Асуудалд өртсөн зээлийн хоршоодыг тогтворжуулахын тулд NCUA-с авах арга хэмжээ

Зээлийн хоршоодыг дампуурсан тохиолдолд NCUA-ийн арга хэмжээ нь асуудалтай зээлийн



хоршоодын эдийн засаг, зохион байгуулалтын байдлаас бүрэн хамаарна. Эдгээр нь авах арга хэмжээ, үзүүлэх дэмжлэгийг нарийвчлан тодорхойлсон янз бүрийн төрлийн харилцан ойлголцлын бичиг (*LUА– Харилцан ойлголцлын захидал (LUAs) нь зээлийн хоршоо нь DOR гэх мэт ноцтой арга хэмжээнүүдэд зохих ёсоор хариу өгөөгүй тохиолдолд засгийн газартай хэлэлцээр хийдэг албан ёсны гэрээ юм*)–ийн асуудлаас эхлээд зээлийн хоршоодыг консерватор болгох /*Conservatorship гэдэг нь шүүхээс насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй хүний санхүүгийн болон хувийн асуудлыг зохицуулах хүнийг томилдог эрх зүйн статус юм*/, зээлийн хоршоог бүс нутгийн тусгай ажиллагааны хэлтэст шилжүүлэх, эсвэл нэгдэх процессыг хялбарчлах, эсвэл худалдан авах, хүлээн авахын тулд дэмжлэг үзүүлж цэгцлэх зорилготой байдаг.

Консерватор бол NCUA–д хийх боломжтой хамгийн чухал бөгөөд хүчирхэг арга хэмжээний нэг юм. Энэ нь гишүүнчлэлийн ашиг сонирхлын үүднээс Зээлийн хоршоог NCUA–ын гишүүдийн хүсэл сонирхлын үүднээс виртуалаар хүлээн авах явдал бөгөөд ТУЗ–ийг томилсон удирдах зөвлөлөөр сольж, зээлийн хоршоог тогтворжуулахад хангалттай чадваргүй гэж үзсэн тохиолдолд менежер, ажилтныг мөн сольж болно. Энэ нь NCUA–д өргөн хэрэглэгддэг үйлдэл биш бөгөөд NCUA–ийн удирдах зөвлөлөөс батлагдаж, дэмжигдсэн байх ёстой. Зорилго нь зээлийн хоршоо болон NCUSIF–ийн хөрөнгийг хоёуланг нь хадгалах явдал юм.

Консерваторт орсны дараа зээлийн хоршоо нь PCA зохицуулалтын дагуу цэвэр хөрөнгийг нөхөн сэргээх төлөвлөгөө, эсвэл шинэчилсэн бизнес төлөвлөгөөг бий болгох ёстой. Аль ч

тохиолдолд төлөвлөгөөнд үйл ажиллагааны болон санхүүгийн зорилго, зорилтот огноо бүхий гүйцэтгэлийн жишиг үзүүлэлтүүдийг багтаасан байх ёстой. Консерватор дахь зээлийн хоршоог зөвхөн NCUA–ийн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн дараа, хүлээн авснаас хойш 12 сарын дотор хийсэн NCUA–ийн нэмэлт шалгалтын дараа л гишүүдэд буцааж шилжүүлж өгдөг. Консерваторын дараа дахин үйл ажиллагаа явуулах боломжгүй зээлийн хоршоог өөр зээлийн хоршоотой нэгтгэж эсвэл татан буулгадаг байна.

Тусгай ажиллагааны хэлтэст илгээгдэнэ гэдэг нь консерваторынхтой адил төрийн эрх мэдэлд шилжихэд хүргэдэггүй ч зээлийн хоршоог тогтворжуулах, мөн NCUSIF–ийн хөрөнгийг хамгаалах чиглэлээр ноцтой асуудлыг богино хугацаанд засаж залруулах хатуу арга хэмжээг NCUA–д хэрэгжүүлэх боломжийг олгодог. Үүнд хүчирхэг техникийн болон шийдвэр гаргах чадвар сайтай хянан шалгагчдыг зээлийн хоршоонд оруулах, томилогдсоноос хойш зургаан сарын дотор ашигтай ажиллах бизнес төлөвлөгөө боловсруулж, 23 сарын дотор 2–оос доошгүй хувийг дахин хөрөнгөжүүлэх зэрэг багтана. NCUA нь зээлийн хоршооны удирдлагыг чадварлаг менежерүүдээр сольж болно.

NCUA нь асуудалтай зээлийн хоршооны хэрэгцээ шаардлагад хариу өгөхийн тулд ямар арга хэмжээ авахаар шийдсэнээс үл хамааран түүнд олон төрлийн хөндлөнгийн оролцоо, арга хэрэгсэл багтааж болдог. Эдгээр нь бие даасан үйл ажиллагаа явуулах эсвэл өөр зээлийн хоршоотой нэгдэх оролдлого хийж дахин сэргээн байгуулагдаж буй зээлийн хоршоодод хамаарна. Эдгээр хөндлөнгийн оролцооны жишээнд:

- Хөрөнгийн худалдан авалт – Хөрөнгийн худалдан авалт нь тодорхой хөрөнгийг худалдан авахад NCUSIF-ийн санг ашиглахыг хэлнэ. Ер нь хэд хэдэн том зээл муудаж, зээлийн хоршоог тогтворгүй болгох магадлалтай бол NCUA эдгээр зээлийн хөрөнгийг худалдан авч зээлийн хоршоодын балансаас хасаж болно. Энэ нь зээлийн хоршооны нөхөн сэргэх чадварын үнэлгээнээс хамаарна.
- Бэлэн мөнгөний төлбөр – NCUSIF-ийн сангийн хөрөнгийг зээлийн хоршоодыг нэгтгэх, худалдан авах, хүлээн авах эсвэл төлбөрийн чадваргүй татан буулгахад туслах зорилгоор мөнгө хуваарилж болно. Мөн муу хөрөнгөжсөн зээлийн хоршоодыг нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусламж үзүүлэхийн тулд бэлэн мөнгөний төлбөр хийж болно.
- Charge to reserve – Энэ нь зээлийн хоршоонд хуваагдаагүй ашгийн алдагдлыг нөхөх, өөрөөр хэлбэл арилжааны алдагдлыг нөхөх зорилгоор нөөцөөс мөнгө шилжүүлэх боломжийг олгодог тул бэлэн бус тусламж юм. Хэрэв зээлийн хоршоод цэвэр хөрөнгийн капиталжуулалтын харьцаа 7 хувиас доош буурна гэж таамагласан байгаа бол нөөцийг сэргээхийн тулд NCUA-аас зөвшөөрөл авах шаардлагатай болдог.
- Зээлжүүлэлтийн баталгаат шугам – Энэ нь мөн бэлэн бус тусламж бөгөөд NCUA нь корпорацын зээлийн хоршоо эсвэл бусад зээлийн үйлчилгээ үзүүлэгчээс зээл авах баталгаа болдог. Энэ нь зээлийн үйлчилгээ үзүүлэгч нь ихэвчлэн зээлийн шугамыг сунгадаггүй тохиолдолд бэрхшээлтэй зээлийн хоршооны хөрвөх чадварыг бэхжүүлж чадна. Баталгаат зээлийн шугам хүлээн авсан зээлийн хоршоод төлбөрийн чадваргүй эсвэл хаагдах аюулд орсон байх ёстой. Баталгаат хугацаа нь хоёр жилээр хязгаарлагддаг.
- NCUSIF loan – NCUA нь хөрвөх чадварыг сайжруулах, зээлийн хоршоог дахин хөрөнгөжүүлэх болон урт хугацаанд оршиход нь туслах зорилгоор (харьяалал болон захиргаанд нь байдаг эсэхээс үл хамааран) зээлийн хоршоонд зээл олгохыг зөвшөөрч болно. Ийм зээл санхүүжилт эргэж бүрэн төлөгдөх ёстой.
- NCUSIF share deposit – NCUA нь хөрвөх чадварыг сайжруулах, зээл олгох, орлого бий болгох санхүүжилтийг тэтгэх, зээлийн хоршооны урт хугацааны тогтвортой байдалд туслах зорилгоор зээлийн хоршоонд хувьцаа хэлбэрээр хадгаламж байршуулах боломжтой.
- Subordinated loan – Зээлийн хоршоо нь урьдчилан тогтоосон, тодорхой, хэмжигдэхүйц зорилго, зорилтуудыг хангаж байгаа тохиолдолд зээлийн эргэн төлөлтийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь "incentive forgiveness – урамшууллаар өршөөх" нөхцөлийг багтаасан subordinated loan тусгайлсан хоёрдогч зээл олгохыг NCUA зөвшөөрч болно. Зорилго нь зээлийн хоршооны ашиг орлогыг нэмэгдүүлж, хөрөнгийн доод шаардлагыг хангах явдал юм.
- Өмнөх хуваагдаагүй ашгийн алдагдал (PUED) – NCUSIF-ийн баталгаат данс – Энэ нь хуваагдаагүй ашгийн алдагдалтай зээлийн хоршооны (алдагдал) сөрөг үлдэгдлийг PUED – NCUSIF баталгааны



данс руу шилжүүлэх боломжтой бэлэн бус тусламж юм. Энэ нь төлбөрийн чадваргүй зээлийн хоршоодод сэргэх бодит боломжийг олгож байна. Гэхдээ энэ арга хэмжээ нь 24 сараар хязгаарлагддаг бөгөөд энэ хугацаанд сөрөг үлдэгдлийг цэгцлэх ёстой.

- Орлогын шилжүүлгийн бууралт – Энэ нь зээлийн хоршоодод зохицуулалтын улирлын дүнгээс бага хэмжээгээр орлогоос капитал руу шилжүүлэх боломжийг олгодог. Энэ нь зээлийн хоршоодод ногдол ашгийн төлбөрөө хадгалж, хадгаламжийг ихээхэн хэмжээгээр буурахаас зайлсхийх боломжийг олгодог.
- Түр зуурын ногдол ашиг – Хуваагдаагүй ашгийн алдагдалтай (жишээ нь алдагдалтай) зээлийн хоршоод NCUA-ийн зөвшөөрөлгүйгээр хадгаламжаас ногдол ашиг олгох боломжгүй. Гэсэн хэдий ч хувьцааг /хадгаламжийг/ ихээхэн татахаас зайлсхийхийн тулд зээлийн хоршоодод боломжийн, зах зээлд чиглэсэн ногдол ашиг төлж, алдагдлыг PUED – NCUSIF баталгааны данс руу шилжүүлэх эрх олгож болно.
- Тогтворжуулахад чиглэсэн бүх арга хэмжээ нь зээлийн хоршоог тасралтгүй үйл ажиллагаа явуулахад чиглэсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулахаас хамаарна. NCUA-ийн эрх бүхий албан тушаалтны тэмдэглэсэнээр, нарийвчилсан, хүрч болохуйц зорилтуудыг агуулсан нөхөн сэргээх road map замын зураг хэрэгтэй байна. Хянан шалгагч нарт зориулсан NCUA гарын авлагад дурдсанчлан ердийн

замын газрын зураг буюу workout strategy, дараах зорилтуудыг агуулдаг:

- Чадварлаг удирдлага, боловсон хүчнийг авч үлдэх үүний төлөө ТУЗ хариуцлага хүлээдэг байх;
- Зээлийн хоршооны үндсэн үйл ажиллагааг бий болгох;
- Бүрэн бөгөөд ерөнхий дэвтрийн дансыг үнэн зөв тохируулсан энэ цагийн, үнэн зөв бүртгэлийг үүсгэх;
- Мэдээллийг бүрэн дүүрэн, шударга ил болгох заалтуудыг хангах;
- Бүх зардлыг хянаж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх;
- Зээлийн хоршооны зээлийн болон shares. шимтгэлийн орлого, үйл ажиллагааны зардлын бизнесийн стратегийг тодорхойлж, тэдгээрийг цэвэр хөрөнгийн нөхөн сэргээх төлөвлөгөө эсвэл бизнес төлөвлөгөөнд тусгах;
- Бүх түвшний боловсон хүчний дэмжлэгтэйгээр цэвэр хөрөнгийн нөхөн сэргээх төлөвлөгөө эсвэл бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Бүх арга хэмжээ, хөндлөнгийн оролцоог NCUA бүсийн хянан шалгагчаар хянагдаж, дагаж мөрдөгдөнө. Тогтворжуулахад 2 жилээс илүүгүй хугацаа шаардагдана; эсхүл NCUA ихэвчлэн зээлийн хоршоог нэгтгэх, худалдан авах эсвэл хүлээн авахыг эрэлхийлдэг. Хэрэв эдгээр сүүлийн арга хэмжээ нь хэрэгжих боломжгүй бол NCUA зээлийн хоршоог татан буулгах хүртэл арга хэмжээ авдаг байна.

Нэгдэх, худалдан авах болон хүлээн авах

Хэрэв зээлийн хоршоо бие даан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй бол

NCUA өөр зээлийн хоршоотой нэгтгэх, худалдан авах, эсвэл хүлээн авахаас өөр сонголтгүй байж болно. NCUA-аас гаргасан тайланд дурдсанаар эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан улам бүр нэмэгдэж буй зээлийн хоршоодыг дахин тогтвортой байлгахын оронд хооронд нь нэгтгэх шаардлага үүсэж байна.

Нэгдсэн тохиолдолд NCUA нь бүтэлгүйтсэн хоршооны үүргийг хүлээн авах тохиромжтой зээлийн хоршоог хайж олоход чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэнэ. NCUA нь хүлээн авагч зээлийн хоршооноос зохих шалгалтыг хийх боловч нэгдсэний дараах бизнесийн чадавхыг үнэлэхэд нь тусалдаг байна. Жишээлбэл, хойшлуулшгүй нэгтгэх эрх бүхий байгууллагын удирдлага дор жишээлбэл, нэгдэх нь ихэвчлэн хуулиар хязгаарлагддаг гишүүнчлэлийн өөр салбарт үйлчилдэг зээлийн хоршоотой тохиролцож болох бөгөөд энэ нь зээлийн хоршоог шинэ зах зээл, шинэ гишүүнчлэлийн бүлгүүдэд нээлттэй болгож өгдөг. Хүлээн авагч зээлийн хоршоо нь нэгдэх замаар хөрөнгөө нэмэгдүүлэх эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн зээлийн хоршоогоор дамжуулан нээгдсэн үйл ажиллагааны шинэ чиглэлд шилжих замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний багцаа төрөлжүүлэх боломжтой. Нэгдсэн хоршоодод туслахын тулд NCUA нь дээр дурдсан олон арга хэмжээг санал болгох боломжтой боловч NCUA-ийн эрх бүхий албан тушаалтны тэмдэглэснээр хүлээн авагч зээлийн хоршоо нь нэгдэхийг өсөлтийн боломж гэж үзвэл өөрийн хөрөнгийн бууралтыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болж магадгүй юм. Худалдан авалт ба assumption хариуцан хүлээн авах үйл ажиллагаа (P&A) нь нэгдэхээс ялгаатай нь зээлийн хоршоо нь зөвхөн тодорхой хөрөнгийг худалдан авч, зөвхөн тухайлсан өр төлбөрийг хүлээн авах бөгөөд энэ нь NCUA

зээлийн хоршоог татан буулгасны дараа share accounts-ийг хамааруулж ч болдог.

Худалдан аваагүй хөрөнгө болон өр төлбөрийг NCUSIF хариуцна. Практикт энэ нь хүлээн авагч зээлийн хоршоо нь хаагдаж байгаа зээлийн хоршооны алдагдлыг хариуцах шаардлагагүйгээр хаагдсан зээлийн хоршооны үйлчилдэг хэсэгт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг олгодог.

Байгууллагын тогтворжуулалтын сан

2009 оны эхээр зарим корпорацын зээлийн хоршоодын томоохон алдагдал хүлээсний дараа Зээлийн хоршоодын хөдөлгөөнийг бүхэлд нь тогтворжуулах өргөн хүрээнд NCUA-ийн Түр зуурын Корпорацын Тогтворжуулалтын Сан (Temporary Corporate Stabilisation Fund-TCSF) бий болсон. 2009 оны 5-р сард Конгрессын хуулиар байгуулагдсан TCSF нь корпорацын зээлийн хоршоод (төв зээлийн хоршоо, зээлийн хоршоодыг богино хугацааны хөрөнгө оруулалт эсвэл урт хугацааны хөрөнгө оруулалтаар хангадаг зээлийн хоршоод) дахь хувьцааг баталгаажуулж, NCUA-д корпорацын салбарыг тогтворжуулах зорилгоор АНУ-ын Холбооны Сангаас зээл авах боломжийг олгосон. TCSF нь өнөөг хүртэл аж ахуйн нэгжийн зээлийн хоршооны тогтолцооны доголдлоос урьдчилан сэргийлж чадсан бөгөөд энэ нь олон иргэний зээлийн хоршоод хөрөнгө оруулалтаа алдаж, хөрөнгийн дутагдалд ороход хүргэсэн байдаг. TCSF-ийг NCUA удирддаг боловч NCUSIF-ээс ялгаатай. Хувь хүний зээлийн хоршоод аж ахуйн нэгжийн алдагдлыг нөхөхийн тулд NCUSIF-ийн нэмэлт хураамж авдаг боловч хэрэв корпорацын салбар уналтад орсон бол үүнтэй адил албадан хураамж авдаггүй.



1.5 ТОГТВОРЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ

Тогтворжуулах хөтөлбөрүүд нь зээлийн хоршоодын аюулгүй байдал, тогтвортой байдал, гишүүдийн хадгаламжийн баталгааг хангахад ихээхэн хэмжээний санхүүгийн болон нөөцийн хөрөнгө оруулалтыг хийж оролцдог. Олон улс оронд тогтворжуулахад ихээхэн анхаарал хандуулах нь салбарын үр дүнтэй менежмент, урт хугацааны найдвартай байдалд чухал ач холбогдолтой гэж үздэг. Ийм учраас бүх жишээн дээр тогтворжуулах зардлыг зээлийн хоршоод өөрсдөө хариуцдаг байсан. Үүнд хөтөлбөрийн зохион байгуулалт, удирдлага, хяналт, шалгалт, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, түүнчлэн тогтворжуулалтын сангийн хөрөнгө оруулалт багтсан. Төлбөрийн аргууд нь харилцан адилгүй боловч зээлийн хоршоод бүхэлдээ салбарт хуримтлагдсан давуу талыг хүртэхийн тулд төлсөн шимтгэл, хураамж, торгуулийн холимгоос бүрддэг байв. Тогтворжуулахтай холбоотой бүх зардлыг зээлийн хоршоод өөрсдөө шууд хариуцаж байсан нь зээлийн хоршоодын тогтворжуулах хөтөлбөрт хэрхэн нийцэж байгаа эсэхэд хяналт тавихад нэлээд хатуу хандахаас өөр аргагүй байдалд хүргэдэг. Нэг гишүүн зээлийн хоршоо хүнд байдалд орж түүнд учирсан хохирлыг оролцогч бүх гишүүн зээлийн хоршоод хариуцахад хүргэдэг. Иймд зээлийн хоршоодыг хөтөлбөрт оролцох нөхцөлийг өндөр гүйцэтгэлийн стандартад нийцүүлэн ажиллуулах замаар алдагдал, үйл ажиллагааны зардлыг багасгах шаардлагатай байв.

Аливаа улс орны тогтворжуулалтын өртөг нь олон хүчин зүйлээс хамаардаг тул тогтворжуулах зардлыг яг таг тодорхойлох эсвэл өөр өөр улс орнуудын хооронд харьцуулалт хийх нь тийм ч хялбар биш юм. Тогтворжуулах зардал нь эцсийн дүндээ тус хөтөлбөрийг хэрхэн зохион байгуулж, удирдаж байгаагаас хамаарна. Хувьсах хүчин зүйлүүдэд хамрагдсан зээлийн хоршоодын тоо; тэдгээрийг газар дээр нь болон хөндлөнгөөс хянан шалгах арга зам; эдгээр шалгалтын давтамж, тэдгээрийн нарийвчлалын түвшин; хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын тоо, тэдний үр чадварын түвшин, мэргэшил, туршлага; үйл ажиллагааны зардлын түвшин; оффисын байршил зэрэг хөтөлбөрийн биет дэд бүтэц; холбогдох мэдээлэл технологийн түвшин; асуудалтай зээлийн хоршоодын үйл ажиллагааг тогтворжуулах, сэргээхэд хөрөнгө оруулах боломжтой хөрөнгө, хөрөнгө оруулалтын интервенцийн нөхцөл, сантай холбоотой хадгаламж эзэмшигчийн хамгаалалтын хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг багтаадаг. Гэхдээ хамгийн чухал хувьсагч нь тогтворжуулах ажлыг тухайн салбар дангаараа бие даасан хөтөлбөр болгон хэрэгжүүлдэг үү, эсвэл Засгийн газар нь зохицуулагч байгууллагад хариуцуулдаг уу, эсхүл түүнтэй хамтран ажилладаг уу үгүй юу гэдэг байж болох юм. Ирландад Ирландын Зээлийн Холбооны Лигээр бие даан удирдагддаг Хадгаламжийг хамгаалах бие даасан схем нь олон жилийн турш тогтворжуулах санг бүрдүүлж, зохион байгуулж, одоогийн байдлаар 110 сая

еврогийн хөрөнгийг бүрдүүлсэн байна. Энэ нь бүхэлдээ зээлийн хоршооны хадгаламжаар санхүүжигддэг бөгөөд хөрөнгө оруулалтын багц болон даатгалын орлогоор жил ирэх тусам нэмэгдсээр ирсэн. 2002 оноос хойш зээлийн хоршоод жил бүр 1000 € (£) хөрөнгө тутамд 58 цент/пенсийг тус санд төлж, дээд тал нь 64,000 хүртэл еврогийн хадгаламжийг даатгуулдаг.

Тогтворжуулах зардлыг энэ хураамж, төлбөр болон SPS-ийн хөрөнгө оруулалтын өгөөжөөс нөхдөг. 2008–2009 оны санхүүгийн жилд Ирландын лигийн сангийн хөрөнгө /Irish League/ 8 сая еврогоор өссөн гэж тооцоолсон боловч хөтөлбөрийн үйл ажиллагааны зардал нь 505 оролцогч зээлийн хоршоодод (14,000 сая еврогийн хөрөнгөтэй) хяналт тавихад ойролцоогоор 2 сая евро зарцуулсан байна.

Ямайка улсад нөхцөл байдал бага зэрэг төстэй байгаа бөгөөд Ямайкын хоршооллын зээлийн холбооны лиг /Jamaica Co-operative Credit Union League/ 2008 оны эцэс гэхэд 45 зээлийн хоршооныхоо 50,400 сая долларын хөрөнгийг хамгаалахын тулд 767.65 сая долларын (Ямайка) (5,7 сая фунт стерлинг) тогтворжуулалтын сан байгуулжээ. Тогтворжуулах зардлыг тус сангаас оруулсан хөрөнгө оруулалтын орлого, мөн зээлийн хоршоо бүр санхүүгийн жил бүрийн эцэст нийт гишүүдийнхээ хадгаламжийн 0.35%-ийг тус санд төлсөн хураамжаас бүрдүүлдэг. 2008 оны эцэст 60.2 сая доллар (£450,000 GBP) гарсан зардлыг тус санд ногдуулсан.

Гэсэн хэдий ч Ирланд, Ямайка зэрэг улсуудын бие даасан тогтворжуулах хөтөлбөрүүдэд хадгаламж эзэмшигчийн хамгаалалтын түвшин FSCS гэх мэт засгийн газрын хадгаламжийг хамгаалах хөтөлбөрүүдээс хамаагүй бага хэмжээтэй байдаг бөгөөд ихэнхдээ өөрийн үзэмжээр шийдвэрлэдэг

гэдгийг анхаарах нь чухал юм. Ирландад SPS хадгаламж эзэмшигчийн хамгаалалтыг ТУЗ-ийн үзэмжээр 13,500 еврог (10,000 фунт стерлинг) хүртэл хязгаарласан байдаг бөгөөд Ямайкад дампуурсан тохиолдолд хадгаламж эзэмшигчдэд төлөх төлбөрийн хэмжээ нь сангийн үнэ цэнээр хязгаарлагддаг бөгөөд урьдчилан тогтоосон тоогоор тогтоогдоогүй байна. Харин тухайн хоёр улсад тогтворжуулах сан байгуулагдсанаас хойш нэг ч зээлийн хоршоо дампуурч, дефолтод ороогүй. Гэсэн хэдий ч тухайн хоёр улсад сүүлийн үеийн Засгийн газрын хөндлөнгийн оролцооны үр дүнд зээлийн хоршоод хадгаламж эзэмшигчид даатгалд хамрагдаж, хадгаламж эзэмшигчид илүү өндөр хамгаалалттай болсон. Энэ нь зээлийн хоршоодод хяналт тавих нэмэлт шаардлага, төлбөрийг бий болгоно. Ямайкад зээлийн хоршоодыг Засгийн газрын хадгаламж эзэмшигчийн хамгаалалтын тогтолцоонд хамруулахын тулд даатгалд хамрагдах хадгаламжийн үнийн дүнгийн 0.15%-ийн жилийн нэмэлт хураамжийг төлсний үндсэн дээр хамруулах болно. Ирландад нэмэлт төлбөрийг хараахан тогтоогоогүй байна.

АНУ-д Үндэсний Зээлийн Хоршооны Захиргаа (National Credit Union Administration-NCUA) нь холбооны зээлийн хоршоодыг зохицуулж, хянадаг бөгөөд Үндэсний зээлийн холбооны хамтын даатгалын санг /NCUSIF-National Credit Union Share Insurance Fund/ ажиллуулдаг. Ирланд, Ямайкын уламжлалт байдлаас ялгаатай нь АНУ-д хоршоодыг тогтворжуулах нь засгийн газрын үүрэг хариуцлага гэж үздэг явдал юм. NCUA-ийн мэдээлснээр, 2008 оныг дуустал тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан нийт үйл ажиллагааны зардал нь ойролцоогоор 180 сая доллар (АНУ) бөгөөд



нийт хөрөнгө нь 856,600 сая доллар (АНУ) байжээ. NCUA-гийн тооцооллоор 180 сая долларын 62% нь shares/депозитын даатгалын удирдлагатай (шалгалтын хугацааны 62 хувь, шалгалтын хугацааны энэ хэсгийг зөвхөн даатгалтай холбоотой биш харин удирдахад шаардагдах хугацаа гэж үзсэний үндсэн дээр) холбоотой гэж үзсэн. Ерөнхийдөө NCUA-ийн тооцоолсноор уг хөтөлбөрийн удирдлагын зардал нь ойролцоогоор 5000 орчим зээлийн хоршоодын нийт хөрөнгийн 0.02%-тай тэнцдэг байна.

Их Британид тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлсэн төсөв санхүүжилт

Бүх хувьсагч, хүчин зүйлүүдийг харгалзан үзвэл үүнд хариулахад хялбар биш юм. Ер нь Ирланд, Ямайкин нэгэн адил салбарын бие даасан хөтөлбөрүүд нь оролцогч зээлийн хоршоодод бие даасан хатуу хяналт тавьдаг ба хадгаламж эзэмшигчийн хамгаалалтыг хангах бие даасан сантай байдаг нь Засгийн газрын зохицуулагчийн оролцоотой харьцуулахад зээлийн хоршоодод илүү их зардал гаргах магадлалтай. Үнэн хэрэгтээ олон улсын хэмжээнд АНУ-ын Ньюфаундленд, Лабрадор мужид байдаг шиг бие даасан схемээс төрийн зохицуулагчтай холбоотой тогтолцоо руу шилжих нь улам бүр нэмэгдсээр байна. Их Британид бол зохицуулалтын байгууллагын хяналт, FSCS-д хадгаламж эзэмшигчийн хамгаалалтад одоо байгаа оролцоог харгалзан үзвэл өөрчлөлт шилжилт хийх шалтгаан бага буюу жишээ нь ABCUL-аар дамжуулан өөрөө бие даасан тогтворжуулах хөтөлбөрийг бий болгох шаардлага байхгүй мэт эхэндээ санагдана.

Зардлыг үнэлэхдээ зээлийн хоршооны сайжруулалт шилжилтийн хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болох FSA, FSCS болон ABCUL-ийг оролцуулсан тогтворжуулах арга барилыг авч үзэх нь ашигтай бөгөөд үр дүнтэй байсан. Тогтворжуулах агентлагийг Засгийн газрын болон хувийн хэвшил зохицуулахаар авч үзэхэд аль алинд нь зохион байгуулалт, хууль эрх зүй, улс төрийн асуудлууд гарах нь ойлгомжтой. Гэсэн хэдий ч FSA, FSCS, ABCUL-ээс ТУЗ нь сонгогдож, тэдэнд үйл ажиллагаагаа тайлагнадаг агентлаг бий болно гэж төсөөлөхөд бэрх байсан. Уг агентлаг асуудалтай зээлийн хоршоодтой шууд хамтран ажиллах замаар FSA-д тавих хяналтыг сайжруулахад хувь нэмэр оруулж, тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ нь мөн зээлийн хоршоодыг бүтэлгүйтэх, төлбөрийн чадваргүй болохоос урьдчилан сэргийлэх замаар FSCS-ийн үйл ажиллагааг дэмжсэн. Зээлийн хоршоо бүтэлгүйтсэн ч гэсэн FSCS нь гишүүдийн хадгаламжийг хамгаалсан хэвээр байсан. Энэхүү нэгдсэн бүтэц нь мэдээжийн хэрэг FSA нь зохицуулалтын тайлан, зээлийн хоршоодтой хийсэн хяналт шалгалтаар дамжуулан олж авсан мэдээллээ тус шинээр байгуулагдсан агентлагтай хуваалцах хүсэлтэй, боломжтой эсэхээс хамаарах байсан. Эхэндээ үүнийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байсан ч эцсийн дүндээ хяналтын талаарх мэдээллийг хуваалцах нь зардлыг ихээхэн бууруулдаг. Тус агентлаг нь бие даан сэргээх, нэгтгэх эсвэл хяналт доор үйл ажиллагааг хаахын тулд асуудалтай зээлийн хоршоодтой хамтран ажиллах шинжээчдийн багийг ажиллуулсан бөгөөд үүнийг агентлагийн ТУЗ-д шууд ажлаа тайлагнадаг менежерээр ахлуулсан. Зардлыг бууруулахын тулд шинжээчдийн баг гэрээсээ ажиллаж, зээлийн

хоршоодын нөхцөл байдлыг FSA тайлан болон тухайн зээлийн хоршооноос нь шууд хүлээн авсан сар эсвэл улирлын тайлангуудыг хүлээн авах замаар үнэлсэн. Санхүүгийн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлснээр зардлыг бууруулсан боловч гараар зайлшгүй хийгдэх систем буюу шинжилгээ дээр энэ нь боломжгүй байсан.

Шинжээчид зээлийн хоршоодод очиж өрсөлдөх чадварыг тодорхойлж, зээлийн хоршооны нөхцөл байдал, удирдлагын чадавхыг баталгаажуулж, зохион байгуулалт, санхүүгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд зээлийн хоршоодтой хамтран ажилласан.

Хөтөлбөрийн зардлыг өгөгдсөн хүчин зүйл, хувьсагчдын хүрээнд харгалзан үзэж яг таг тооцоолоход маш хүндрэлтэй байдаг.

Гэхдээ ижил тооны зээлийн хоршоодтой хэдий ч Ирланд улс дахь нөхцөл байдал нь өвөрмөц онцлогтой байсан байж магадгүй юм.

Учир нь ижил тооны зээлийн хоршоодтой боловч Их Британид 593 сая фунт стерлингийн хөрөнгөтэй байхад Ирланд улс 14,000 сая еврогийн хөрөнгөтэй атлаа тогтворжуулах хөтөлбөрийн зардал нь ойролцоогоор 1.8 сая фунт стерлинг гарчээ.

Ирландад байдагтай харьцуулахад хамаагүй жижиг зээлийн хоршоодын хяналт нь бага ачаалалтай, хурдан гүйцэтгэх шаардлагатай тул Их Британийн тогтворжуулах хөтөлбөрийг жилд 1 сая орчим фунт стерлингээр санхүүжүүлж, зохион байгуулсан. Үнэн хэрэгтээ энэ нь таван жилийн хугацаанд зээлийн хоршоодын санхүүгийн үйлчилгээний нөхөн олговрын схемийг /Financial Services Compensation Scheme/ тэтгэж, хүргэхэд зарцуулсан 6 сая фунт стерлингийн бодит зардалтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт байсан.

2004–с 2009 оны Тогтворжуулах хөтөлбөрийн эхний санхүүжилтийг нь Засгийн газрын буцалтгүй тусламж болон зээлийн хоршоодын хадгаламжийн тодорхой хувиар бүрдүүлсэн. Энэ нь анхны захиргааны зардал болон тогтворжуулах хүсэлтүүдийг санхүүжүүлсэн байна. Зардлыг анхны санхүүжилтийн хөрөнгө оруулалтаас авсан хүү болон шаардлагатай бол дараагийн хураамжаас санхүүжүүлсэн. Жилд 1 сая фунт стерлингийг бүрэн нөхөхийн тулд хадгаламжийн анхны хураамжийг 0.2% орчимд тогтоосон байна.



1.6 ДҮГНЭЛТ

Зээлийн хоршоог тогтворжуулах хөтөлбөрийг аль ч улсад шууд амжилттай хэрэгжүүлэх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Зээлийн хоршоод нь хөгжлийнхөө тодорхой түүхэн үйл явцын үр дүнгээс хамаардаг бөгөөд олон улсын жишигт нийцсэн тогтворжуулах хөтөлбөрийг шууд хэрэгжүүлэхэд тодорхой бэлтгэл ажлыг хангасан байх ёстой. Тогтворжилтын зохицуулалтад элсэх, оролцох үндсэн стандартыг хангаж чадаагүй зээлийн хоршоод зах зээлд хэтэрхий олон байдаг. Өөр нэг саад бэрхшээл нь мэдээжийн хэрэг тогтворжуулах системийг хэрэгжүүлэх зардал юм. Хэрэв тогтворжуулах хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлбэл зээлийн хоршоод өөрсдөө төлбөр, хураамжийн системээр дамжуулан зардлыг нөхөх ёстой болдог. Энэ нь хоршоодыг сэргээх, шилжүүлэх үйл ажиллагаанд санхүүгийн нэмэлт дарамт болох нь дамжиггүй.

Засгийн газар оролцохын тулд Их Британийн FSA болон FSCS-ийн үзэж байгаагаар зээлийн хоршоод нь үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах томоохон санхүүгийн хөрөнгө оруулалтыг олж, хүртэхийн тулд үндэсний эдийн засагт илүү чухал санхүүгийн байгууллага болох ёстой. Зээлийн хоршоод, зарим нь хэт том, нөгөө нь өчүүхэн жижиг байдаг. FSCS-ийн сонгосон аргачлал /pay-out box/ нь илүү хямд сонголттой бөгөөд урт хугацаанд үйлчлэх боломжтой байна. Дэлхийн хэмжээний судалгаануудад зээлийн хоршооны амжилтад тогтворжуулах тогтолцоо чухал ач холбогдолтойг нотлон харуулсан. Чухам ийм шалтгаанаар WOCCU нь Узбекистан, Польшийн шинээр сэргэж гарч ирж буй тогтворжуулах хөтөлбөрүүдийг хөгжүүлэхийг нэн тэргүүнд тавьж чухалчилсан байдаг. Учир нь тогтворжилтын хатуу чанга нөхцөл, стандарт нь сайн засаглал, үр дүнтэй менежментийг бий болгодог тул гишүүдийн хадгаламжийн сүүлчийн найдвартай хамгаалагч болдог. Их Британид хоршооны салбарынхаа ирээдүйг харахын тулд тогтворжуулах хөтөлбөр боловсруулах асуудлыг зайлшгүй хэлэлцэх ёстой болсон. ABCUL /Assosation of British Credit Unions Limited/ нь олон улсын туршлагад үндэслэн гишүүддээ үзүүлж буй сургалт, дэмжлэгийн хэмжээнээс үл хамааран зээлийн хоршооны урт хугацааны ирээдүйтэй, тогтвортой хөгжилд хамгийн их хувь нэмэр оруулж чадах арга бол тогтворжуулах хөтөлбөр гэж тодорхойлсон байдаг.

Олон улсын хэмжээнд бие даасан арилжааны холбооны схемээс /trade association schemes/ татгалзаж Зохицуулах болон Засгийн газрын хадгаламж (депозит) хамгаалах тогтолцоонд шилжиж байна. Тогтворжуулах хөтөлбөрүүд гишүүнчлэлийн шаардлагын нөхцөл болгон бүх зээлийн хоршоод PEARLS хяналтын системд хамрагдахын тулд сар бүр тайлангаа ирүүлэхийг шаарддаг.

Хөтөлбөрүүдийн зөвлөмжид стандартууд нь өөрөө хоршоодын сайжралтыг бэхжүүлэхэд түлхэц болно гэж үзэж санал болгодог хэдий ч үүний үр дүнд хоршоод хоорондоо нэгдэж нийлэх, хаагдах үйл явц нэмэгдэх нь бас эрчимжих магадлалтай гэдгийг хүлээн зөвшөөрөх

хэрэгтэй болдог. Гэсэн хэдий ч зах зээлд тэсэж үлдсэн зээлийн хоршоод нь илүү хүчтэй, тогтвортой байгууллагууд болж хөгждөг байна.

Манай улсын ХЗХ-ны салбарт зохистой харьцааны 12 шаардлага үзүүлэлтийг хэрэгжүүлж байгаа бол 2009 онд WOCU-гаас ХЗХ-дод санал болгосон зохистой харьцааны 45 үзүүлэлт шаардлагыг санал болгосон байдаг бөгөөд тогтворжуулах хөтөлбөр, тогтолцоог хэрэгжүүлэхтэй холбоотой одоогийн мөрдөгдөж байгаа шаардлага, стандартыг хөгжүүлж, өргөжүүлэх шаардлагатай тулгарч байна.

1.7 САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дараах зөвлөмжүүдийг ABCUL-ийн зүгээс Их Британийн зээлийн хоршоодод тогтворжуулах зарчмуудыг дэмжих зорилготой гаргасан байдаг.

Зээлийн хоршоодын хувьд:

1. Улирал, жилийн тайланг ирүүлэхгүй байх зэрэг зохицуулалтын шаардлагаас хазайсан тохиолдолд бүх зээлийн хоршоод маш нухацтай хандах ёстой.
2. Зээлийн хоршоод санхүүгийн нягтлан бодох бүртгэлд ил тод байх соёлыг төлөвшүүлж, санхүүгийн гүйцэтгэлд хатуу хяналт тавих ёстой. Тэд бусад зээлийн хоршоодын санхүүгийн үзүүлэлттэй харьцуулах боломжтой байж, үүнийг сайшаах дэмжих зохицуулалттай байх ёстой.
3. Удирдлагын баг нь сар бүрийн удирдлагын дансыг үнэн зөв, цаг тухайд нь бүх ТУЗ-ийн хуралд оруулж танилцуулж байх ёстой. Тэд PEARLS гэх мэт санхүүгийн зорилтот зохистой харьцааны дагуу санхүү болон үйл ажиллагаанд гарсан ахиц дэвшлийг тогтмол үнэлж байх ёстой.
4. Зээлийн хоршоод хөрөнгийн шаардлагын дэлхийн стандартууд нь Их Британийн 1-р зэрэглэлийн зээлийн хоршоодод тавигддаг FSA-ын шаардлагаас өндөр байгааг мэдэх ёстой. 1-р зэрэглэлийн зээлийн хоршоо нь Санхүүгийн үйлчилгээний газраас тогтоосон хөрөнгийн доод стандартыг давуулан хангахыг эрмэлзэх ёстой. Хэрэв өөрийн хөрөнгийн харьцаа 3 хувиас доош унавал зээлийн хоршоод яаралтай техникийн туслалцаа авч, нөхөн сэргээх төлөвлөгөө гаргах хэрэгтэй.
5. Санхүүгийн харьцааны дүн шинжилгээгээр өгөгдсөн чиг хандлагын мэдээлэлд үндэслэн



асуудалд орсон зээлийн хоршоод хугацаа алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд эртнээс арга хэмжээ авч, бусад зээлийн хоршоо, худалдааны холбоо, Санхүүгийн үйлчилгээний газар /FSA– Financial Services Authority/ болон бусад зээлийн холбоог дэмжих байгууллагаас тусламж хүсэхэд бэлэн байх ёстой.

6. Өөрийн хөрөнгө/нийт хөрөнгийн харьцаа (эрсдэлээр жигнэсэн) 3%–аас бага болсон зээлийн хоршоод гурван улирал дараалан энэ харьцааг сайжруулж чадахгүй гэж үзвэл өөр зээлийн хоршоотой нэгдэх санхүүгийн тусламж хүсэх хэрэгтэй.
7. Зээлийн хоршоод бүтэлгүйтсэн тохиолдолд pay–out box болгон FSCS–д найдах замаар санхүүгийн хатуу хяналт, дүн шинжилгээ, менежментийг алдагдуулах ёсгүй. Зээлийн хоршоод тухайн нэг хувийн зээлийн хоршооны нэр хүндэд учирсан нэр хүндийн асуудал бүхэл бүтэн зах зээлд нөлөөлж түүнийг харлуулж болзошгүй гэдгийг ойлгож ухаарах хэрэгтэй гэж зөвлөжээ.

Зохицуулагч байгууллагын хувьд

8. ABCUL зээлийн хоршоог үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах ёстой боловч зөв зохистой, тэнцүү /proportional/ зохицуулалтын төлөө компани үйл ажиллагаа явуулах ёстой.
9. ABCUL ирээдүйд нэр төртэй хаагдах эсвэл нэгдэхийг эрмэлзэж буй асуудалтай зээлийн хоршоодод зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ёстой. ABCUL санхүүгийн хүнд хэцүү нөхцөлд хоршоогоо хаах нь эсвэл хүчирхэг өөр хоршоотой нэгдэх шийдвэр нь зээлийн хоршооны гишүүдэд өөрчлөлт, шилжилтийн хамгийн сайн ашиг сонирхолд нийцэх хувилбар шүү гэдэг ойлголтыг гишүүддээ ухамсарлуулах ёстой.
10. ABCUL PEARLS хяналтын систем болон орох өгөгдлийг /input data/ сар бүр гишүүддээ үйлчилгээ болгон санал болгосоор байх ёстой.
11. ABCUL асуудалтай зээлийн хоршоодод туслах чадвартай, мэргэшсэн, чадварлаг техникийн болон бизнесийн шинжээчийг бүрдүүлж, тэдэнд хандах боломжтой байх баталгаагаар гаргах ёстой. Эргээд эдгээр шинжээчдийн зардлыг зээлийн хоршоодод нөхөх боломжтой байх ёстой.
12. ABCUL өөрийн хөрөнгө/нийт хөрөнгийн харьцаа 3%–аас бага болсон, мөн энэ харьцааг гурван улирал дараалан сайжруулж чадахгүй гэж үзсэн зээлийн хоршоодыг бусад зээлийн хоршоотой нэгдэхэд нь санхүүгийн тусламж авахыг дэмжих ёстой.
13. ABCUL зохицуулах байгууллага аливаа санаачилга гаргахад зээлийн хоршоодын оролцоо болсон одоогийн санхүүгийн хатуу хяналт, зохицуулалтын шаардлагыг хангахаас хамаарна гэдгийг баталгаажуулах ёстой.

14. Урт хугацаанд Зээлийн хоршоодыг тогтворжуулах агентлаг байгуулах талаар ABCUL Засгийн газартай хэлэлцээ хийх ёстой. Энэ нь Засгийн газраас ивээн тэтгэдэг байгууллага байж болох ч FSA, ABCUL болон холбогдох салбартай хамтран ажиллана. Үүнийг FSCS эсвэл түүнтэй адилтгах системд нэгтгэж эсвэл хамтран ажиллах боломжтой.
15. FSA улирал, жилийн тайлангаар дамжуулан зээлийн хоршоодын гүйцэтгэлд илүү үр дүнтэй хяналт тавьж, зээлийн хоршооны одоо байгаа зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөхийг улам бүр чангатгах ёстой.
16. FSA зээлийн хоршоодтой хамтран улирал тутам тайлангаа үнэн зөв гаргаж өгсөн эсэхийг баталгаажуулах ёстой. Зээлийн хоршоод улирлын тайланд нь FSA-аас онцлон тэмдэглэсэн аливаа бэрхшээл, дутагдлыг залруулах, сайжруулах талаар санал хүсэлтийг хүлээн авах ёстой.
17. FSA санхүүгийн сул байгууллага гэж тодорхойлогдсон зээлийн хоршоодод анхаарлаа төвлөрүүлж, төлбөрийн чадваргүй болохоос сэргийлэх интервенц, шаардлагатай арга хэмжээг дэмжих ёстой. Энэ нь бүх нийтийн дагаж мөрдөх ёстой босго, хил заагийг өсгөн нэмэгдүүлэхээс хамаагүй илүү үр дүнтэй хөндлөнгийн оролцох арга гэж үнэлэгддэг.
18. Засгийн газар FSA, FSCS, ABCUL болон холбогдох салбартай хамтран зээлийн хоршоог тогтворжуулах агентлагийг хөгжүүлэх замаар зээлийн хоршооны салбарыг бэхжүүлэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.
19. Зээлийн хоршоодын нэгдлийг дэмжих зорилгоор Зээлийн хоршоодын тогтворжуулалтын санг Засгийн газар байгуулах ёстой бөгөөд ингэснээр тэд FSCS-ийн хөрөнгийг бүтэлгүйтсэн зээлийн хоршоодынх гэж дуудах шаардлагагүй болно. Энэ сангийн хөрөнгийг нэгдэхээс өмнөх асуудалтай зээлийн хоршоодын муу, үр ашиггүй хөрөнгийг (зээл) худалдан авахад ашиглаж болно.



Хүснэгт 1: WOCCU-гаас санал болгосон зохистой харьцааны PEARLS үзүүлэлт.

| AREA | PEARL | DESCRIPTION | GOALS (EXCELLENCE) |
|----------------------------------|-------|--|-------------------------|
| P = PROTECTION | P1 | Allowance for Loan Losses / Delinquency > 12 months | 100% |
| | P2 | Net Allowance Tor Loan Losses / Delinquency 1-12 months (WOCCU Standard) | 35% |
| | P2X | Net Allowance for Loan Losses / Delinquency 1-12 months (User Defined) | 100% |
| | P3 | Complete Charge-Off of Delinquent Loans >12 mos | Yes |
| | P4 | Annual Loan Charge-offs / Average Loan Portfolio | Minimized |
| | P5 | Accumulated Loan Recoveries/Accumulated Loan Charge-offs | >75% |
| | P6 | Solvency | Min 111% |
| E= EFFECTIVE FINANCIAL STRUCTURE | E1 | Net Loans: Total Assets | 70-80% |
| | E2 | Liquid Investments / Total Assets | Max 16% |
| | E3 | Financial Investments / Total Assets | Mix 2% |
| | E4 | Non-Financial Investments / Total Assets | 0% |
| | E5 | Savings Deposits / Total Assets | 70-80% |
| | E6 | External Credit / Total Assets | Max 5% |
| | E7 | Member Share Capital / Total Assets | Max 20% |
| | L8 | Institutional Capital / Total Assets | Min 10% |
| | E9 | Net Institutional Capital / Total Assets | Min 10% |
| A = ASSET QUALITY | A1 | Total Loan Delinquents / Cross Loan Portfolio | ≤5% |
| | A2 | Non-Earning Assets / Total Assets | ≤5% |
| | A3 | Net Institutional & Transitory Capital + Non Interest-Bearing Liabilities / Non-earning Assets | >200% |
| AREA | PEARL | DESCRIPTION | NORM |
| R = RATES OF RETURN & COSTS | R1 | Net Loan Income / Average Net Loan Portfolio | Entrepreneurial Rate |
| | R2 | Total Liquid Investment Income/ Average Liquid Investments | Market Rates |
| | R3 | Total Financial Investment Income / Average Financial Investments | Market Rates |
| | R4 | Total Non-Financial Investment Income/ Average Non-Financial Investments | >= R1 |
| | R5 | Total 1 interest Cost on Savings Deposits / Average Savings Deposits | Market Rates >Inflation |
| | R6 | Total Interest Cost on External Credit / Average External Credit | Market Rates |

| | | | |
|---------------------|-----|--|---------------------------------|
| | R7 | Total Interest (Dividend) Cost on Shares / Average Member Shares | Market Rates > = R5 |
| | R8 | Total Gross Income Margin / Average Total Assets | Amount Needed to Cover R10, R12 |
| | R9 | Total Operating Expenses / Avg. Total Assets | <= 5% |
| | R10 | Total Loan Loss Provision Expense / Average Total Assets | Dependent on Delinquent Loans |
| | R11 | Non-Recurring Income or Expense / Average Total Assets | Minimum |
| | R12 | Net Income / Average Total Assets (ROA) | Dependent on E8 |
| | R13 | Net Income / Avg. Institutional + Avg. Trans Capital (ROC) | > Inflation Rate |
| L = LIQUIDITY | L1 | S.T Investments + Liquid Assets – S.T. Payables / Savings Deposits | Min 15% |
| | L2 | Liquidty Reserves / Savings Deposits | 10% |
| | L3 | Non-Earning Liquid Assets / Total Assets | <1% |
| S = SIGNS OF GROWTH | S1 | Growth in Loans to Members | Dependent on E1 |
| | S2 | Growth in Liquid Investments | Dependent on E2 |
| | S3 | Growth in Financial Investments | Dependent on E3 |
| | S4 | Growth in Non-Financial Investments | Dependent on E4 |
| | S5 | Growth in Savings Deposits | Dependent on E5 |
| | S6 | Growth in External Credit | Dependent on E6 |
| | S7 | Growth in Share Capital | Dependent on E7 |
| | S8 | Growth in Institutional Capital | Dependent on E8 |
| | S9 | Growth in Net Institutional Capital | Dependent on E9 |
| | S10 | Growth in Membership | Minimum 15% |
| | S11 | Growth in Total Assets | > inflation + 10% |



Хүснэгт 2: Дотоодын ХЗХ-дын сангуудын үзүүлэлт.

| Тэр бум ₮/ | 2020 II | 2020 III | 2020 IV | 2021 I | 2022 II | 2021 III | 2021 IV | 2022 I | 2022 II | 2022 III | 2022 IV | 2023 I | 2023 II |
|------------------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | 45.5 | 47.5 | 49.5 | 51.1 | 55.9 | 60.8 | 63.9 | 65.7 | 53.5 | 56.1 | 59.8 | 59.4 | 61.6 |
| ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ | 18.2 | 18.3 | 18.5 | 21.3 | 22.6 | 25.7 | 25.4 | 26.4 | 26.1 | 26.1 | 25.9 | 26.6 | 27.2 |
| ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ | 27.1 | 29.0 | 30.7 | 29.6 | 33.0 | 34.8 | 38.4 | 39.1 | 27.2 | 29.9 | 33.7 | 32.6 | 34.2 |
| Хадгаламж, хамгаалалтын сан | 1.8 | 1.9 | 1.9 | 2.1 | 2.2 | 2.2 | 2.3 | 2.6 | 2.6 | 2.6 | 2.6 | 2.8 | 2.9 |
| Тогтворжилтын сан | 1.8 | 1.8 | 1.9 | 2.1 | 2.1 | 2.2 | 2.2 | 2.6 | 2.6 | 2.6 | 2.6 | 2.8 | 2.8 |
| Хадгаламж | 163.4 | 163.6 | 182.2 | 201.4 | 191.2 | 203.8 | 203.6 | 202.1 | 189.4 | 189.8 | 187.5 | 191.5 | 203.9 |
| ҮАЗ | 6.0 | 8.5 | 11.5 | 3.3 | 6.1 | 8.8 | 12.2 | 3.8 | 7.3 | 10.6 | 14.2 | 4.1 | 8.1 |
| Нийт хөрөнгө | 234.4 | 234.3 | 256.0 | 278.9 | 270.5 | 289.4 | 291.2 | 291.3 | 271.6 | 266.7 | 267.7 | 274.5 | 295.9 |

II. ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН САН

2.1. УДИРТГАЛ

Сүүлийн хорин жилийн хугацаанд системчилсэн банкны салбарын хямралын давлагаа дэлхий даяар тодорхой давтамжтай нүүрлэж байна. Энэхүү хямралын давлагаа нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудыг адилхан дайрч, дэлхийн 93 оронд системийн хямралын 112 тохиолдол, 46 улсад 51 удаа дотоод хямралын тохиолдол гарсан.

Томоохон хэмжээний банкны хямралын тархалт нь тасалдал үүсгэдэг бөгөөд зардал ихтэй байдаг. Хадгаламж эзэмшигчид мөнгөө авах боломжоо алдаж, сайн зээлдэгчид зээл авах боломжоо алдаж, бүр дампууралд өртөж, зарим сайн хоршоод үйл ажиллагаагаа зогсоож болзошгүй нөхцөл байдалд хүрдэг. Өр болон хөрөнгийн хэрэгсэл гаргагчид зах зээл ширгэж байгааг анзаардаг. Татвар төлөгчдөд зориулж ихэвчлэн эдгээр тасалдлыг бууруулах томоохон хуулийн төслийг боловсруулж танилцуулдаг. Эдгээр хямралын зардал нь төсвийн шууд зардлаас давж, тогтворжуулах хөтөлбөрүүдийг алдагдуулж, өсөлтийн удаашрал, ядуурлыг нэмэгдүүлэх зэрэг үр дагавруудыг агуулдаг.

Гэсэн хэдий ч 1997 оны Тайланд, Солонгосын хямралын үеэр гарсан төсвийн нийт зардал ДНБ-ий 30 хувиас давж, Индонезид төсвийн зардал ДНБ-ий 50 хувьд хүрчээ. Хямрал банкны салбараас хальж тархвал санхүүгийн салбарын бүрэн хямралыг өдөөдөг. Үүний хамгийн ойрын жишээ бол банкны системийн сул талууд нь бусад дотоодын санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийн хямралыг өдөөж, гадаадын

капиталыг их хэмжээгээр урсгаж, валютын хүчтэй хямралд хүргэсэн Турк улсын жишээ юм. Аливаа улс орны бодлого боловсруулагчид системийн эрсдэлийг багасгах, тасалдал, төсвийн зардлыг хязгаарлахын тулд санхүүгийн аюулгүй байдлын сүлжээг бий болгодог. Аливаа улсын аюулгүй байдлын сүлжээ нь тасалдлыг бууруулах санхүүгийн бодлогын багцаас бүрддэг. Эдгээр бодлогод далд болон нээлттэй хадгаламжийн даатгал /lender-of-last-resort буюу LoR/, Төв банкаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хямралтай холбогдуулан хамгийн сүүлийн удаа зээл авах эрх, банкны төлбөрийн чадваргүй байдлыг шалгах, шийдвэрлэх журмыг боловсруулж, мөн ОУВС зэрэг үндэстэн дамнасан байгууллагуудаас яаралтай тусламж авах боломжтой арга хэмжээнүүд багтдаг.

Аюулгүй байдлын сүлжээний бодлогын дотор хадгаламжийн даатгалыг ашиглах нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж, түгээмэл ажиглагдах болов. Хүснэгт 1-ээс харахад сүүлийн 26 жилийн хугацаанд хадгаламжийн даатгалаар тодорхой баталгаа гаргаж буй орнуудын тоо бараг гурав дахин өссөн байна. Хадгаламжийн даатгалын баталгааны тогтолцоог бий болгох нь гаднын мэргэжилтнүүдийн хөгжиж буй орнуудад өгдөг санхүүгийн бүтцийн талаар өгдөг гол бодлогын зөвлөгөө болсон (Folkerts Landau, Lindgren, 1997; Garcia, 1999). 1994 онд хадгаламжийн даатгалыг Европын холбооны шинээр бий болсон банкны нэгдсэн зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.



Өнөөдөр ЭЗХАХБ-ын ихэнх орнууд болон хөгжиж буй орнуудад хадгаламж эзэмшигчийн тодорхой хамгаалалт ямар нэг хэлбэрээр хэрэгжиж байна. Хадгаламжийн даатгалын тодорхой схемүүд яагаад бодлого боловсруулагчдын анхаарлыг татдагийг ойлгоход хэцүү биш юм. Богино хугацаанд төсөвт яаралтай зардал гаргах шаардлагагүй тул банк дампуурах болон, эсвэл сандрах нөхцөл байдал үүсгэсэн асуудлын үед түүнийг шийдвэрлэх зардал багатай шийдэл юм. Даатгалын тогтолцоо нь санхүүгийн салбарыг тогтворжуулахаас гадна улс төрийн ашиг тустай байдаг. Үүнд: жижиг хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, депозитийг хамгаалахын тулд жижиг санхүүгийн байгууллагуудыг томоохон байгууллагуудтай өрсөлдөх боломжийг сайжруулж, хөгжүүлдэг.

Бодлого боловсруулагчид голдуу үгүйсгэж, үл ойшоох шинжтэй байсан ч эрдэмтэн судлаачид эртнээс түүнийг хүлээн зөвшөөрч, ач холбогдлыг нь тууштай онцгойлж ирсэн нь хадгаламжийн даатгал нь банкны эрсдэлийг өөртөө шингээж, бууруулах чадвартай байдаг. Нөгөөтээгүүр, Хадгаламж эзэмшигчдийнх нь банкнуудыг хянах хүсэл эрмэлзлийг бууруулдаг тул хадгаламжийн даатгал нь хэт их эрсдэл хүлээх, өөрөөр хэлбэл ёс суртахууны аюулыг бий болгож, банкны бодлогогүй үйлдлүүдийг урамшуулах талтай. Гэхдээ хадгаламжийн тодорхой төрлийн даатгалыг бий болгохыг дэмжсэн хамгийн үнэмшилтэй аргуудын нэг нь үүнийг төрөөс хадгаламж эзэмшигчдэд үзүүлэх төлбөрийн хариуцлагыг хязгаарлах арга гэж танилцуулж болох явдал юм. Даатгалын тогтолцоонд даатгалд хамрагдах хязгаарлалт байхгүй тул хадгаламж эзэмшигчид татвар

төлөгчдөд хадгаламжийн баталгааг шууд хязгааргүй нийлүүлэхэд хүргэх хангалттай улс төрийн дарамт шахалт үзүүлэх боломжтой. Ийм хүлээлт нь ёс суртахууны аюулыг бий болгодог.

АНУ бол хадгаламжийн даатгалын үндэсний тогтолцоог нэвтрүүлсэн анхны улс орон юм. Түүний зорилго нь жижиг хадгаламж эзэмшигчдийг хамгаалахаас илүүтэй банкны хадгаламжийн хөрвөх чадварт итгэх итгэлийг сэргээх явдал байсан (Голембе, 1960). Үнэн хэрэгтээ жижиг хадгаламж эзэмшигчдийг хамгаалах өөр арга хэрэгсэл аль эрт хүлээн зөвшөөрөгдсөн байсан. Жишээлбэл, Европт хадгаламжийн банкнууд найдвартай санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийснээр хөрвөх чадвараа хадгалж байв. Хэдэн арван жилийн мэтгэлцээн, төрийн хэмжээний түвшинд ёс суртахууны гажуудлын сөрөг туршлагын үр дүнд мөн банкны хямралын үеэр 1933 онд АНУ-ын холбооны хадгаламжийн даатгал байгуулагдсан. Байгуулагдсанаасаа хойших эхний дөчин жилийн хугацаанд томоохон байгууллагуудын дунд ямар нэгэн доголдол гараагүй нь банкны хямралаас урьдчилан сэргийлэх хямд арга хэрэгсэл бол хадгаламжийн даатгал гэж төөрөгдүүлэхэд хүргэсэн.

Гэвч 1980-аад онд Хадгаламж, зээлийн даатгалын эмх замбараагүй байдал гарах болсон нь энэхүү хуурмаг байдлыг арилгаж, хадгаламжийн даатгал нь татвар төлөгчдийн мөнгөөр даатгуулсан байгууллагууд эрсдэл үүрснээс болж алдагдалд хэрхэн өртөж байсныг илчилсэн юм.

Орчин үеийн онолчид хадгаламжийн даатгалын загварыг олон талт оролцогчдын үндсэн төлөөлөгчийн гэрээний асуудал гэж

үздэг (Kane, 1995; Calomiris, 1996). Хэлэлцэн тохирогч талууд нь банк, хадгаламж эзэмшигч, хянагч, улс төрчид, татвар төлөгчдөөс бүрдэнэ. Даатгуулсан санхүүгийн байгууллага татвар төлөгчдөд хохирол учруулах үйл явдал нь хяналт шалгалтын сул үед тухайн байгууллагын алдагдлыг хувьцаа эзэмшигчийн оруулсан цэвэр хөрөнгөөс давсан тохиолдолд татвар төлөгчдийн хөрөнгөөр барагдуулах үүрэг хариуцлага ирэхэд тохиолдоно.

Ирээдүйд татвар төлөгчдөд учирч болзошгүй хохирлыг бууруулахын тулд өндөр хөгжилтэй орнуудын эрх баригчид эрсдэлд суурилсан хөрөнгийн стандартыг тогтоож, зохицуулалтаас үүдэлтэй инновац нь үр нөлөөг нь сулруулж байгаа тохиолдолд эдгээр стандартыг дахин тохируулахаар тогтсон. АНУ-д 1991 оны Холбооны Хадгаламжийн Даатгалын Корпорац (FDIC)-ийг сайжруулах тухай хууль нь бүр ч илүү урагшилж, АНУ-ын зохицуулагчид хөрөнгийн стандартын зөрчлийг шийдвэрлэхийн тулд яаралтай арга хэмжээ авах үүрэг хүлээсэн. 1993 онд Конгресс Хадгаламж эзэмшигчдэд давуу эрх олгох тухай хуулийг баталж, АНУ-ын татвар төлөгчдөд нэмэлт хамгаалалтыг санал болгосон бөгөөд энэ нь ирээдүйд банкнуудыг татан буулгах үед хадгаламжгүй зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг FDIC-ийн нэхэмжлэлд

хамааруулахаар тогтсон. Хадгаламжийн даатгалын тодорхой тогтолцоог нэвтрүүлэх эсэх, түүнийг хэрхэн төлөвлөх нь түүний ажиллах ёстой санхүүгийн болон хяналтын орчноос хамаарна. Тогтвортой байдал ба ёс суртахууны аюулын хоорондох боломжит солилцоог харгалзан улс хоорондын туршлагаас авсан эмпирик заавар нь маш ашигтай байдаг. Зураг 1-ээс харахад бодлого боловсруулагчид маш хурдан амжилттай урагшилж байгааг харуулж байна. Хадгаламжийн даатгалд хамрагдахыг зөвлөдөг мэргэжилтнүүд улс орнуудыг зохих тохирох байгууллагын дэд бүтэцтэй байсан нь дээр гэж үздэг бөгөөд гэрээ байгуулах орчны төгс бус байдлын нөлөөллийг үл хайхардаг.

Мэргэжилтнүүдийн зөвлөгөөг сайтар тайлбарласан улс хоорондын харьцуулсан эмпирик нотолгоонд үндэслэх шаардлагатай байдаг. Гэсэн хэдий ч бодлогын зөвлөгөөг турших эмпирик мэдээллийн сан бий болоход хугацаа шаарддаг. Дэлхийн банкны судалгааны төслөөр дэлхий даяарх судлаачдад зориулж ийм мэдээллийн санг боловсруулж, хадгаламжийн даатгал нь санхүүгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлдөг, зах зээл банкны эрсдэлийг хэрхэн сахилга батжуулдаг, санхүүгийн ерөнхий тогтолцоог хөгжүүлдэг зэрэг асуултуудад хариулт хайж, байнга шинэчилдэг.



2.2. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хүснэгт 3. Хадгаламжийн даатгалын загварыг улс орнуудаар харьцуулалт.

Table 1. Deposit Insurance Around the World : Design of Explicit Deposit Insurance

| Countries | Date Enacted / Revised | Coverage Limits US\$ or ECU | Coverage Ratios Limit/gdp per capita | Co- insurance | Permanent Fund Y=Yes N=No | Annual Premiums % of insured deposits unless otherwise noted | Source of Funding P= Private, O=Official J=Joint | Administration |
|-------------------------|------------------------|--|--|------------------|------------------------------------|--|---|----------------|
| | | | | | | | | |
| Argentina | 1979/1992/ 1995 | 30000 | 3 | N | Y | risk-based, 0.36 to 0.72 | P | P |
| Austria | 1979/1996 | \$24,075 but coinsurance for businesses | 1 | Y | N | pro rata, ex post | J | P |
| Bahrain | 1993 | 5640 | 1 | N | N | ex post | P | J |
| Bangladesh | 1984 | 2123 | 6 | N | Y | 0.005 | J | O |
| Belgium | 1974/1995 | 15,000 ECU until year 2000 | 1 | N | Y | 0.02 + 0.04 of insured liabilities | J | J |
| Brazil | 1995 | 17000 | 4 | N | Y | 0.3 | P | P |
| Bulgaria | 1995 | 1784 | 1 | N | Y | risk based to 0.5 | J | J |
| Cameroon | 1999 | 5336 | 9 | N | Y | risk based: 0.15% of deposits + 0.5% of net non-performing loans | J | J |
| Canada | 1967 | 40770 | 2 | N | Y | 0.33 max | J | O |
| Central African Rep. | 1999 | 3557 | 13 | N | Y | risk based: 0.15% of deposits + 0.5% of net non-performing loans | J | J |
| Chad | 1999 | 3557 | 15 | N | Y | risk based: 0.15% of deposits + 0.5% of net non-performing loans | J | J |
| Chile | 1986 | demand deposits in full and 90% coinsurance to UF 120 of \$3,600 for savings deposits | 1 | Y | N | none | O | O |
| Colombia | 1985 | in full until 2001, then coinsurance to \$5,500 | 2 | Y | Y | 0.3 | P | O |
| Croatia | 1997 | 15300 | 3 | N | Y | 0.8 | J | J |
| Czech Rep. | 1994 | coinsurance to \$11,756 | 2 | Y | Y | commercial banks 0.5, savings banks 0.1 | J | O |
| Denmark | 1988/1998 | 20000 ECU | 1 | N | Y | 0.2 (maximum) | J | J |
| Dominican Republic | 1962 | coinsurance to \$13,000 | 7 | Y | Y | 0.1875 | J | J |
| Ecuador | 1999 | in full to year 2001 | | N | Y | 0.65 | n.a. | O |
| El Salvador | 1999 | 4720 | 2 | N | Y | risk-based, 0.1 to 0.3 | J | O |
| Equatorial Guinea | 1999 | 3557 | 3 | N | Y | risk based: 0.15% of deposits + 0.5% of net non-performing loans | J | J |
| Estonia | 1998 | coinsurance 90% of \$1383, but 20,000 ECU in year 2010 | 0 | Y | Y | 0.5 (maximum) | J | J |
| Finland | 1969/1992/ 1998 | 29435 | 1 | N | Y | risk based: 0.05 to 0.3 | J | P |
| France | 1980/1995 | 65387 | 3 | N | N | on demand but limited | P | P |
| Gabon | 1999 | 5336 | 1 | N | Y | risk based: 0.15% deposits + 0.5% net non-performing loans | J | J |
| Germany | 1966/1969/ 1998 | private: 30% of capital; official coinsurance 90% to 20000 ECU | 1 | Y | Y | official is 0.03 but can be doubled | P | P |
| Gibraltar | 1998 | lesser of 90% coinsurance or 20,000 ECU | | Y | N | administrative expenses and ex post contributions | P | J |
| Greece | 1993/1995 | 20,000 ECU | 2 | N | Y | decreasing by size: 1.250 to 0.025 | P | J |
| Hungary | 1993 | 4,165 ECU or \$4,564 | 1 | N | Y | risk based to 0.3 | J | J |
| Iceland | 1985/1996 | 20,000 ECU | 1 | Y | Y | 0.15 | P | O |
| India | 1961 | 2355 | 6 | N | Y | 0.05 | J | O |
| Indonesia | 1998 | Blanket guarantee | | | | | | |
| Ireland | 1989/1995 | coinsurance 90% to 15,000 ECU | 1 | Y | Y | 0.2 | P | O |
| Italy | 1987/1996 | 125000 | 6 | N | N | risk adj., ex post 0.4 to 0.8 of protected funds | J | J |
| Jamaica | 1998 | 5512 | 2 | N | Y | 0.1 | J | O |

| Countries | Date Enacted / Revised | Coverage Limits | Coverage Ratios | Co-insurance | Permanent Fund | Annual Premiums | Source of Funding | Administration |
|-------------------|------------------------|--|-----------------|--------------|----------------|--|-------------------|----------------|
| Japan | 1971 | \$71,000, but in full until March 2001 | | N | Y | 0.0048 + 0.036 | J | J |
| Kenya | 1985 | 1750 | 5 | N | Y | 0.15 | J | O |
| Korea | 1996 | \$14,600, but in full until the year 2000 | | N | Y | 0.05 | J | O |
| Latvia | 1998 | \$830 until year 2000 | 0 | N | Y | 0.3 | J | O |
| Lebanon | 1967 | 3300 | 1 | N | Y | 0.05 | J | J |
| Lithuania | 1996 | \$6,250 then coinsurance | 2 | Y | Y | 1.5 | J | O |
| Luxembourg | 1989 | coinsurance 90% to ECU 15000 thru 1999, then to ECU 20000 | 0 | Y | N | ex post | P | P |
| Macedonia | 1996 | coinsurance 75% to \$183 | 0 | Y | Y | 1.5%, risk-based 1% to 5% | J | J |
| Malaysia | 1998 | Blanket guarantee | | | | | | |
| Marshall Islands | 1975 | 100000 | | N | Y | risk-based, 0.00 to 0.27 | P | O |
| Mexico | 1986/1990 | in full except subordinated debt until 2005 | | N | Y | 0.3 (max 0.5) plus 0.7 as needed | J | O |
| Micronesia | 1963 | 100000 | | N | Y | risk-based, 0.00 to 0.27 | P | O |
| Netherlands | 1979/1995 | 20,000 ECU | 1 | N | N | expost | J | O |
| Nigeria | 1988/1989 | \$588(at market exchange rate), \$2435 (at official exchange rate) | 2 | N | Y | 0.9375 | J | O |
| Norway | 1961/1997 | 260800 | 8 | N | Y | 0.005 of assets and 0.01 of total deposits | J | P |
| Oman | 1995 | coinsurance 75% to \$52,630 | 9 | Y | Y | 0.02 | J | O |
| Peru | 1992 | 21160 | 9 | N | Y | risk-based from 0.65 to 1.45 | J | J |
| Philippines | 1963 | 2375 | 3 | N | Y | 0.2 | J | O |
| Poland | 1995 | 1,000 ECU, then 90% coinsurance for the next 4,000 ECU | 0 | Y | Y | not more than 0.4 | J | O |
| Portugal | 1992/1995 | 15,000 ECU, coinsurance to 45,000 ECU | 1 | Y | Y | risk-based, 0.08 to 0.12 + more in emergencies | J | O |
| Republic of Congo | 1999 | 3557 | 5 | N | Y | risk based: 0.15% of deposits + 0.5% of net non-performing loans | J | J |
| Romania | 1996 | 3600 | 2 | N | Y | risk-based: 0.3 to 0.6 | J | J |
| Slovak Republic | 1996 | 7900 | 2 | N | Y | 0.1 to 0.3 for banks | J | J |
| Spain | 1977/1996 | 15,000 ECU through 1999, then 20,000 ECU | 1 | N | Y | maximum of 0.2 | J | J |
| Sri Lanka | 1987 | 1470 | 2 | N | Y | 0.15 | J | O |
| Sweden | 1996 | 28,663 ECU, \$31,412 | 1 | N | Y | risk-based, 0.5 now, 0.1 later (future date is not available) | J | O |
| Switzerland | 1984/1993 | 19700 | 1 | N | N | on demand | P | P |
| Taiwan | 1985 | 38500 | 3 | N | Y | 0.015 | J | O |
| Tanzania | 1994 | 376 | 2 | N | Y | 0.1 | J | P |
| Thailand | 1997 | Blanket guarantee | | | | | | |
| Trinidad & Tobago | 1986 | 7957 | 2 | N | Y | 0.2 | J | O |
| Turkey | 1983 | in full | | N | Y | risk-based 1.0 to 1.2 | J | O |
| Uganda | 1994 | 2310 | 8 | N | Y | 0.2 | J | O |
| Ukraine | 1998 | 250 | 0 | N | Y | 0.5 plus special charges | J | O |
| United Kingdom | 1982/1995 | larger of 90% coinsurance to \$33,333 or 22,222 ECU | 1 | Y | N | on demand | P | P |
| United States | 1934/1991 | 100000 | 3 | N | Y | risk-based, 0.00 to 0.27 | J | O |
| Venezuela | 1985 | 7309 | 2 | N | Y | 2 | J | O |

Source: Demirguc-Kunt and Sobaci, "Deposit Insurance Around the World: A Database," World Bank Economic Review, forthcoming. Full data base available at: http://www.worldbank.org/research/interest/confs/upcoming/deposit_insurance/home.htm

Дэлхий даяар бүх нийтэд нь оновчтой тохирох зөвхөн нэг хадгаламжийн даатгалын загварыг боловсруулах боломжгүй. Жишээлбэл, дансны

хамрах хүрээ нь хязгааргүй баталгаанаас эхлээд хатуу даатгалын хязгаар хүртэл өөр өөр харилцан адилгүй байдаг. Нэг талаас, Мексик, Турк, Япон



улсууд хадгаламж эзэмшигчийн депозитыг 100 хувь даатгалд хамруулна гэж амладаг бол Чили, Швейцар, Их Британи зэрэг улсууд нэг хүнд ногдох ДНБ-ээс ч бага хэмжээний депозитыг л даатгалд хамруулдаг байна. Түүнчлэн, олон улс орнууд гадаад валютаар байршуулсан хадгаламжийг даатгалд хамруулдаг ч ихэнх схемд банк хоорондын хадгаламжийг даатгалд хамруулдаггүй байна.

Даатгалын хамгийн дээд түвшинг тогтоохоос гадна зарим улсууд данс эзэмшигчид хадгаламжийн үлдэгдлийнхээ тодорхой хувийг "coinsure-хамтын даатгалаар даатгуулахыг" шаарддаг. Хамтарсан даатгалын заалтууд харьцангуй ховор хэвээр байгаа ч сүүлд батлагдсан схемүүдэд илүү олон удаа тохиолдох болов.

Хадгаламжийн даатгалын obligation /өрийн даалгавар/ нь ихэвчлэн засгийн газар болон банкны эх үүсвэрийн хослолоор урьдчилан санхүүжигддэг. Даатгагчид үүсэж болзошгүй хохирлынхоо эсрэг зохих нөөцийн санг бүрдүүлэхийн тулд ийм улс орнуудад банкууд жилийн хураамжийг бүхэлд нь буюу ихээхэн хэмжээгээр нэг дор даатгуулсан хадгаламжийнхаа хэмжээгээр тооцож авдаг байна. Жилийн эдгээр шимтгэлийг банкны эрсдэлд мэдрэмтгий болгох ажлыг сүүлийн жилүүдэд эхлүүлсэн.

Даатгалын тогтолцоог ихэвчлэн төрийн байгууллага эсвэл төр хувийн хэвшлийн түншлэлээр удирддаг. Гэсэн хэдий ч Швейцар, Герман, Аргентин зэрэг цөөн хэдэн улсууд өөрсдийн схемийг хувийн байдлаар /хувийн өмчид суурилсан/ удирддаг. Эцэст нь хэлэхэд, бараг бүх улс оронд дүрмийн сангийн гишүүнчлэл заавал байх ёстой. Үүний эсрэгээр тогтолцоогоо бүрдүүлсэн хамгийн алдартай

жишээ бол Швейцар улс юм.

Хүснэгт 3-т мөн улс орон бүрийн даатгалын тогтолцооны схемийг бий болгосон огноог бичсэн болно. Хэд хэдэн улс орнууд хямралын үед хадгаламжийн даатгалын тогтолцоогоо баталж, өргөжүүлсэн.

Жишээлбэл, Тайланд, Малайз, Солонгос улсууд сүүлийн үеийн хямралынхаа хариуд blanket insurance-д /өөр өөр байршилд ижил төстэй олон үл хөдлөх хөрөнгийн даатгалын даатгал юм. Тодорхой хамрах хүрээнээс ялгаатай нь энэ нь нэг байршилд хязгаарлагдахгүй. Үл хөдлөх хөрөнгөөс гадна хувийн өмч, моргейжийн хөрөнгө оруулалт гэх мэт бусад хөрөнгийг хамарч болно/ шилжсэн. 1990-ээд онд Африкийн зарим орнуудад болон шилжилтийн үеийн орнуудад магадгүй зарим талаараа ЕХ-нд элсэх урт хугацааны сонирхлоос үүдэлтэйгээр хадгаламжийн даатгал хурдацтай тархаж байсан. 1999 онд хадгаламжийн даатгалд хамрагдсан улсууд бол Эквадор, Эль Сальвадор, Төв Африкийн Валютын Холбооны нэг хэсэг, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад, Экваторын Гвиней, Габон, Бүгд Найрамдах Конго улсууд юм. Эдгээр шинэ схемүүдийн ихэнх нь хангалттай том цар хүрээг хамруулдаг. Жишээлбэл, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад улсууд нэг хүнд ногдох ДНБ-ээсээ 13-15 дахин их хэмжээний хадгаламжийг даатгах хамрах цар хүрээтэй байдаг.


Улс орон бүрийн хадгаламжийн даатгалын тогтолцооны загварчлалын шинж чанаруудын хүрээ маш өргөн, маш нарийвчлалтай байдаг тул тэдгээрийг харьцуулсан өгөгдлийн багц нь шинжээчдэд янз бүрийн нөхцөл байдалд өөр өөр функцүүд хэр сайн ажиллаж байгааг харьцуулж, ялгах боломжийг олгодог.

2.3. ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ЗАГВАРЧЛАЛ

Зураг 1.–т улс орнууд хадгаламжийн даатгалд шилжих хандлагатай байгааг ажиглаж болно. Хүснэгт 1–д жагсаасан улс орнуудын онцлог нь энэ бодлогын хэрэгслийн хэрэглээ хөгжиж буй орнуудад ялангуяа хурдацтай хөгжиж байгааг тодотгож байна. Энэ нь эрүүл хандлага байх эсэх нь тухайн улс орнуудын хадгаламжийн даатгалын зардал, үр ашгийн тэнцвэрт байдлаас хамаарна. Засгийн газар нь татвар хураах хүчтэй тогтолцоотой эсвэл гадаадын зээл авах боломжтой улс орнуудад хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгосны үндсэн давуу тал нь санхүүгийн үймээн самууны үед шууд аюулыг арилгах явдал юм. Даатгалын дээд хязгаарыг чанд мөрдүүлэх боломжтой

бүх улс орнууд аюулгүй байдлын сүлжээтэй байдаг тул хадгаламжийн даатгал нь төлбөрийн чадваргүй байгууллагуудын хадгаламж эзэмшигчдэд үзүүлэх засгийн газрын ирээдүйн төлбөрийн хариуцлагыг хязгаарлаж чадна. Үүний нэгэн адил хадгаламжийн даатгалд хамрагдах нь засгийн газарт төлбөрийн чадваргүй байгууллагуудын асуудалд цаг тухайд нь оролцох эрхээ нэмэгдүүлэх талаар боломжийг олгодог. Энгийн жижиг хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, жижиг санхүүгийн байгууллагуудыг том өрсөлдөгчтэй өрсөлдөхөд нь туслах хоёрдогч ашиг сонирхол мөн дагалддаг.

Зураг 1. 1934–1999 он хүртэл хугацаанд депозитын даатгалыг нэвтрүүлсэн улс орнууд.



Source: Demirguc-Kunt and Sobaci, World Bank, 2000.

Хадгаламжийн даатгалыг хэрэгжүүлэх нь даатгалын компанийг ажиллуулах төсөвт зардлаас гадна төсөвлөөгүй шууд бус зардлыг бий болгодог. Хадгаламжийн

даатгалын гол шууд бус зардал нь үр ашиггүй төрлийн санхүүгийн байгууллагын эрсдэлийн татааснаас үүдэлтэй. Даатгал нь зохисгүй эрсдэлийг санаатайгаар нэмэгдүүлэх аюулыг



ёс суртахууны аюул гэж нэрлэдэг. Эрсдэл даах нь өгөгдсөн схем нь хадгаламж эзэмшигчдийн урьд өмнө нь байсан санхүүгийн байгууллагын эрсдэлд хяналт тавих, хяналт тавих хөшүүргийг сулруулж байгаатай холбоотой учраас санаатай үйлдэл гэж тодорхойлсон. Татвар төлөгчдийн ёс суртахууны эрсдэлд өртөхийг хянахын тулд даатгагч нь санхүүгийн байгууллагуудад хяналт тавих, сахилга батжуулахад өөрөө эсвэл орлон гүйцэтгэгч талуудыг татан оролцуулах ёстой. Хадгаламжийн даатгалын онцлогоос үүсэх үр өгөөж, зардлын тэнцвэр нь даатгагчийн хохирлын хяналтын шинж чанар, энэхүү алдагдлын хяналт нь тухайн улс орны мэдээллийн болон гэрээ байгуулах орчны сул талуудтай хэрхэн харьцаж байгаагаас хамаарч өөр өөр байх ёстой.

Кейн (2000) банкны эрсдэлийг хянах нь ил тод байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ шаарддаг бөгөөд даатгагч үр дүнтэй ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулах нь амжилт, алдаа дутагдлыг татвар төлөгчдийн өмнө хариуцах ёстойг онцолсон. Байгууллагууд банкны зээлдүүлэгчид эсвэл хянагчдад банкны санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт, эрсдэлийн талаарх мэдээллийг төгс /Perfect deterrency/ бөгөөд зардал багатай мэдээлэх замаар ил тод байдлыг бүрэн хангадаг. Perfect deterrency гэдэг нь зээлдүүлэгч эсвэл хянагч нар мэдээллийн урсгалын үр дагаврыг шууд ойлгож, аливаа сөрөг үр дагавраас өөрсдийгөө бүрэн, зардалгүйгээр хамгаалж чаддаг нөхцөл байдлыг тодорхойлдог. Татвар төлөгчид төрийн албан тушаалтнуудын үйлдлийг тодорхойлж, тэдний үйл ажиллагааны үр дүнд бүрэн хариуцлага хүлээлгэж чадвал төгс хариуцлага бий болдог.

Ил тод байдал, урьдчилан сэргийлэх, хариуцлагатай байх нь тухайн улсын

байгууллагын орчны хэмжүүр юм. Эдгээр хэмжигдэхүүнүүдийн өндөр үзүүлэлтүүд нь хувийн болон төрийн секторын түншүүд банкны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, эрсдэл даах явдлыг сахилга баттай болгож, санхүүгийн хүндрэлээ нэн даруй шийдвэрлэх замаар банкны зохистой зан үйлийг хэрэгжүүлэх боломжтой гэдгийг баталдаг. Дэлхий даяар эдгээр гэрээний шинж чанар бүрд томоохон ялгаа байдаг. Улс орон, соёл иргэншилд ил тод байдал, саад тогтор, хариуцлагын төлөөх итгэмжлэгдсэн төлөөлөгчид нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр өсөх хандлагатай байдаг (Кейн, 2000), гэхдээ нийгмийн капиталын бусад элементүүд ч мөн адил үүрэг гүйцэтгэдэг.

Хамгаалалтын сүлжээ нь санхүүгийн хямралаас үүдэлтэй нийгмийн зардал, засгийн газрын хөндлөнгийн оролцоо нь хохирлыг бууруулах нийгмийн үр өгөөжөөс давахаас урьдчилан сэргийлэхийг эрмэлздэг. Хамгаалалтын сүлжээний загварчлал, ялангуяа хадгаламжийн даатгалын зохицуулалтууд нь тухайн улс орнуудын байгууллагын орчинд байдаг тодорхой сул талуудыг шийдвэрлэх ёстой.

Нэг хүнд ногдох орлого буурах тусам гэрээ байгуулах орчин улам олон янз болж байгааг хүлээн зөвшөөрөх нь хоёр үр дагавартай. Нэгдүгээрт, энэ нь "шилдэг практик" загварчлалын онцлогуудын нэг хослолыг санал болгох нь хөгжиж буй олон оронд сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй гэсэн үг юм. Хоёрдугаарт, ил тод байдал, тогтоон барих арга хэрэгсэл, хариуцлага маш сул байгаа орнуудын хувьд хадгаламжийн даатгалын үр ашигтай ил тод тогтолцоог хэрэгжүүлэх нь ямар ч боломжгүй юм.

Улс орон бүрийн хадгаламж-даатгалын тогтолцооны үндсэн гурван хэмжигдэхүүн нь: хувийн удирдлага болон/эсвэл хувийн

санхүүжилтэд хэр түшиглэдэг; албан ба албан бус хамрах хүрээний өргөн цар хүрээ; төлбөрийн чадваргүй банкнуудын далд эрсдэлд өртөмтгий байдал гэсэн үзүүлэлтүүд юм. Ил тод баталгааны тогтолцоонд шилжихдээ эрх бүхий албан тушаалтнууд өнгөрсөн хугацаанд улс орноо санхүүгийн хямралд өртөмтгий болгож байсан ил тод байдал, тогтоон барих арга чарга, хариуцлагын тогтолцооны сул талуудыг үр ашигтайгаар бууруулах хамрах хүрээ, санхүүжилт, удирдлагын бүтцийг хэрэгжүүлэх ёстой.

Хадгаламж эзэмшигчид банкны хөрөнгийн эдийн засгийн үнэ цэн, банкны эрсдэл хүлээх шинж чанарыг ажиглахад хэцүү байх тусам зохицуулагчид даатгуулсан банкнуудын үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг тайлагнах *informative protocol*-ийг бий болгох нь чухал болдог. Хэрэв тус улсын компанийн засаглалын тогтолцоо нь өмнө нь хадгаламж эзэмшигчдэд эрсдэл шилжүүлэхээс бага зэрэг хамгаалалт өгдөг байсан бол албан тушаалтнууд даатгагчийг таслан зогсоох тусгай эрх олгох ёстой. Эцэст нь хэлэхэд, улс төрийн тогтолцоо нь төрийн албан тушаалтнуудад хариуцлага бага байх тусам хадгаламж-даатгалын менежерүүд өөрсдийн үйл ажиллагаанаас бий болгож буй нийгмийн үнэ цэнийг үнэн зөв хэмжихэд илүү хариуцлагатай байх ёстой.

Түүхээс харахад ил тод байдал багатай, саад тотгор багатай хосолсон орчин нөхцөлд, банкны алдагдлыг хувьцаа эзэмшигчийн хариуцлагаар буюу түүний эзэмшлийн банканд байршуулсан хөрөнгийн хэмжээнээс өргөжүүлэх (Кэйн, Вилсон, 2001) болон томоохон хадгаламж эзэмшигчид болон хадгаламжгүй эзэлдүүлэгчдийг хамтын даатгалаар даатгуулах */coinsure/* нь чухал ач холбогдолтой болгосон.

Хариуцлага багатай орчинд хадгаламжийн даатгалын менежерүүдэд ил тод байдлын түвшинг оновчтой болгох, жижиг хувьцаа эзэмшигчдийн саад тотгор болон давхар даатгалыг зөвшөөрүүлэхийн тулд гэрээний урамшуулал шаардлагатай байдаг. Хариуцлага, ил тод байдал багатай орчинд, санхүүжилт, менежментэд хувийн оролцоо нь аюулгүй байдлын алдагдлыг сахилга батжуулахад шаардлагатай хөшүүргийг бий болгоход тусална. Даатгагчийн үйл ажиллагааг утга учиртай хэмжиж болохын хэрээр топ менежерүүдийн бүрэн эрхийнхээ хугацаанд хадгаламж-даатгалын гүйцэтгэлийн зохих хэмжүүртэй уялдуулан өгөөжийг нь хойшлуулсан нөхөн олговрын санг бий болгох нь зүйтэй.

Ил тод байдал, саад тотгор, хариуцлага нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг тул тухайн улс орны аюулгүйн сүлжээний загварчлалын онцлогууд дагаад өөрчлөгдөх ёстой. Цаг хугацааны явцад үр ашгийг хадгалахын тулд тус систем нь хувийн болон төрийн зохицуулалтын байгууллагуудыг үнэлэх, эрсдэлд орох, төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх сахилга батыг нэн даруй хэрэгжүүлэх, эдгээр ажлыг хэр сайн гүйцэтгэснийх нь төлөө зохих ёсоор шагнуулж, шийтгэх чадавхтай байх ёстой.

Кейн (2000) мөн банкны хямралыг даван туулахын тулд *blanket deposit guarantees*-ийн аюулын талаар авч үзсэн. Хямралыг зохицуулахдаа цочролыг яаралтай зогсоох нь найдваргүй төлбөрийн чадваргүй байгууллагуудыг илрүүлж, эрсдэл хүлээх байдлыг илрүүлэх боломжийг хязгаарлаж, хэтрүүлж болохгүй. Үймээн самууныг үр дүнтэй арилгахын тулд хөрвөх чадварыг зөвхөн төлбөрийн чадвартай байгууллагуудад л санал болгох ёстой.



Ийм бодлого нь зах зээлийн сахилга бат, эрсдэл үүрэх хөшүүргийг гажуудуулж, улсын санд тодорхойгүй үүрэг хариуцлага хүлээлгэж

байгаа учраас ирэх жилүүдэд нь шинэ, гүнзгий хямралыг үүсгэхэд нөлөөлдөг байна.

2.4. ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ОНОЛЫН БӨГӨӨД ЭМПИРИК БАРИМТ

Өргөн хүрээний судалгаануудад хадгаламжийн даатгалын үр ашиг, зардалд дүн шинжилгээ хийж, хадгаламжийн даатгалын оновчтой тогтолцоог бий болгохын тулд эдгээр үр өгөөж, зардлыг тэнцвэржүүлэх сорилтыг судалдаг. Гэсэн хэдий ч бодит амьдрал дахь хадгаламжийн даатгалын тогтолцооны үр ашгийн талаарх улс хоорондын харьцуулсан эмпирик нотолгоог олоход хэцүү байдаг. Тухайн улс орны хадгаламжийн даатгалын тогтолцоо хэр үр дүнтэй болохыг харуулдаг дөрвөн эмпирик асуултад хариулт хайлаа.

- 1/ Хадгаламжийн даатгал нь санхүүгийн байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөх?
- 2/ Хадгаламжийн даатгал зах зээлийн сахилга батад хэрхэн нөлөөлдөг вэ?
- 3/ Хадгаламжийн даатгал санхүүгийн хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?
- 4/ Хадгаламжийн даатгал нь хямралыг зохицуулахад ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

Асуулт тус бүртэй холбоотой судалгаануудыг багцалж, асуулт бүрийн хариулт өөр өөр улс орон болон гэрээ байгуулах орчинд хэрхэн өөр өөр байдаг талаарх эмпирик нотолгоог судалсан.

1/ Хадгаламжийн нээлттэй даатгал нь санхүүгийн байгууллагын тогтвортой байдалд хэрхэн нөлөөлдөг вэ?

Системийн хямралын дунд хадгаламж эзэмшигчдийн баталгааг өргөжүүлэх эсвэл чангатгах нь хямралыг бууруулах хэрэгсэл болох бодлого боловсруулагчдын анхаарлыг ихэд татдаг. Гэсэн хэдий ч тус хямралыг эмчлэхээр хойшлуулсан зардал нь ихээхэн байж болно. Хадгаламжийн даатгалыг улс орны аюулгүй байдлын сүлжээнд оруулах урт хугацааны хамгийн сайн арга бол эдийн засагчдын дунд маргаантай асуудал юм.

Даймонд ба Дибвиг (1983) нарын сонгодог бүтээлд хадгаламжийн даатгал нь тодорхой бус ил тод байдал нь өөрөө өөрийгөө гүйцэлдүүлэх замаар банкны тогтвортой байдалд заналхийлэх гэрээ байгуулах орчинд алдагдлын эрсдэлийг бууруулах цорын ганц урьдчилан сэргийлэх хэрэгсэл оновчтой бодлого гэж тодорхойлсон байдаг.

Аллен, Гейл (1998) нар илүү ил тод байдал нь зөвхөн банкны активын чанар бодитоор муудсан тохиолдолд л гүйлгээг нэмэгдүүлэх нөлөөтэй байдаг гэж үзсэн. Илүү ил тод болсон энэ орчинд аюулгүй байдлын оновчтой стратеги /safety-net strategy/ нь банкны системийн хөрвөх чадварыг хангахад төв банкны зээлийг ашиглах явдал юм.

Safety-net strategy нь шилжих хөдөлгөөнийг зогсооход маш үр дүнтэй байдаг тул safety nets нь ёс суртахууны аюулыг бий болгодог. Энэхүү ёс суртахууны аюул банкууд болон тэдгээрийн зохицуулагчдаас үүсдэг. Оппортунист банкирууд хяналт шалгалтын ил тод байдал, саад тотгорын сул талыг дөрөөлөн үр ашиггүй эрсдэлийг авч, тэр байтугай залилан мэхлэх үйл ажиллагаа явуулах боломжтой байдаг. Практикт safety net –ийн хяналтын бүрдэл элементүүдийг хянадаг зохицуулагчид болон улс төрчид зохистой хэм хэмжээг хянах, хэрэгжүүлэхэд зоригжуулах хүч хангалттай байдаггүй.

Банкны өөрийн хөрөнгө, ил тод байдал, deter-
gency /тогтоон барих арга/, хариуцлагатай байх тусам банкууд эрсдэл шилжүүлэх, луйвардах өдөөгч шалтгаан буурдаг. Эдийн засгийн таагүй шокийн үед ил тод байдал болон банкны хөрөнгийн хэмжээ буурах хандлагатай байдаг (Merton, 1977, Calomiris, 1990).

Луйвар нь ихэвчлэн банкирууд өөрсдөдөө болон холбогдох талуудад зах зээлээс доогуур нөхцөлөөр зээл олгох хэлбэрээр явагддаг. Банкны өөрийн хөрөнгө шавхагдахын хэрээр зээлийн авлигын зардал safety net–д /аюулгүй байдлын сүлжээнд/ улам бүр буурч байдаг (Akerlof and Romer, 1993).

Эдийн засгийн онол нь холимог мэдээллийг агуулдаг. Нэг талаас, найдвартай хадгаламжийн даатгал нь хадгаламж эзэмшигчийн гүйлгээг багасгах замаар санхүүгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулдаг. Нөгөөтээгүүр, Даатгуулагчдын хөрөнгийн байдал, эрсдэл даах чадварыг сайтар хянахгүй бол даатгагчид урт хугацаанд банкны тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлийг бий болгоно. Хадгаламж–даатгалын онол нь сайн ба муу үр

дагаврыг зэрэг агуулсан байдаг тул эмпирик баримт нотолгоог давхар судлах нь чухал юм. Хадгаламжийн даатгал болон санхүүгийн хямралын хоорондын уялдаа холбоог судлахын тулд Демиргүч–Кунт, Детрагиаче (2000) нар анх удаа муж хоорондын мэдээллийн санг ашигласан. Тэд 1980–1997 оны 61 орны мэдээллийг ашиглан банкны хямралын загварыг тооцсон. Бусад тодорхойлогч хүчин зүйлсийг хянасны дараа тэд муу боловсруулсан хадгаламжийн даатгалтай байх нь тухайн улс банкны хямралд өртөх магадлалыг нэмэгдүүлэх хандлагатай байдаг бөгөөд энэ үр дүн нь урвуу учир шалтгааны нөлөөнд автдаггүй болохыг олж мэдсэн.

Хадгаламжийн даатгалын тодорхой загвар нь улс орнуудад ихээхэн ялгаатай байдгийг хүлээн зөвшөөрч Демиргүч–Кунт ба Детрагиаче (DKD) нар хувийн загварчлалын онцлог нь хадгаламжийн даатгалын банкны тогтвортой байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах эсэх, хэрхэн бууруулахад анхаарлаа хандуулсан. Хүснэгт 2–т үзүүлсэн регрессийн шинжилгээний туршилтаас харахад хадгаламжийн даатгал нь нь хамрах хүрээ өргөн байдаг улс орнуудад хамгийн их асуудал үүсгэдэг бөгөөд эрх баригчид тодорхой нөөцийн томоохон санг хуримтлуулж, төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэхэд зориулж зарцуулдаг бөгөөд уг схемийг хувийн хэвшил гэхээсээ илүү төрийн албан хаагчид удирдан зохион байгуулдаг. Эдгээр дүгнэлтүүд нь хадгаламжийн даатгалд заналхийлж буй ёс суртахууны эрсдэлтэй шууд тэмцэх нь чухал болохыг онцолж байна. Мөн байгууллагын орчин нь ил тод бус, саад тотгортой улс орнуудад хадгаламжийн даатгалын банкны эмзэг байдалд сөрөг нөлөөлөл ихээхэн байдгийг DKD харуулж байна.,



харин орчин нь хүчтэй орнуудад тийм ч чухал биш юм. Эдгээр дүгнэлтүүд нь гэрээ байгуулах орчин нь идэвхжүүлэгч зөрчилдөөнийг хянадаг тохиолдолд, үр дүнтэй зохистой зохицуулалт, хяналт нь хадгаламжийн даатгалд бий болсон тааламжгүй өдөөгч шалтгааныг нөхөх боломжтой бөгөөд ингэснээр ёс суртахууны эрсдэлд санаа зовох шаардлагагүй болно гэдгийг баталж байна. Eichengreen, Arteta (2000) нар DKD-ийн хадгаламжийн даатгалын үйлчлэлээс өндөр хөгжилтэй орнуудыг давхар нөлөөллийг арилгах үүднээс түүврээс нь хасаж, хадгаламжийн илэрхий даатгал үйлчилж, оршин байгаа эсэхийг тогтоохын тулд нэг хэмжээст дамми хувьсагчийг ашигласны үр дүнд тус таамаглал бат бөх биш болохыг тогтоожээ. Ерөнхийдөө, тогтолцоо нь ёс суртахууны аюулыг эрчимжүүлдэг шинж чанаруудыг хэдий чинээ их хэмжээгээр бол, төдий чинээгээр банкны хямралд өртөмтгий байдаг гэсэн үг юм.

DKD нь санхүүгийн аюулгүй байдлын сүлжээний бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг, ялангуяа зохицуулалт, хяналтын хэрэгжилтийн чанарын өөрчлөлтийг төгс бус хянадаг. DKD нь зохицуулалт, хяналтын чанарыг хүнд суртлын чанар, хүнд суртлыг саармагжуулах, авлигагүй байдал, гэрээний хэрэгжилтийн чанар, хуулийн үр ашигтай байдал зэрэг байгууллагын үзүүлэлтээр илэрхийлдэг.

Барт, Каприо, Левин (2001) нар арилжааны банкнуудын зохицуулалт, хяналтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийн санг бүрдүүлэн судалж, төрийн хяналтын шинж чанарын өөрчлөлтийг хянадаг DKD-ийн дүгнэлтийг дахин баталсан.

Бодлого боловсруулагчид нээлттэй хадгаламжийн даатгал болон банкны хямрал хоёрын эерэг хамаарлыг сэрээх дохио гэж

үзэх ёстой. Учир нь хадгаламжийн найдвартай даатгал нь банкнуудад эрсдэлээс үл хамааран хадгаламж цуглуулах боломжийг олгодог. Хадгаламжийн даатгал нь хувийн хэвшлийн хяналтыг эрс багасгаж, зохицуулалт, хяналтын үр дүнгүй сахилга батаар солих юм бол эерэг хамааралтай байх болно. Хүчирхэг байгууллага бүхий улс орнуудад хадгаламж эзэмшигчдийн ихэнх хяналтыг бууруулснаар эсвэл бүхэлд нь албан ёсны хяналт шалгалтаар орлуулах бөгөөд ингэснээр хадгаламжийн даатгалын банкны эмзэг байдалд үзүүлэх нөлөө тийм ч чухал биш болдог.

2/ Хадгаламжийн даатгал зах зээлийн сахилга батад хэрхэн нөлөөлдөг вэ?

Ил тод байдал өндөртэй орчинд хадгаламж эзэмшигчид хадгаламжийн хүүг нэмэгдүүлэхийг шаардах эсвэл хадгаламжаа эргүүлэн татах замаар хэт их эрсдэл үүрдэг санхүүгийн байгууллагуудыг сахилга батжуулах боломжтой. Гэсэн хэдий ч хадгаламжийн даатгал нь хадгаламж эзэмшигчдийн банкны өөрийн хөрөнгө, алдагдлыг хянах, хяналтад оролцох оролцоог багасгахын хэрээр банкны эрсдэлийг хянах хариуцлагыг зохицуулалтын тогтолцоонд шилжүүлдэг. Хадгаламжийн даатгалын менежерүүдээс сахилга батыг нь өөрсдөөс нь шилжүүлэх болгонд тухайн банкны үйл ажиллагаа мууддаг. Үүнийг ойлгохын тулд дараах 2 асуултад хариулах ёстой болдог. Үүнд:

- Хадгаламж эзэмшигчид зах зээлийн сахилга батыг хангуулахад хэрхэн хүчин зүтгэл гаргадаг вэ?
- Хадгаламжийн даатгал нь хадгаламж эзэмшигчийн сахилга батыг хэрхэн бууруулдаг вэ?

Банкны хүүгийн зардалд тусгалаа олж илэрхийлэгддэг зах зээлийн сахилга батыг голчлон АНУ-ын туршлага дээрээс олж харж болно. Фланнери (1998) АНУ-д даатгуулаагүй банкны хадгаламж болон бусад өрийн хэрэгслийн хүүгийн зардал нь үл мэдэгдэх эрсдэлийн ажиглагдаж болох арга хэмжээнд хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг талаар судалгаа хийсэн. АНУ-д 100,000 доллароос дээш үлдэгдэл даатгалд хамрагддаггүй.

Ер нь судлаачид эдгээр хэсэгчилсэн даатгалд хамрагдсан санхүүгийн хэрэгслүүдийн (хадгаламжийн гэрчилгээ, CD зэрэг) төлсөн хүү нь банкны эрсдэлтэй холбоотойгоор ихээхэн нэмэгддэг болохыг (Жишээлбэл, Baer and Brewer 1986, Hannan and Hanweck 1988, Brewer and Mondschean 1994) тогтоожээ. Эллис, Фланнери (1992) нар CD-ийн ханшийн хөдөлгөөнийг хувьцааны үнийн хөдөлгөөнтэй холбогдсон банктай холбоотой мэдээлэл, банкнуудын CD-ийн ханш нь тухайн банкны эрсдэлийн талаарх зах зээлийн төсөөлөлд ерөнхийдөө хариу үйлдэл үзүүлдэг болохыг нотолсон.

Күүк ба Спеллман (1994) нар бүр бүрэн даатгалтай хадгаламж, АНУ-ын хадгаламж зээлийн хоршоодын (S&Ls) эрсдэлийн хураамж нь 1987 онд хувийн байгууллагын эрсдэлт хүчин зүйлүүдэд хариу үйлдэл үзүүлж байсныг тогтоосон. Эрсдэлд ийм мэдрэмтгий байдал нь тухайн үед тэдний холбооны батлан даагч эдийн засгийн гүн гүнзгий төлбөрийн чадваргүй болчихсон байсныг нь илчилдэг. Эдгээр хураамж нь түрэмгий S&L-ууд болон тэдгээрийн төлбөрийн чадваргүй даатгагчдыг мөрий тавьж тоглохыг хазаарлах зорилгоор нэгэн зэрэг үйлчилсэн.

Энэхүү үндэслэл нь хяналт шалгалт болон даатгагчийн цэвэр хөрөнгийн хангалтгүй

байдал нь даатгагчийн баталгаанд итгэх итгэлийг бууруулж болохыг харуулж байна. Хадгаламж эзэмшигчийн хариу үйлдлээс давж гарч, Фланнери ба Сореску (1996) даатгалгүй банкны өрийн бичиг болон төрийн сангийн үнэт цаасны хоорондох зах зээлийн өгөөжийн зөрүүг судалжээ. Эдгээр тархалт нь 1989–1991 онд бэрхшээлт байдлыг арилгаж байх үед банкны эрсдэлд ихээхэн мэдрэмтгий байдгийг харуулсан.

Энэ нь FDIC төлбөрийн чадваргүй банкны эзэмшигч компаниудын зээлдүүлэгчдийг бүрэн аварч чадах уу, үгүй юу гэсэн эргэлзээ төрүүлж байсан үе байсан. 1983–1984 онд дарамт багатай цаг үед банкны деривативын зөрүүгээр далд болон илт баталгааны найдвартай байдлын өөрчлөлтийн ач холбогдлыг сөрөг талаас нь дэмжигддэг. Тэр үеийн өгөгдөлд дүн шинжилгээ хийхдээ Авери, Белтон, Голдберг (1988), Гортон, Сантомеро (1990) нар эрсдэлд мэдрэмтгий байдлыг илрүүлж чадаагүй юм.

Даатгалын хадгаламжийн хүүгийн зардал, даатгалд хамрагдаагүй хэрэгслүүдийн зардал нь даатгагчийн баталгааг нөхөх чадварт эргэлзэх үед хадгаламжийн байгууллагыг улам сахилга баттай болгодог байж болзошгүй юм. Иймэрхүү эргэлзээ нь хөгжиж буй орнуудад түгээмэл байдаг бөгөөд хурдан нэмэгдэж магадгүй. Банкнуудын хадгаламжийн өсөлтийг эрсдэлийн урамшуулал нь удаашруулж байгаа эсэхийг олон янзын улс орон болон цаг хугацааны хувьд авч үзсэн байдаг. Гортон, Пеннакчи (1990) яагаад асуудалтай байгууллагад хадгаламжийн өсөлт удааширна гэж хүлээх ёстойг тайлбарласан. Статистикийн дүн шинжилгээ нь дэлхий даяар ижил төстэй байгаа хэв шинжийг илрүүлдэг. Мартинез–Периа, Шмуклер (1998) нар Аргентин, Чили, Мексикийн банкнууд дахь



депозит нь бүртгэлийн мэдээллээс бий болсон эрсдэлийг хэмжих арга ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоожээ. Хадгаламжийн даатгал хамгийн найдвартай гэж тооцогддог Чилид даатгалгүй хадгаламж эзэмшигчид банкны эрсдэлийг үр дүнтэй хянадаг гэдгийг харуулсан.

1920–1930–аад оны Нью-Йорк хотын банкнуудыг судалж үзээд Каломирис, Вилсон (1998) нар хадгаламж эзэмшигчид банкнуудыг эрсдэлтэй байдлаар нь ялгаварлан гадуурхаж, мөнгөө аюулгүй газар руу шилжүүлэх хандлагатай байсныг тогтоосон. Үүний нэгэн адил Кейн (1987) 1985 онд Охайогийн Хадгаламжийн Баталгааны Сан (ODGF) хямралд ороход Охайогийн хадгаламж эзэмшигчид зөвхөн ODGF-ийн даатгалд хамрагдсан байгууллагуудын санг хассан гэж мэдээлсэн. Парк (1995) болон Парк ба Перистиани (1998) нар 1980–аад оны үед АНУ-ын хувийн хадгаламжийн өсөлт нь төлбөрийн чадваргүй болох магадлалтай болсон тул эрсдэлтэй бас хэмнэлттэй бүлгийн хүмүүсийн хадгаламжийн өсөлт удааширч байсныг тогтоосон.

Demirgьз–Kunt болон Huizinga (DKN, 2000) нар 1990–1997 онд 43 орныг хамарсан банкны салбарыг харьцуулж, хадгаламж эзэмшигчийн сахилга бат/дэг журмыг хүүгийн түвшин болон хадгаламжийн өсөлтийг харгалзан үзсэний үндсэн дээр судалжээ. Нээлттэй даатгал нь банкны хүүгийн зардлыг бууруулж, хүүгийн төлбөрийг банкны эрсдэл, хөрвөх чадварт бага мэдрэмтгий болгодог гэдгийг нотлон харуулсан. Гэсэн хэдий ч тухайн улс орны аюулгүй байдлын сүлжээний / country's safety net/ шинж чанараас үл хамааран зах зээлийн зарим сахилга бат/дэг журам хэвээр үлддэг.

DKN нь загварчлалын шинж чанарын өөрчлөлт зах зээлийн сахилга бат/дэг жаягт хэрхэн нөлөөлдөг талаар онцгойлон анхаардаг. Тэд байгууллагын хөгжил өндөртэй орнуудад зах зээлийн сахилга бат илүү хүчтэй байдаг гэж үздэг. Гэсэн хэдий ч байгууллагын хөгжил өндөртэй орнуудад ч хадгаламжийн даатгал нь зах зээлийн сахилга бат/дэг жаягийг сааруулдаг.

Даатгалын хамрагдалтын хязгаарыг өндөр тогтоох, банк хоорондын хадгаламжийн хамрах хүрээг өргөтгөх, нөөцийн өмнөх сан байгуулах, нөөцийг засгийн газраас санхүүжүүлэх, төрийн менежментийг шаардах нь зах зээлийн дэг жаягийг шахан гаргаж байна. Нөгөөтээгүүр зах зээлийн сахилга батыг давхар даатгалд хамруулах, валютын хадгаламжийг хамруулах, даатгалын байгууллагын хувийн болон хамтарсан удирдлагыг бий болгох зэргээр сайжруулж байна. Хадгаламжийн даатгалын үнэ цэнийг банкнууд болон тэдгээрийн зээлдүүлэгчид шаардлагатай хүүгийн бууралтаар хэмжиж болно. Нийгэм нь банкнуудад хяналт тавих удирдлагын зардал болон зах зээлийн сахилга бат/дэг журмыг бууруулсны үр дагаврыг хүлээн зөвшөөрснөөр хадгаламжийн аюулгүй байдлын зардлын өсөлтийг төлөх болдог. Даатгалын шимтгэлээр дамжуулан "зөв" үнэ тогтоох нь эрсдэлийн шилжилтийг зарчмын хувьд арилгах боломжтой боловч ийм үнэ тогтоох нь ялангуяа хөгжиж буй орнуудад улс төр, захиргааны хувьд хэцүү байдаг. Leaven (2001) банкны хувьцааны зах зээлийн үнийн 14 орны жишээн дээр банкнуудад жил бүр олгодог далд татаасын тооцоог гаргажээ. Хадгаламжийн даатгалын өртөг нь тухайн улс орон бүрд онцлог шинж чанартай бөгөөд нэг хүнд ногдох ДНБ бага, байгууллагын орчин муутай орнуудад хамгийн өндөр байдаг гэж тэрээр

үзсэн. Германы банкнууд маш бага эрсдэл хүлээж, хадгаламжийн даатгалаас хамгийн бага хэмжээний татаас авдаг. Энэ нь Бекийн (2001) Германы хадгаламжийн даатгалын талаар хийсэн судалгааны дүгнэлтийг бататгаж байна. Хувийн удирдлага, харилцан хариуцлага, дампуурлын эсрэг хандлага нь Германы банкнуудад эрсдэл хүлээх хөшүүргийг хязгаарладаг гэж Бек үздэг. Хадгаламжийн даатгал нь өндөр хөгжилтэй орнуудад ч зах зээлийн дэг журмыг шахан гаргадаг ч хатуу зохицуулалт, хяналт тавьж байж цэвэр үр нөлөө нь сайжирч магадгүй юм. Гэрээ байгуулах орчин муутай улс орнууд хадгаламжийн даатгалд өртөх магадлал өндөр байдаг.

Зарим хүмүүс байгууллагын хувьд буурай хөгжилтэй орнуудад хадгаламжийн даатгал нь зах зээлийн сахилга бат/дэг журам, системийн тогтвортой байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг нөхөх өөр давуу талтай гэж үздэг. Фолкертс–Ландау, Линдгрэн (1998) нар хадгаламжийн даатгалын үндсэн ашиг тус нь жижиг хадгаламж эзэмшигчдэд эрсдэлгүй хөрөнгө олгох явдал гэж үздэг. Энэ үзлийг шүүмжлэгчид засгийн газрын өрөөр баталгаажсан шуудангийн хадгаламж, мөнгөний зах зээлийн сан гэх мэт хөрөнгийг гаргах замаар (Calomiris, 1996, Stiglitz, 1992) эсвэл эсвэл даатгуулсан хадгаламж гаргаж буй банкнуудыг "narrow" банк хэвээр байлгахыг хязгаарлаж болно гэж шаардах замаар тогтворгүйжүүлэх зардалгүйгээр энэхүү ашиг тусыг авах боломжтой гэж онцолдог. Хоёрдох бөгөөд ялангуяа хувьслын үзэл баримтлал нь хөгжөөгүй байгууллагатай орнуудад хадгаламжийн даатгал нь санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг илүү үр дүнтэй гүйцэтгэхийн тулд банкны системийг сайжруулах эхлэлийг бий болгоно гэж үздэг.

3/ Хадгаламжийн даатгал санхүүгийн хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?

Улс орнууд янз бүрийн шалтгааны улмаас хадгаламжийн даатгалд хамрагддаг. Гэсэн хэдий ч нийтлэг шалтгаан нь одоогийн төсвийн эх үүсвэрийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, сангийн нөөцийг зарцуулахгүйгээр албан ёсны санхүүгийн системд итгэх итгэлийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн байгууллагын зээлийн урсгалыг /нөгөө талдаа зээл санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой/ нэмэгдүүлэх явдал юм. Хадгаламжийн даатгал нь хадгаламж эзэмшигчдийн санхүүгийн системийн тогтвортой байдалд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн хэрээр өрхийн хуримтлалыг санхүүгийн системд үр дүнтэй ашиглахад чиглүүлж чадна. Хөрөнгө оруулалтын сайжруулсан хэв маяг, тогтвортой өндөр нийт эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд албан журмаар татан төвлөрсөн сангийн нөөц хөрөнгө мөнгийг зарцуулагдах хэлбэртэй байх уу, үгүй юу гэдэг асуулт дагалддаг.

Сүүлийн үед хадгаламжийн даатгалд хамрагдсан ч гэсэн санхүүгийн хөгжлийн түвшин доогуур улсууд бол Африк, Латин Америкийн орнууд юм. Хадгаламжийн даатгал нь санхүүгийн хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулж байгаа эсэхийг судлахын тулд Cull, Senbet, Sorge (2000) нар 58 улс орны хугацааны цувааны өгөгдөл дээр судалгаа хийсэн байдаг. Эдгээр судлаачид хадгаламжийн тодорхой даатгал нь зөвхөн хүчтэй байгууллагын хөгжил байгаа тохиолдолд санхүүгийн үйл ажиллагааны түвшин, түүний тогтворгүй байдалд эергээр нөлөөлдөг гэж үзсэн. Хадгаламжийн даатгалын зохицуулалт нь байгууллагын орчны сул талыг даван туулах зохицуулалтын схемийг тусгаагүй тохиолдолд тогтворгүй байдал үүсэж,



улмаар санхүүгийн хөгжилд хохирол учруулах магадлалтай гэж дүгнэсэн.

Secchetti болон Krause (2000) дэлхийн 49 орны панел өгөгдөл дээр судалж үзэхэд хадгаламжийн даатгал нь банкны бус санхүүжилтийн механизмын хувьслыг удаашруулдаг болохыг тогтоосон. Банкны хадгаламжийн даатгал илүү өргөн хүрээтэй, хөгжсөн байдаг улс орнуудад хөрөнгийн болон санхүүгийн зах зээл бага хөгжсөн, нэг хүнд ногдох олон нийтэд арилжаалагддаг пүүсийн тоо маш бага байгааг анзаарсан байдаг.

Иймээс байгууллагын хувьд сул орчинд хадгаламжийн даатгал нь санхүүгийн хөгжлийг дэмжих бус зарим талаараа харин удаашруулж ч байх шиг санагдуулна. Улс орон даяар харьцуулж хийсэн судалгаа нь гэрээ байгуулж буй орчныхоо илт дутагдлыг засахын тулд тасралтгүй хадгаламжийн даатгалд хамрагддаг улс орнуудад урт хугацаанд тулгарч буй эрсдэлийг тодорхойлсон байна. Энэхүү судалгаа нь хадгаламжийн даатгалын тогтолцоонд хамрагдах эсэх талаар эрх баригчдад анхааруулах чухал зөвлөгөө юм.

Шийдвэр гаргах үйл явц нь тухайн улсын санхүүгийн салбарын тогтолцоонд байгаа ил тод байдал, саад тотгор, хариуцлагатай байдлыг дүгнэх аудитын үйл ажиллагаанаас эхлэх ёстой. Аюулгүйн байдлын сүлжээний сайн загварыг /Good safety-net/ хөгжүүлэх гэдэг нь зөвхөн өндөр хөгжилтэй орнуудад байдаг туршлагыг хуулбарлахыг хэлдэггүй. Сайн загвар, тогтолцоо гэдэг нь тухайн улсын санхүүгийн гэрээний тогтолцоонд хамаарах асуудлуудыг багасгаж, бууруулж чадсан байхыг хэлдэг.

Эрх мэдэлтнүүд хямралын үед байгууллагын аудит, улс орны онцлогт хохирсон зохицуулалтыг хэвээр үргэлжлүүлж магадгүй юм шиг дүр

эсгэдэг. Энэ үзэл баримтлалын дагуу санхүүгийн хямралын үед зээлдүүлэгчид нь хадгаламжийн даатгалд хамрагдахыг тулгадаг улс орнуудад урт хугацааны үр дагаврын талаар бодох боломж хомс байдаг.

4/ Хямралыг зохицуулахад хадгаламжийн даатгал ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

Банкны хямралыг саатуулахын тулд blanket guarantees гаргах нь түгээмэл байдаг. Энэхүү стратегийг хэрэгжүүлж буй орнуудад Швед (1992), Япон (1996), Тайланд (1997), Солонгос (1997), Малайз (1998), Индонези (1998) улсууд орно. 2000–д онд Турк улс зөвхөн банкны хадгаламж эзэмшигчид төдийгүй Туркийн банкнуудын дотоодын болон гадаадын бүх хадгаламжийн бус зээлдэгчид баталгаа гаргаж, санхүүгийн хямралаа зогсоохыг оролдсон.

Системийн хямралыг зогсоохын тулд blanket guarantees ашиглахыг дэмжигчид хадгаламж эзэмшигчдийн чанарын удирдлага руу чиглэсэн нүүдлийг зогсооход sweeping guarantees нь тустай, бүр зайлшгүй шаардлагатай гэж үздэг. Гэсэн хэдий ч, blanket guarantees нь ижил төстэй нөхцөл байдалд ирээдүйд ашиглах хүлээлтийг бий болгодог тул зах зээлийн сахилга бат/дэг журмыг алдагдуулж, урт хугацааны туршид ихээхэн тогтворгүй байдалтай болгож болзошгүй юм. Хямрал намжсаны дараа зарим улс орнууд албан ёсны даатгалын хамрах хүрээг багасгаж чадсан ч албан бус даатгалыг найдвартай байдлаар бууруулах нь маш хэцүү байдаг.

Хадгаламж эзэмшигчийн гүйлгээг зогсооход бүрэн баталгааг найдвартай сунгах бодлого хангалттай гэдэг нь ойлгомжтой. Гэсэн хэдий ч хөгжиж буй орнуудын засгийн газруудын

хувьд түүний баталгааг бий болгож, улмаар найдвартай байлгах нь өндөр өртөгтэй асуудал үүсгэдэг.

Засгийн газрын өргөн хүрээтэй баталгаа нь хуримтлагдсан алдагдал, эрсдэлийг банкны оролцогч талуудаас татвар төлөгчид рүү шилжүүлдэг. Бүрэн баталгааг хангах төсвийн зардал нь засгийн газрын далд өрийг бүрдүүлдэг далд төсвийн зардал юм. Энэхүү бүртгэгдээгүй зарлага, бүртгэгдээгүй өр нь тухайн улсын валютын нөөцийг илт сулруулдаг байна. Тиймээс төсвийн чадавх сул орнуудад санхүүгийн хувьд боловсронгуй хашир оролцогч талууд баялгаа оффшор руу шилжүүлэх хөшүүрэгтэй тулгарсаар байна. Хэрэв энэ хөрөнгийн нүүдэл удахгүй эхэлбэл гаднаас өргөн хүрээний дэмжлэг үзүүлэхгүй бол бүрэн баталгаа нь богино хугацаанд ажиллахгүй байж магадгүй юм.

Шууд хямралыг амжилттай зогсоож чадсан ч хямралыг зогсоох баталгааг бий болгох нь ирээдүйн хямралд ижил төстэй тусламж үзүүлэх хүлээлтийг бий болгодог. Энэ аргыг илүү олон удаа хэрэглэж, гадаадын болон үндэстэн дамнасан байгууллагууд илүү их урам зоригтойгоор дэмжих тусам банкнууд болон тэдгээрийн зээлдүүлэгчид хямралын дараах албан ёсны даатгалын хамрах хүрээг бага хохирлын түвшинтэй гарах оролдлогыг нухацтай авч үзэх нь илүү хэцүү болно.

Honohan, Klingebiel (2000) нар банкны системийн хямралыг шийдвэрлэх эцсийн төсвийн зардалд бүрэн баталгаа болон хямралын менежментийн бусад стратегийн нөлөөнд дүн шинжилгээ хийсэн.

Дэлхий даяар тохиолдсон дөчин хямралыг хамарсан тоо баримтаас харахад хадгаламж

эзэмшигчийн хязгааргүй баталгаа, хөрвөх чадварыг хязгаарлахгүй байх дэмжлэг, зохицуулалтын хүлээцтэй байдал нь банкны хямралыг шийдвэрлэх эцсийн төсвийн зардлыг ихээхэн нэмэгдүүлж байгааг харуулж байсан. Түүгээр ч барахгүй эдгээр зохиогчид төсвийн зардал болон эдийн засгийн сэргэлтийн хурд хоёрын хооронд ямар ч ялгаа байхгүй гэж үздэг. Тэдгээрийн жишээн дээр хадгаламж эзэмшигчдийн баталгаа болон зохицуулалтын хүлээцтэй байдал нь хямралын үргэлжлэх хугацаа эсвэл хямралаас үүдэлтэй нийт бодит үйлдвэрлэлийн бууралтыг мэдэгдэхүйц бууруулж чадаагүйг илрүүлсэн. Төлбөрийн чадваргүй байгууллагуудад хөрвөх чадварын дэмжлэг үзүүлэх нь банкны зээлийн хөшүүргийг маш ихээр тогтворгүй болгож хямралыг уртасгаж, эрүүл зохицуулалтыг хойшлуулж, нэмэлт бүтээгдэхүүний алдагдал бий болгож байсан бололтой.

Хямралын дунд үед ч гэсэн шууд дарамтыг шийдвэрлэхийн тулд урт хугацааны зорилгоо золиослох нь үр ашиггүй юм. Хямралын үр дүнтэй менежмент нь triage /ангилахаас/ эхэлдэг. Төлбөрийн чадваргүй байгууллагуудыг илрүүлж, эрсдэл даах чадварыг нь хянах ёстой.

Дампуурах гэж байгууллагуудад хөрвөх чадварын нээлттэй дэмжлэг үзүүлж, зээлдүүлэгч нарт нь бүрэн баталгаа гаргах нь шинэ бөгөөд илүү хүчтэй хямралыг бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг.

Түр зуурын яаралтай арга хэмжээ гэж үзэж гаргасан хадгаламжийн даатгал нь төсвийн өндөр зардалд хүргэдэг. Эдгээр зардлыг гаргах нь бодит эдийн засагт банк санхүүгийн хямралаас хурдан гарах эсвэл үйлдвэрлэлийн алдагдал багатай байх магадлал бага юм.



2.5. ДҮГНЭЛТ БОЛОН БОДЛОГЫН САНАЛ

Эмпирик судалгаа нь хоёр үндсэн асуултад хариулт хайдаг.

- Зарим улс орнууд хадгаламжийн даатгалаас зайлсхийх нь зөв үү?
- Хадгаламж–даатгалын загвар нь ил тод байдал, урьдчилан сэргийлэх, хариуцлагын талаарх соёлын буюу улс орон хоорондын ялгааг хэрхэн зохицуулах ёстой вэ?

1/Улс орон бүр хадгаламжийн даатгалд хамрагдах ёстой юу?

Хадгаламжийн даатгалын талаарх улс орон даяар хийсэн эмпирик судалгаанууд нь байгууллагын хувьд сул орчинд хадгаламжийн даатгалын зохицуулалт муу хийгдсэн нь ирээдүйн банк санхүүгийн хямралын магадлалыг нэмэгдүүлэх хандлагатай байдаг гэсэн таамаглалыг баттай баталдаг байна.

Судлаачид дэлхийн янз бүрийн улс орнуудад ажиглагдаж буй банк санхүүгийн хямралын тохиолдлыг харьцуулж үзэхэд хадгаламжийн даатгалын тогтолцоо муу боловсруулсан орнууд илүү их хямралд өртдөг нь тогтоогджээ. Түүнчлэн гэрээ байгуулах орчин сул орнуудад эдгээр хямралын давтамж улам гүнзгийрдэг. Судлаачид өөр өөр улс орнуудын банк санхүүгийн салбарын хүүгийн зардал болон хадгаламжийн өсөлтөд анхаарлаа төвлөрүүлэх үед хувийн болон засгийн газрын хяналт муу зохион байгуулалттай системд хадгаламжийн тогтолцоо эрс сул байгааг харуулж байна. Үүний хамгийн үнэмшилтэй тайлбар нь засгийн газрууд хадгаламжийн даатгалын

тодорхой схемийг хэрэгжүүлэхийн өмнө ил тод байдал, саад тогтор/ урьдчилан сэргийлэх, хариуцлагагүй байдлын сул талуудыг арилгах ёстой. Санхүүгийн байгууллагуудын зохицуулалт, хяналтыг сайжруулах, өмчийн эрхийг хамгаалж, гэрээний хэрэгжилтийг бэхжүүлэх хуулийн тогтолцоог шинэчлэх, нягтлан бодох бүртгэл, мэдээллийг ил тод болгох дүрмийг боловсронгуй болгож, үнэн зөв мэдээллийг зах зээлд цаг алдалгүй хүргэх нь урамшууллын бүтцийг сайжруулж, илүү эрсдэл хүлээхийг хязгаарласан байгууллагын шинэчлэлийн төрлүүдийн жишээ юм.

Гэрээ байгуулах нөхцөл муутай нөхцөлд даатгалаас үүдэлтэй хувийн хяналтыг бууруулах нь албан ёсны хяналтын мөн чанарын дутагдлаас болж эрчимжиж байгаа тул эрсдэлийн шилжилт нэмэгддэг. Банк санхүүгийн хяналт шалгалтын сул талыг ашиглан даатгалд хамрагдсан хадгаламж гаргаж, түүгээрээ сөрөг эрсдэл ихтэй төслүүдийг санхүүжүүлэхийг эрмэлздэг. Тооцоонд ороогүй баталгааны үнэ цэн нэмэгдэж байгаа нь засгийн газрын төсвийн чадавхыг зэрэг шавхах тусам тухайн улсын санхүүгийн тогтолцооны эмзэг байдал нэмэгддэг. Хэдийгээр төрийн албан тушаалтнууд хадгаламжийн даатгал нь санхүүгийн хүчирхэг тогтолцоог бий болгоход тусална гэдэг ч гэрээ байгуулах орчин үүнийг дэмжихгүй бол үүнийг хийж чадахгүйд хүрнэ.

Хяналт муу байгаа нь санхүүгийн байгууллагуудыг эерэг хазайлттай боловч өнөөгийн үнэ цэн нь сөрөг төслүүдэд зээл олгоход хүргэдэг. Ийм зээл нь санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг алдагдуулж, эдийн засгийн бодит

капиталыг устгаж, санхүүгийн хөгжлийг саатуулдаг. Улс хоорондын эмпирик судалгаа нь тухайн улсын санхүүгийн гэрээ байгуулах орчны ач холбогдлыг харьцуулдаг. Аливаа улс хадгаламжийн даатгалыг үр ашигтайгаар дэмжихэд урьдчилсан бэлтгэлээ хангах ёстой. Хадгаламжийн даатгалыг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй засгийн газрууд гэрээ байгуулах боломжтой хүчтэй орчин нь урьдчилсан нөхцөл гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Үнэн хэрэгтээ, хэрэв тухайн улсын гэрээ байгуулах орчин нь ил тод, хариуцлагатай байсан ч урьдчилан сэргийлэх чадваргүй бол хадгаламжийн даатгалын тогтолцоо нь сайнаас илүү их хор хөнөөл учруулах болно. Сул байгууллагатай орнуудын хувьд хадгаламжийн даатгалд хамрагдах нь санхүүгийн хөгжилд маш богино хугацаанд л тусалж магадгүй юм. Удаан хугацааны туршид энэ нь зах зээлийн сахилга бат/дэг журмыг алдагдуулж, ёс суртахууны эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн эмзэг байдлыг улам хурцатгах магадлалтай. Сүүлийн үед хадгаламжийн даатгалд хамрагдаж байгаа олон улс орон гэрээ байгуулах орчин муутай байгаа тул бодлогын энэхүү дүгнэлт нь маш их хамааралтай юм.

2/ Хадгаламжийн даатгалыг хэрхэн төлөвлөх ёстой вэ?

Улс хоорондын харьцуулсан эмпирик судалгаа нь хадгаламжийн даатгалын тодорхой схемийг цогцлоосон эсвэл хэрэгжүүлэх шатандаа байгаа улс орнуудад сургамж болдог. Тааламжтай нөхцөлд ч гэсэн хадгаламж эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд хадгаламжийн даатгал ашиглах нь зах зээлийн сахилга батыг бууруулах замаар санхүүгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байдаг. Гэсэн хэдий ч

зохих загварчлалын боломжууд нь нийгмийн зардлыг багасгахын тулд эдгээр нөлөөг хянаж, нөхөж чаддаг. Эмпирик судалгаанууд дараах шинж чанарууд нь зах зээлийн сахилга батыг сайжруулж, ёс суртахууны эрсдэлийг бууруулдаг гэсэн таамаглалыг баталдаг.

- Бүртгэлд баттай хамрагдах хамгийн бага хамрах хүрээ
- Нарийн хамрах хүрээ (жишээлбэл, банк хоорондын депозитийг оруулахгүй)
- Хамтарсан даатгал (мөн хоёрдогч өглөг болон өргөтгөсөн хувьцаа эзэмшигчийн хариуцлага гэх мэт хувийн алдагдал хуваалцах сонголтод зохицуулалтууд)
- Албан ёсны гишүүнчлэл
- Ex-post funding
- Тэсэжүлдсэн санхүүгийн байгууллагуудын алдагдлыг нөхөхөд чиглүүлэх (Татвар төлөгчид үнэхээр системийн хямралын үед санхүүгийн байгууллагуудад туслахыг хүсэж болно)
- Төрийн болон хувийн хэвшлийн хамтарсан менежмент

Даатгалын хамрах хүрээг найдвартай хязгаарлаж, заавал гишүүнээр элсэхийг шаардахын давуу тал нь илэрхий бөгөөд огт маргаантай зүйл биш юм. Даатгалын хамрах хүрээг байж болох хэмжээгээр хязгаарлах нь томоохон хадгаламж эзэмшигчид, хоёрдогч өглөг эзэмшигчид эсвэл бусад санхүүгийн байгууллагууд гэсэн тодорхой бүлэг хувь хүмүүсийн хөрөнгө нь зайлшгүй эрсдэлд ордог гэдгийг ойлгосны үндсэн дээр хийгддэг. Энэхүү байдал нь тэдэнд санхүүгийн байгууллагууд болон хамгаалалтын сүлжээний менежерүүдийн зан үйлийг хянах хөшүүрэг болж өгдөг. Албан ёсны гишүүнчлэл нь даатгалын сангийн хэмжээг нэмэгдүүлж, эрсдэл багатай байгууллагуудыг



системээс шилэгдэхээс сэргийлдэг. Энэ нь эрсдэл багатай, сайн менежменттэй санхүүгийн байгууллагууд бусад амжилттай яваа өрсөлдөгчөө хянах, хянахад эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад туслах боломж олгодог гэсэн үг юм.

Даатгалын загварчлал, менежментэд ex-post funding санхүүжилт, хувийн оролцоог илүүд үзэх нь гарцаагүй илүү хэцүү хамтарсан борлуулалт шаарддаг. Нэг талаас, хуримтлагдсан хөрвөх чадвартай нөөцийн санд нэн даруй нэвтрэх боломжгүй байх нь эрх баригчдыг төлбөрийн чадваргүй байгууллагуудтай цаг тухайд нь харьцах боломжийг хойшлуулах аюул заналхийлж байна. Гэвч байгууллагын сул орчинд хадгаламж-даатгалын нөөцийн эдийн засгийн цэвэр үнэ цэнийг сул дорой, төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгчид эдгээр нөөц рүү далд хэлбэрээр шилждэг далд өр төлбөрийг тооцолгүйгээр хэтрүүлэн үнэлдэг болохыг улс орнуудын харьцуулсан тооцоо харуулж байна. Үнэн хэрэгтээ хэт давуулж үнэлэгдсэн сан нь санхүүгийн байгууллагын төлбөрийн чадваргүй байдлын нотолгоог үл тоомсорлож, тэргүүлэгч хадгаламж эзэмшигчид болон өрсөлдөгч байгууллагуудын ёс суртахууны аюулыг улам эрчимжүүлэх хандлагатай байдаг.

Санхүүжилтгүй орхисон ч гэсэн тухайн улсын хадгаламжийн даатгалын тогтолцоог өөрийн улсын сан хөмрөгөөс эсвэл гаднын найдвартай даатгагчидтай байгуулсан давхар даатгалын гэрээгээр зээлийн шугам хэлбэрээр шууд ашиглах боломжтой хэвээр байна. Гэрээ байгуулахад сул зохицуулалттай нөхцөлд, мөнгөн сан хөмрөг эсвэл гадаадын давхар даатгагч зэрэг шийдвэр гаргах нэмэлт

нэгжүүдэд бизнес загварчлал, удирдлагын шийдвэрт хяналт тавих ач холбогдолтой хариуцлагыг хуваарилах нь үр ашигтай байдаг. Хадгаламж-даатгалын цэвэр алдагдлыг өмнөх эсвэл дараа нь санхүүжүүлсэн эсэхээс үл хамааран алдагдлыг нөхөх хөрөнгө үндсэндээ тэсэж үлдсэн санхүүгийн байгууллагуудаас гарна гэдгийг тодорхой болгох ёстой. Эс тэгвэл засгийн газрын нөөц нь зах зээлийн сахилга батыг бууруулж, хэврэг байдлыг нэмэгдүүлж болзошгүй гэсэн дарамт байдаг.

Хадгаламжийн даатгалын зохицуулалтыг зохицуулахад хувийн талуудыг татан оролцуулах нь ёс суртахууны эрсдэл, эмзэг байдлыг бууруулдаг болохыг эмпирик судалгаа харуулдаг. Хувийн менежерүүд үүргээсээ зайлсхийж, мөнгө завших боломжтой байдаг ч аливаа хувийн схемд оролцогч талууд удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хяналтын байгууллагад хандах хүчтэй хөшүүрэгтэй байдаг.

Эцэст нь дүгнэхэд, энд хураангуйлсан судалгааны ач холбогдол нь хадгаламжийн даатгалд хамрагдах байгууллагын урьдчилсан нөхцөлийг тодорхойлох, системийн загварчлалыг зөв болгохын тулд хамтын хүчин чармайлт гаргахад анхаарлаа хандуулах нь чухал болохыг онцолж байна. Хадгаламжийн даатгал нь хааяагүй алдаатай эсвэл ил тод / explicit/ системтэй бүх улс орнууд анхны боломжоороо схемээсээ татгалзах ёстой гэж ямар ч судалгааны үр дүн харуулахгүй байна. Гэрээ байгуулах орчин сайн хөгжсөн орнуудад системийн асуудал ховор тохиолддог бөгөөд загварчлалын онцлог, хямралууд хоорондын хамаарал сул, ихэвчлэн ач холбогдолгүй байдаг.

ЭХ СУРВАЛЖ

1. <https://ncua.gov/>
2. <https://www.cdic.ca/>
3. <https://www.cudgcnl.com/>
4. <https://www.fscs.org.uk/>
5. European central bank, "Occasional paper series: Completing the banking union with a European deposit insurance scheme", No 208/April 2018
6. Allen, F., Carletti, E., Goldstein, I. and Leonello, A. (2017), "Government guarantees and financial stability", ECB Working Paper Series No 2032, February
7. Anginer, D., Demirguc-Kunt, A. and Zhu, M. (2014), "How does deposit insurance affect bank risk? Evidence from the recent crisis", Journal of Banking & Finance, Vol. 48
8. Bank of England (2016), "The Bank of England's approach to setting a minimum requirement for own funds and eligible liabilities (MREL)", Responses to Consultation and Statement of Policy, November
9. World bank, "DEPOSIT INSURANCE AROUND THE GLOBE: WHERE DOES IT WORK?"
10. IMF, "Stabilization programs in Developing Countries: A Formal Framework"
11. World bank Group, "Note on Stabilization /wealth funds: a case study analysis", 2018
12. FRC bulletin data
13. IMF, "Good practices for Deposit Insurance"
14. <https://assets.gov.ie/40996/dccc8eab3ea74c7ab809e067b5752fb8.pdf>
15. <https://creditunionsofjamaica.com/member-community-faqs/>
16. <https://www.creditunion.ie/>
17. www.depositguarantee.ie
18. <https://assets.gov.ie/40996/dccc8eab3ea74c7ab809e067b5752fb8.pdf>
19. <https://www.abcul.coop/credit-unions/about-credit-unions>
20. <https://www.woccu.org/>
21. Бусад